



**МОНГОЛБАНК**

**МОНГОЛБАНКНЫ ЗАХИРГААНЫ  
ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ**

**ЭМХЭТГЭЛ II**

Улаанбаатар хот  
2019 он



Улсын  
бүртгэлийн  
дугаар

## ГАРЧИГ

Хуудасны  
дугаар

<b>4338</b>	Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам	<b>5</b>
<b>4338</b>	Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам	<b>30</b>
<b>4338</b>	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам	<b>36</b>
<b>4388</b>	Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам	<b>59</b>
<b>4417</b>	Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам	<b>93</b>

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 04 сарын 10-ны өдрийн 4338 дугаарт бүртгэв.*

## **МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А-82

Улаанбаатар хот

### **Журам, заавар батлах тухай**

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 36 дугаар зүйлийн 36.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам”-ыг нэгдүгээр хавсралт, “Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг хоёрдугаар хавсралт, “Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг гуравдугаар хавсралт, “Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан шийдвэрлэх заавар”-ыг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаал, заавар гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А-190 дугаар, 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А-152 дугаар, 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А-152 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т үүрэг болгосугай.

**МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАЯРТСАЙХАН**

*Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А-82 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

## **БАНК БАЙГУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Монголбанкнаас Банкны тухай хуулийн 3 дугаар бүлгийг үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл (цаашид “банк байгуулах хүсэлт” гэх) хүлээн авах, банк байгуулах хүсэлт хуулиар тогтоосон шаардлага, нөхцөлийг хангасан эсэхийг судалж хянах, банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгохоос татгалзах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам нь Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн байна.

1.3. Банк байгуулах тухай Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол банк байгуулах тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд энэ журмын 6 дугаар бүлгийг үндэслэн хүчингүй болгоно.

1.4. Банк байгуулах тухай Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол банк байгуулах тусгай зөвшөөрлийг энэхүү журмын 1.8-д заасан банкны үйл ажиллагааны энгийн зөвшөөрлийн хамт олгоно.

1.5. Банкны нэгж байгуулах, банкны эрхлэх үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл олгох, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, худалдах, шилжүүлэхэд зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг хязгаарлах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Монголбанкнаас баталсан бусад журмаар зохицуулна.

1.6. Монголбанк нь Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг банкны эрхлэх үйл ажиллагаа, банкны хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон бусад үзүүлэлтүүдэд хамруулан тусгайлан тогтоож болно.

1.7 “Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж Банкны тухай хуулийн 3.1.12-т заасан хувьцаа эзэмшигчийг хэлнэ.

1.8. “Банкны үйл ажиллагааны энгийн зөвшөөрөл” гэж:

1.8.1.1. Банкны тухай хуулийн 6.1.2-т заасан зээл;

1.8.1.2. Банкны тухай хуулийн 6.1.3-т заасан төлбөр тооцооны үйлчилгээ (зөвхөн бэлнээр болон банк хоорондын захар хийх бэлэн бус төлбөр тооцоо);

1.8.1.3 Банкны тухай хуулийн 6.1.5-д заасан гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах;

1.8.1.4. Банкны тухай хуулийн 6.1.7-д заасан үнэт зүйл хадгалах;

1.8.1.5. Банкны тухай хуулийн 6.1.8-д заасан гадаад төлбөр тооцоо хийх (зөвхөн конверсийн гүйлгээ, гадаадын банкнаас зээл авах, харилцагчийн захиалгаар валютын арилжааны хэлцэл хийх, ностро, лоро харилцах, зөвхөн ханшийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор хийгдсэн гадаад валютын своп, спот хэлцэл хийх);

1.8.1.6. Банкны тухай хуулийн 6.1.10-г заасан санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг тус тус эрхлэх зөвшөөрлийг хэлнэ.

1.9. “Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл гэж энэ журмын 1.8-д зааснаас бусад Банкны тухай хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хэлнэ.

1.10. Гадаадын банк буюу гадаад улсад байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагын охин компани болох банк нь Банкны тухай хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулна.

## **ХОЁР. Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага**

2.1. Монголбанк нь банк байгуулах тусгай зөвшөөрлийг Банкны тухай хуульд заасан банк байгуулагч, банкны хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгө, банкны удирдлагатай холбоотой дараах шаардлагыг хангасан тохиолдолд олгоно. Үүнд:

2.1.1. Банк байгуулагч, банкны хувьцаа эзэмшигч нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1.1. Банкны тухай хуулийн 18-19, 22, 36, 36<sup>1</sup> дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан;

2.1.1.2. Байгуулж буй банк нь халхавч банк биш байх;

2.1.1.3. Банк байгуулагч нь хуулийн этгээд байх тохиолдолд банк байгуулах хүсэлт гаргасан өдрөөс өмнөх 3 (гурав)-аас дээш жилийн хугацаанд тогтвортой, үр ашигтай үйл ажиллагаа эрхэлсэн;

2.1.1.4. Банк байгуулагч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

2.1.1.5. Банк байгуулагч нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

2.1.2. Банк байгуулагч нь энэхүү журмын 2.1.1, 2.2-д заасан шаардлагыг банкны хувьцаа эзэмшиж байх нийт хугацаанд хангах үүрэгтэй.

2.1.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.3.1. Банкинд хувь нийлүүлсэн хөрөнгө нь хууль ёсны үйл ажиллагааны орлого байх;

2.1.3.2. Банкинд хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн болон бусад өр үүсгэх бусад хэлцлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй байх.

2.1.4. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.4.1. Банкны тухай хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангасан;

2.1.4.2. Банк байгуулах хүсэлт гаргасан өдрөөс өмнөх 5 (таван) жилийн хугацаанд аливаа хуулийн этгээдийн татан буугдах, дампууралд буруутай болохыг шүүхээс тогтоож байгаагүй, ийм нөхцөл байдлыг үүсгээгүй, бүрдүүлээгүй байх;

2.1.4.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй.

2.1.5. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.5.1. Банкны тухай хуулийн 33.3-т заасан шаардлагыг хангасан;

2.1.5.2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй.

2.1.6. Банкны гүйцэтгэх удирдлага нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.6.1. Банкны тухай хуулийн 34.2-т заасан шаардлагыг хангасан;

2.1.6.2. Банк байгуулах хүсэлт гаргасан өдрөөс өмнөх 5 (таван) жилийн хугацаанд аливаа хуулийн этгээдийн татан буугдалт, дампууралд буруутай гэдэг нь шүүхээр тогтоогдож байгаагүй;

2.1.6.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

2.1.7. Гадаадын банк байгуулах этгээд нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.7.1. Энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан шаардлагыг хангасан;

2.1.7.2. Банк байгуулах хүсэлт гаргасан өдрөөс өмнөх 3 (гурван) жилийн хугацаанд активын хэмжээгээр “Bankers Almanac”-аас гаргасан жагсаалтын эхний 100-д багтсан байх;

2.1.7.3. Олонулсын зэрэглэл тогтоогч Standard & Poor’s, Fitch байгууллагаас авсан урт хугацааны үнэлгээ нь А-аас доошгүй, Moody’s байгууллагаас авсан урт хугацааны үнэлгээ нь А2-оос доошгүй байх;

2.1.7.4. Тухайн этгээд бүртгэгдсэн улсаас бусад оронд банк, түүний нэгж байгуулж, үйл ажиллагаагаа 3 (гурав)-аас доошгүй жил тогтвортой явуулж байгаа;

2.1.7.5. Тухайн этгээд бүртгэгдсэн орон болон бусад орны банкны тухай хууль, тогтоомж болон түүнтэй холбоотой хууль, дүрмийг зөрчиж байгаагүй, сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд энэ зөрчлөөс үүдэн банк, түүний нэгжийг

байгуулах зөвшөөрөл нь хүчингүй болж, төлбөрийн чадварын болон санхүүгийн хүндрэлд орж байгаагүй;

2.1.7.6. Төлөөлөгчийн газар нь Монгол Улсад 1 (нэг)-ээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхэлсэн байх.

2.2. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд, банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, банкны гүйцэтгэх удирдлагад томилогдох этгээд нь дараах шаардлагыг хангасан эсэх тухай Монголбанк дүгнэлт гаргана. Үүнд:

2.2.1. Тухайн этгээдтэй холбоотойгоор ямар нэгэн сахилгын арга хэмжээ авч байсан, эсхүл гэмт хэргийн шинж чанартай мөрдөн байцаах ажиллагаа явагдаж байгаа эсэх, эсхүл ийм үйл ажиллагаанд хүргэж болзошгүй байдалд байгаа эсэх;

2.2.2. Тухайн этгээд нь өмнө нь томилогдож байсан итгэлцэл, фидуци болон эдгээртэй адилтгах бусад төсөөтэй харилцааг тодорхой шалтгааны улмаас шаардсаны дагуу дуусгавар болгож байсан эсэх;

2.2.3. Тухайн этгээдийг шаардлага хангаагүй шалтгаанаар захирал, удирдах албан тушаалаас нь чөлөөлж байсан эсэх;

2.2.4. Тухайн этгээд өмнө нь зохицуулагч байгууллагатай хамтарч ажилласан эсэх, хууль эрх зүй, зохицуулалтын болон мэргэжлийн стандарт, шаардлагыг дагаж мөрдөхөд бэлэн эсэх;

2.2.5. Тухайн этгээд Монголбанкны шаардлага, түүнтэй адилтгах стандарт эсхүл зохицуулагч байгууллага, мэргэжлийн байгууллага эсхүл төрийн байгууллага, агентлагуудын шаардлагуудыг зөрчиж байсан эсэх;

2.2.6. Тухайн этгээд ажил үүрэг, эрх мэдэл, ажил үүргээ хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх;

2.2.7. Тухайн этгээдийг Монголбанк эсхүл мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар хувийн эсхүл мэргэжлийн ёс зүйгүй байдлыг тогтоож үйл ажиллагааг нь зогсоож байсан эсэх.

### **ГУРАВ. Банк байгуулахад бүрдүүлэх баримт бичиг**

3.1. Банк байгуулагч нь банк байгуулах хүсэлтээ энэ журмын Хавсралт 1-ийн дагуу гаргаж, энэ журмын 3.2-3.8-д заасан баримт бичгийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ.

3.2. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээд нь энэхүү журмын Хавсралт 2-ын дагуу гаргасан Банк байгуулагч, хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтыг доорх баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

3.2.1. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээд нь хоёр болон түүнээс дээш бол Компанийн тухай хуулийн 13.3-т заасны дагуу банк байгуулах гэрээ (эх хувь, нотариатаар баталгаажуулсан хувь), нэг этгээд бол банк байгуулах шийдвэр;



3.2.2. Байгуулах банк нь хоёр болон түүнээс дээш банк байгуулагч, хувьцаа эзэмшигчтэй бол хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, нэг банк байгуулагч, хувьцаа эзэмшигчтэй бол тухайн этгээдийн шийдвэр. Энэ тогтоол, шийдвэрт дараах зүйлсийг тусгана:

3.2.2.1. Хувьцааны захиалга авах, шинээр хувьцаа гаргах замаар банк байгуулах бол зарлах болон гаргах хувьцааны тоо, ширхгийн үнэ, хэмжээ, тэдгээрээс банк байгуулах этгээдийн худалдан авах тоо, ширхгийн үнэ, хэмжээ, худалдан авах хугацаа, төлбөр хийх хэлбэр;

3.2.2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилсон шийдвэр;

3.2.2.3. Хууль тогтоомжид заасан бусад шаардлагатай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн шийдвэр;

3.2.3. Энэ журмын Хавсралт 6-д заасан зааврын дагуу боловсруулсан банкны дүрэм;

3.2.4. Энэ журмын Хавсралт 7-д заасан зааврын дагуу боловсруулсан банк байгуулах эдийн засгийн үндэслэл;

3.2.5. Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас;

3.2.6. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээд нь шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

3.2.7. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээдийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлоход шаардлагатай гэж Монголбанкнаас үзсэн мэдээлэл бүхий баримт бичиг;

3.2.8. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч хүртэлх хэлхээ холбоог тогтооход шаардлагатай гэж Монголбанкнаас үзсэн мэдээлэл бүхий баримт бичиг;

3.2.9. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээд нь гадаадын харьяалалтай хуулийн этгээд, иргэн бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, иргэн нь дараах баримт бичгийг нэмж ирүүлнэ. Үүнд:

3.2.9.1. Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг;

3.2.9.2. Харьяалах улс, оронд гааль, татварын өртэй эсэхийг харуулсан баримт бичиг;

3.2.9.3. Харьяалах улс, оронд ял шийтгэлгүй болохыг нотлох баримт бичиг;

3.2.9.4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг.

3.2.10. Банк байгуулах хүсэлт, баримт бичиг нь хууль тогтоомжид

нийцсэн, шаардлага хангасан эсэх тухай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээс гаргасан хуулийн дүгнэлт ирүүлэхийг Монголбанк шаардах эрхтэй.

3.3. Банкинд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, гарал үүслийг нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:

3.3.1. Монголбанкнаас баталсан банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээнээс доошгүй хөрөнгийг Монголбанк дахь тусгай дансанд байршуулсан тухай баримт;

3.3.2. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээд, тэдгээрийн холбогдох этгээд нь хуулийн этгээд бол үйл ажиллагааны сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, иргэн бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны цалин, орлогын тодорхойлолт, харилцагч банкны дансны хуулга;

3.3.3. Банк байгуулагч болон хувьцаа эзэмшигч болох этгээд, тэдгээрийн холбогдох этгээд нь хуулийн этгээд бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан”, иргэн бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны “Хувь хүний орлогын албан татварын тайлан”;

3.3.4. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээд, тэдгээрийн холбогдох этгээд нь гааль, татварын өртэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

3.3.5. Хувьцаа эзэмшигч нь гэрээнд заасан хугацааны дагуу хувьцаа худалдаж авах үүргээ биелүүлснийг нотлох төлбөрийн баримт;

3.3.6. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүслийг нотлоход шаардлагатай гэж Монголбанк үзсэн бусад баримт бичиг.

3.4. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагын албан тушаалд томилогдох этгээдийн энэ журмын Хавсралт 3-ын дагуу гаргасан тодорхойлолт болон холбогдох баримт бичиг. Үүнд:

3.4.1. Мэргэжлээрээ болон банк, санхүүгийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан ажлын туршлагатайг нотлох баримт;

3.4.2. Боловсролын гэрчилгээ, дипломыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.4.3. Шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

3.4.4. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагын албан тушаалд томилогдох этгээд нь гадаадын харьяалалтай иргэн бол энэ журмын 3.4.1-3.4.3-г зааснаас гадна доорх баримт бичгийг нэмж ирүүлнэ. Үүнд:

3.4.4.1. Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй эсэх, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй болохыг нотлох баримт бичиг;

3.4.4.2. Харьяалах улс оронд аливаа ял шийтгэл хүлээгээгүй болохыг нотлох баримт бичиг;

3.4.4.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг.

3.5. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд, банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, банкны гүйцэтгэх удирдлагад томилогдох этгээд нь энэхүү журмын 2.2-т заасан шаардлагыг хангаж буй эсэх тайлбараа Хавсралт 4-ийн дагуу гаргаж ирүүлнэ.

3.6. Ажлын байр, техник тоног төхөөрөмж, програм хангамж, найдвартай аюулгүй ажиллагааны шаардлага хангасан нөөц төв, нууцлал, харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх дараах баримт бичиг. Үүнд:

3.6.1. Банк байрших байр, барилгыг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, түрээсэлж байгаа бол түрээсийн гэрээ;

3.6.2. Ажлын байр нь мөнгөн хөрөнгийн найдвартай байдлыг хангасан эсэхийг нотолсон баримт;

3.6.3. Харуул хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээ, эсвэл харуул хамгаалалтын албатай болохыг нотлох баримт;

3.6.4. Програм хангамж нийлүүлэх, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэх байгууллагатай хамтран ажиллах гэрээ;

3.6.5. Энэ журмын Хавсралт 5-ын дагуу гаргасан Техник, тоног төхөөрөмж, ажлын байрны тодорхойлолт.

3.7. Гадаадын банк байгуулах этгээд нь энэхүү журмын 3.1-3.6-д зааснаас гадна дараах баримт бичгийг нэмж ирүүлнэ. Үүнд:

3.7.1. Банкны тухай хуулийн 22.1-д заасан баримт бичиг;

3.7.2. Гадаадын банк байгуулагчийн харьяалагдах улсын банк, санхүүгийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас Монголбанкт хамтран банкны нэгдсэн хяналт шалгалт хийх зорилгоор Хамтын ажиллагааны гэрээ эсхүл Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан хамтран ажиллах тухай албан бичиг;

3.7.3. Гадаадын банк байгуулагчийн харьяалагдах улсын банк, санхүүгийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийн биелэлтийг сүүлийн 36 (гучин зургаан) сарын байдлаар хангаж буйг нотлох гадаадын банк байгуулагчийн харьяалагдах улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тодорхойлолт;

3.7.4. Гадаадын банк байгуулагчийн харьяалагдах улсаас бусад улсад банк, түүний нэгж байгуулж, үйл ажиллагаагаа 3 (гурав)-аас доошгүй жил тогтвортой явуулж байгааг нотлох гадаадын банк байгуулах этгээдийн харьяалагдах улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тодорхойлолт;

3.7.5. Гадаадын банк байгуулагчийн харьяалагдах улсын болон бусад холбогдох улс орны Банкны тухай хууль, журмыг зөрчиж байгаагүй, сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд энэ төрлийн зөрчлөөс үүдэн банк, түүний нэгжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчингүй болж байгаагүйг нотлох гадаадын банк байгуулах этгээдийн харьяалагдах улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тодорхойлолт;

3.7.6. Гадаадын банк байгуулагчийн сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд төлбөрийн чадварын болон санхүүгийн хүндрэлд орж байгаагүйг нотлох гадаадын банк байгуулагчийн харьяалагдах улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тодорхойлолт;

3.7.7. Гадаадын банк байгуулагч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүйг нотлох гадаадын банк байгуулагчийн харьяалагдах улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тодорхойлолт.

3.8. Банк байгуулагч нь гадаад улсын харьяалалтай хуулийн этгээд, иргэн байх тохиолдолд энэ журмын 3.1-3.7-д заасан банк байгуулах хүсэлт, баримт бичгийг тухайн улсын хэлээр үйлдэж, нотариатаар баталгаажуулсан монгол болон англи хэлний албан орчуулгын хамт Монголбанкинд ирүүлнэ.

3.9. Монголбанк нь энэ журамд заасан баримт бичгээс гадна нэмэлт материал шаардах эрхтэй бөгөөд банк байгуулагч, банкны хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн холбогдох этгээдтэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авна.

### **ДӨРӨВ. Банк байгуулахад бүрдүүлэх баримт бичгийг хянах, зөвшөөрөл олгох**

4.1. Монголбанк нь Банкны тухай хууль тогтоомжийг үндэслэн банк байгуулах хүсэлтийг холбогдох зааврын дагуу хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгана.

4.2. Монголбанк банк байгуулах тусгай зөвшөөрлийг олгох эсэх шийдвэрийг энэ журмын 3 дугаар бүлэгт заасан банк байгуулах хүсэлт, холбогдох баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор гаргаж, энэ тухай банк байгуулах хүсэлт гаргагчид ажлын 3 (гурван) хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

4.3. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт баримт бичиг шаардлагатай тохиолдолд банк байгуулах хүсэлт гаргагчид энэ талаар албан бичгээр мэдэгдэнэ.

4.4. Баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрийг банк байгуулах хүсэлт хүлээн авсан өдөрт тооцно.

4.5. Банк үүсгэн байгуулах тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд Монголбанкны банкны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар

нь хууль, эрх зүйн асуудал эрхэлсэн газар, төлбөр тооцоо, бүртгэлийн асуудал эрхэлсэн газар, мэдээлэл технологийн асуудал эрхэлсэн газрын тус тусын дүгнэлт, саналыг нэгтгэж, банк үүсгэн байгуулах зөвшөөрөл олгох асуудлыг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

4.6. Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамж, Монголбанкны ажил үйлчилгээний шимтгэлийг төлөхийг банк байгуулах хүсэлт гаргагчаас шаардаж, улсын тэмдэгтийн хураамж, Монголбанкны ажил үйлчилгээний шимтгэл төлсөн баримтыг банк байгуулах хүсэлт бүхий баримт бичигт нэмж хавсаргана.

4.7. Банк байгуулагч нь Банкны тухай хуульд зааж, энэ журамд тодорхойлсон шаардлагыг хангасан, банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл байхгүй бол банк байгуулах хүсэлт гаргагчид банк байгуулах тусгай зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар олгоно.

### **ТАВ. Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл**

5.1. Монголбанк нь дараах үндэслэлээр банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

5.1.1. Энэ журмын 2 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангаагүй;

5.1.2. Банкинд хувь нийлүүлэх хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг хангалтгүй буюу банк байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого болох нь нотлогдоогүй;

5.1.3. Банкинд хувь нийлүүлэх хөрөнгийг зээл болон зээлтэй адилтган тооцох үүрэг, бусад өр үүсгэх хэлцлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн гэдгийг Монголбанк үзсэн бөгөөд банк байгуулах хүсэлт гаргагч үүнийг эсрэгээр нь нотолж чадаагүй;

5.1.4. Банкны дүрэм нь хууль тогтоомжтой зөрчилдсөн;

5.1.5. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагын ажлын туршлага, боловсрол, ур чадвар, ёс зүй, бизнесийн нэр хүнд шаардлага хангахгүй гэж Монголбанк үзсэн;

5.1.6. Тухайн банкийг байгуулснаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдал болон санхүү, банкны салбарын тогтолцооны тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй гэж Монголбанк үзсэн;

5.1.7. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан баримт бичгийг бүрэн гүйцэд ирүүлээгүй;

5.1.8. Монголбанкнаас шаардсан мэдээлэл болон тухайн мэдээллийн нотлох баримтыг ирүүлээгүй, нотлох баримтын үндэслэл, тайлбар нь тодорхойгүй, тэдгээрийг тодорхойлох боломжгүй;

5.1.9. Бүрдэл дутуу материалыг буцааснаас хойш 60 (жар) хоногийн дотор холбогдох баримт бичгийг ирүүлээгүй;

5.2. Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тухай банк байгуулах хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

5.3. Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Монголбанк нь тухайн банк байгуулагч, хувьцаа эзэмшигчдээс банк байгуулах хүсэлтийг 1 (нэг) жилийн дотор дахин хүлээн авахгүй.

### **ЗУРГАА. Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

6.1. Монголбанк дараах үндэслэлээр банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргана. Үүнд:

6.1.1. Банкны тухай хуулийн 27.1-д заасан үндэслэл бүрдсэн;

6.1.2. Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар банкныг татан буулгах тухай шийдвэр гарсан.

6.2. Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн этгээд зөвшөөрлийн гэрчилгээг ажлын 5 (тав) хоногийн дотор Монголбанкинд хүргүүлнэ.

### **ДОЛОО. Хяналт, хариуцлага**

7.1. Энэ журмын 6.1-д заасан үндэслэлээр банкны үйл ажиллагааг зогсоож, арга хэмжээ авахтай холбогдон гарсан зардлыг Монголбанк хариуцахгүй.

### **НАЙМ. Бусад**

8.1. Банк байгуулагдсанаас хойш Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага өөрчлөгдөх тохиолдолд тухайн албан тушаалд шинээр томилогдох этгээд нь Банкны тухай хууль болон энэ журмын 2.1.4-2.1.6, 2.2-д заасан шаардлагыг хангасан байна.

..... **БАНК БАЙГУУЛАХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТ**

<b>1. БАЙГУУЛАХ БАНКНЫ НЭР</b>				
<b>2. БАЙГУУЛАХ БАНКНЫ ХАЯГ</b>				
<b>3. БАЙГУУЛАХ БАНКНЫ ТӨРӨЛ</b>				
Байгуулагдах хэлбэр	ХХК			<input type="checkbox"/>
	ХК			<input type="checkbox"/>
Хөрөнгө оруулалтын төрөл	Дотоодын банк			<input type="checkbox"/>
	Гадаадын банк			<input type="checkbox"/>
	Гадаадын хөрөнгө оруулалттай банк			<input type="checkbox"/>
<b>4. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ</b>				
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)				
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ (төгрөгөөр)				
Хувьцааны тоо ширхэг				
<b>5. БАНК БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД</b>				
	Оноосон нэр (овог, нэр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)	Худалдаж авсан хувьцааны тоо ширхэг	Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)
1				
2				
...				
<input type="checkbox"/> Дээрх хуулийн этгээд, иргэд нь хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа эрхэлж олсон цэвэр ашгаараа тус банкныг байгуулж байгаа болно.				
<b>6. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ</b>				
	<u>Эрхлэх албан тушаал</u>			
	<u>Овог, нэр</u>			
1	Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга			
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга			
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн			
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн			
...				

Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харилахгүй, банкны үйл ажиллагааг шударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршилагатай, банкны ашиг сонирхлыг хувийн ашгаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж Банкны тухай хууль болон энэхүү журмын дагуу шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан тушаалд томилсон болно.

7. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	
	Эрхлэх албан тушаал
1	
2	
<p><input type="checkbox"/> Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харилахгүй, банкны үйл ажиллагааг шударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршилагатай, банкны ашиг сонирхлыг хувийн ашгаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж Банкны тухай хууль болон энэхүү журмын дагуу шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан тушаалд томилсон болно.</p>	
8. БАНК БАЙГУУЛАХ ХҮСЭЛТЭД ХАВСАРГАСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ	
1	
2	
3	
...	
Бүгд ..... хуудас	
<p><input type="checkbox"/> Дээрх баримт бичгүүдийг Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 201.. оны ..... дугаар тушаалаар батлагдсан "Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам"-ын дагуу үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа, хуурамч мэдээлэл орсон тохиолдолд Банкны тухай хууль болон бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.</p>	

Банк байгуулах хүсэлт болон холбогдох баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, банк байгуулах тусгай зөвшөөрлийг олгоно уу.

**БАНК БАЙГУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАСАН:**

Банк байгуулагч нь хуулийн  
 этгээд бол Гүйцэтгэх захирал (гарын үсэг) (нэр)  
 Банк байгуулагч нь иргэн бол (гарын үсэг) (нэр)



..... **БАНК БАЙГУУЛАГЧ,**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

<b>А. БАНК БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ</b>		
<input type="checkbox"/> <i>Банк байгуулагч</i> <input type="checkbox"/> <i>Хувьцаа эзэмшигч</i>		
Оноосон нэр:		
Улсын бүртгэлийн дугаар:		
Регистрийн дугаар:		
Байгуулагдсан огноо:		
Хуулийн этгээдийн улсын харьяалал:		
Үйл ажиллагааны чиглэл:		
Хаяг:		
Цахим хаяг:		
Холбоо барих утас:		
Гүйцэтгэх удирдлага		
1	Албан тушаал:	
	Овог, нэр:	
	Регистрийн дугаар:	
	Яс, үндэс:	
	Иргэншил:	
	Оршин суугаа хаяг:	
	Цахим шуудангийн хаяг:	
	Холбоо барих утас:	
...		

Гүйцэтгэх удирдлагын түүх (он дарааллаар бичнэ үү)			
	Албан тушаал	Овог нэр	Хугацаа
1			
2			
3			
...			

Хараат болон охин компанитай бол доорх хүснэгтийг бөглөнө үү				
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар
1				
2				
3				
...				

Өөр хуулийн этгээд, банкинд хувь эзэмшдэг бол доорхыг бөглөнө үү	
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр
1	Эзэмшлийн хувь
2	

...		
Хэрэв банк байгуулагч, хувьцаа эзэмшигч хуулийн этгээд нь аливаа хуулийн этгээдийн охин эсвэл хараат компани бол толгой компанийн тухай мэдээллийг доорх хүснэгтэд бөглөнө үү.		
Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр		
Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар,		
Үйл ажиллагааны чиглэл		

Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нийт хувьцааны 5%-аас илүү хувийг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг хувь хүн, тэдгээрийн холбогдох этгээдийн тухай мэдээллийг доорх хүснэгтэд бөглөнө үү			
	Овог, нэр	Регистрийн дугаар	Эзэмшлийн хувь
1			
2			
...			
Байгууллагын бүтцийг диаграмм хэлбэрээр доорх хүснэгтэд оруулна уу <i>(Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн охин болон хараат компани, хувьцаа эзэмшдэг компани, банк байгуулагчийн толгой компани болон хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн эзэмшлийн хувийг харуулсан нарийвчилсан диаграммыг энд зурна уу)</i>			
Харилцагч банк			
1			
2			
...			

Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)

..... оны ..... сарын .....-ний өдөр

В. <b>БАНК БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУВЬ ХҮН БОЛ</b>				
<input type="checkbox"/> Банк байгуулагч		<input type="checkbox"/> Хувьцаа эзэмшигч		
<b>I. Товч танилцуулга</b>				
Ургийн овог:		<i>Зх4 харьцаатай сүүлийн зургаан сарын дотор авхуулсан өнгөт цээж зураг</i>		
Овог:				
Нэр:				
Төрсөн огноо:				
Регистрийн дугаар:				
Яс, үндэс:				
Иргэншил:				
Оршин суугаа хаяг:				
Цахим шуудангийн хаяг:				
Суурин болон гар утасны дугаар:				
<b>II. Ажил эрхлэлт</b>				
Одоо ажиллаж байгаа байгууллага				
Албан тушаалын нэр				
Албан тушаалд томилогдсон огноо				
Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, утасны дугаар				
Өмнөх хугацаанд ажилласан байгууллага	Албан тушаалын нэр	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон огноо	Ажлаас гарсан огноо, шалтгаан
...				
...				
...				
Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорхыг бөглөнө үү.				
д/д	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар	
1				
2				
...				
Хуулийн этгээд, банкны хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол доорх хүснэгтийг бөглөнө үү.				
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар	
1				
2				
...				
<b>III. Гэр бүлийн байдал</b> (гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээллийг оруулна уу)				
	Овог, нэр, дугаар	Регистрийн	Таны юу болох	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал

1			
2			
...			

Банк байгуулагч, хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэх/паспортын нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны ..... сарын .....-ний өдөр

..... **БАНКНЫ**  
**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

<b>ТОМИЛОГДОХ АЛБАН ТУШААЛ</b>				
<i>(томилогдох албан тушаалын нэрийг энд бичнэ үү)</i>				
<b>I. Товч танилцуулга</b>				
Ургийн овог:				<i>3x4 харьцаатай сүүлийн зургаан сарын дотор авхуулсан өнгөт цээж зураг</i>
Овог:				
Нэр:				
Төрсөн огноо:				
Регистрийн дугаар:				
Яс, үндэс:				
Иргэншил:				
Оршин суугаа хаяг:				
Цахим шуудангийн хаяг:				
Суурин болон гар утасны дугаар:				
<b>II. Боловсрол</b> <i>(боловсролын гэрчилгээнүүдийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана уу)</i>				
Боловсрол	Эзэмшсэн боловсрол/ хамгаалсан цол	Суралцсан хугацаа	Сургуулийн нэр	Улс, хотын нэр
Дунд				
Дээд				
...				
<b>III. Ажил эрхлэлт</b>				
Одоо ажиллаж байгаа байгууллага				
Албан тушаалын нэр				
Албан тушаалд томилогдсон огноо				
Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, утасны дугаар				
Өмнөх хугацаанд ажилласан байгууллага	Албан тушаалын нэр	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон огноо	Ажлаас гарсан огноо, шалтгаан
...				
...				
...				
Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.				
д/д	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар	
1				

2			
...			
Хуулийн этгээд, банкны хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол доорх хүснэгтийг бөглөнө үү.			
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар
1			
2			
...			
<b>IV. Гэр бүлийн байдал</b> ( <i>гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээллийг оруулна уу</i> )			
	Овог, нэр, дугаар	Регистрийн	Таны юу болох
			Одоо эрхэлж буй ажил, албан тушаал
1			
2			
...			
<b>V. Харилцагч банк</b>			
1			
2			
...			

Иргэний үнэмлэх/паспортын нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг товч намтрын хамт хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны ..... сарын .....-ний өдөр

**..... БАНКНЫ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ  
ЭТГЭЭД, БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,  
ГИШҮҮН, БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД ТОМИЛОГДОХ  
ЭТГЭЭДИЙН АСУУЛГА**

1	Та өөр улсын эрх бүхий байгууллагад зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байсан уу? Таны хүсэлтийг хүлээж аваагүй, эсвэл татгалзсан тохиолдол бий юу?	
2	Та аль нэг улсад иргэний, эрүүгийн шүүхийн шийдвэрээр ял, шийтгэл эдэлж байсан уу (18 нас хүрэхээс өмнө үйлдэж байсан гэмт хэрэг, тээврийн хэрэгсэл эзэмшихтэй холбоотой зөрчлийг хялбарчилсан журмаар шийдвэрлэсэн бол энд хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
3	Санхүүгийн байгууллагатай холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
4	Та гишүүн байсан мэргэжлийн байгууллагын шийдвэрээр сахилгын хариуцлага хүлээж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
5	Та өмнө нь луйвар, залилан, эсвэл ижил төрлийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй орлогын талаар мэдүүлэг өгч байсан уу (хараат бус шинжээчээр ажиллаж байсан бол хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
6	Та, эсвэл таны хувьцаа эзэмшдэг, захирал, гүйцэтгэх удирдлага, мөн/эсвэл ажилтнаар нь ажилладаг, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлдэг байгууллага, нөхөрлөл нь төрийн, мэргэжлийн, эсвэл бусад төрлийн зохицуулагч байгууллагын зүгээс мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.	
7	Таныг албан тушаалаас тань огцруулж байсан, эсвэл албан тушаалд томилогдохтой холбогдуулан татгалзаж байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.	
8	Таныг өөр улсад шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцож байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.	
9	Та өөр улсад шүүхийн шийдвэрээр төлбөр барагдуулах шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болж байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.	
10	Та хуулийн этгээд үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэхтэй холбоотой, эсвэл хуулийн этгээдийн удирдлага, ажилтны эсрэг залилан, эрх мэдлээ урвуулан ашиглах, бусад албан тушаалын гэмт хэрэгт холбогдон аль нэг улсад иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэгдэн шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	

11	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, эсвэл ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл нь өр төлбөрөө бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн барагдуулж чадаагүй тохиолдол бий юу? Таныг албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа нэг жилийн дотор ийм тохиолдол гарсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
12	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөө цуцлуулж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
13	Та итгэлцэл, фидуци болон эдгээртэй адилтгах бусад төсөөтэй харилцааг тодорхой шалтгааны улмаас шаардсаны дагуу дуусгавар болгож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
14	Та энэ байгууллагад хэн нэгэн гуравдагч этгээдийн удирдлага, зааварчилгааны дор ажиллах/ажиллаж байна уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
15	Та холбогдох хууль эрх зүй, зохицуулалтын болон мэргэжлийн стандарт шаардлагыг дагаж мөрдөхөд бэлэн үү?	

Би энэ тодорхойлолтыг бөглөн өгснөөр мэдүүлсэн бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг баталж байна. Мөн дээр дурдсан хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын захирал, гүйцэтгэх удирдлагаар ажиллах хугацаанд, эсвэл хувьцаа эзэмшигч байх, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэх хугацаанд энэ асуулгад мэдүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд эрх бүхий байгууллагад 21 хоногийн дотор мэдэгдэх болно.

Овог, нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_  
 Огноо \_\_\_\_\_



..... **БАНКНЫ ТЕХНИК, ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

Банк нь үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангагдсан бөгөөд үйл ажиллагаандаа .....  
(*програм хангамжийн нэрийг бичнэ*) програм хангамж ашиглаж, програм хангамж нь мэдээллийн нууцлал, найдвартай ажиллагааг хангасан болохыг баталж байна.

Банк нь үйл ажиллагаа эрхлэхэд зориулж Улаанбаатар хот ( .....  
.аймаг)-ын .....  
..... (хаяг) орших үл хөдлөх хөрөнгийг худалдан авсан (түрээсэлсэн)  
(*аль нь болохыг доогуур нь зурах*) бөгөөд энэхүү байр нь нийт. .... метр  
квадрат талбайтай, банкны үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой бөгөөд банкны  
аюулгүй ажиллагааг хангах харуул хамгаалалтын. .... компанитай  
болон дохиолол хамгаалалтын ..... компанитай гэрээ  
байгуулахаар урьдчилан тохиролцсон болно.

Хавсралт:

1. Банкны үйл ажиллагаа эрхлэх үл хөдлөх хөрөнгийг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, зээлийн барьцаанд байгаа эсэхийг тодорхойлсон баримт бичиг, түрээсэлсэн бол түрээсийн гэрээ.
2. Банкны програм хангамжийг нийлүүлж байгаа этгээдтэй хийсэн гэрээ, Монголбанкны банк хоорондын сүлжээ болон зээлийн мэдээллийн сантай холбогдож, ажиллахад бэлэн болсныг нотлох баримт.
3. Харуул хамгаалалтын болон дохиолол хяналтын компанитай гэрээ байгуулахаар урьдчилан тохирсон болохыг нотлох баримт.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА (гарын үсэг) (нэр)

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ (гарын үсэг) (нэр)

## **БАНКНЫ ДҮРЭМ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР**

Банкны дүрэмд Банкны тухай хуулийн 21.1, Компанийн тухай хуулийн 16.2-т заасан шаардлагаас гадна дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

1. Банкны оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;
2. Өмчлөлийн болон байгуулагдсан хэлбэр, үйл ажиллагаа явуулах, ажил үйлчилгээ эрхлэх чиглэл;
3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;
4. Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулах хороо, тэдгээрийн гишүүдийг томилох, чөлөөлөх журам, эрх, үүрэг, хариуцлага;
5. Банкны тухай хуулийн 33 дугаар зүйл, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамнаас баталсан Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх тухай журмын шаардлагыг хангасан Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага;
6. Эрх бүхий албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага, банк их хэмжээний болон ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;
7. Дотоод аудитын газрын бүрэн эрх, үүрэг, хариуцлага;
8. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн бүрэн эрх, үүрэг, хариуцлага;
9. Банк, банкны ажилтны нэр хүндийг хамгаалах, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг тусгасан бодлого;
10. Хувьцааг арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан журам;
11. Банк татан буулгах үндэслэл, банкны удирдлагын буруутай үйл ажиллагаанаас харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим;
12. Шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

## БАНК БАЙГУУЛАХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Банк байгуулах эдийн засгийн үндэслэлд дор дурдсан асуудлыг тусгана.

Үүнд:

1. Улс орны эдийн засаг, банкны системийн өнөөгийн нөхцөл байдал, хандлага болон онцлогийг судалж, банкны системд шинэ банк байгуулах шаардлага болон шинэ банк байгуулагдсанаар үүсэх нөлөөллийн судалгааг эдийн засгийн үндэслэлтэй тооцоололд суурилан гүйцэтгэх.
2. Байгуулах банкны үйл ажиллагааны цар хүрээ, бүтээгдэхүүн үйлчилгээ, шинээр нэвтрүүлэх арга хэрэгсэл, техник технологийг тодорхойлж, банкны системд үзүүлэх эерэг нөлөөллүүдийг тодорхой тусгах.
3. Банкны эхлэлтийн тайлан тэнцэл болон банк байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж эхлэхээс хойш хэрэгжүүлэх 3 жилийн хугацааны санхүүгийн төсөл, бизнес төлөвлөгөөг боловсруулах.
4. Байгуулах банкны эрхлэх үйл ажиллагаа, ажил үйлчилгээний ерөнхий нөхцөлийг тусгаж, холбогдох журам, заавар боловсруулах.
5. Байгуулах банкны эрсдэлийг илрүүлэх, тооцох, хэмжих, үнэлэх, дүгнэх, удирдах арга хэрэгсэл болон дотоод хяналтын зохистой механизмыг хэрхэн бүрдүүлэхийг тодорхойлсон баримт бичиг боловсруулах.

### ***Банкны бизнес төлөвлөгөө боловсруулах***

Бизнес төлөвлөгөө нь тухайн банкны хэтийн хөгжил, зорилтыг тодорхойлж, энэ зорилтоо амжилттай биелүүлж, үр дүнд хүрэхийн тулд банкны бүтэц, зохион байгуулалт, эрхэлж буй ажил, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, банкны санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримт бичиг юм.

Банк байгуулагч нь бизнес төлөвлөгөөг байгуулах банкны үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд банк байгуулагдан үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүр нь тодорхой хугацаа, хариуцах эзэн, тайлбар, танилцуулгатай хийгдсэн байна.

Банкны бизнес төлөвлөгөөнд дараах асуудлуудыг тусгана Үүнд:

1. ***Банкны бизнесийн хэтийн төлөв, зорилт.*** Энэ хэсэгт банкны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд дараах асуудлын талаар баримтлах бодлого, байр суурийг он тус бүрээр төлөвлөж тусгана:

- А. Банкны өмчлөл, үйл ажиллагааны хэлбэр, төрөл, ирээдүйн чиглэл, зах зээлд гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь, өрсөлдөгчид, цар хүрээ (нэгжийн тоо, байршил гэх мэт), харилцагчдын бүтэц, үйлчилгээний хөнгөн шуурхай болон итгэл найдвартай байдлыг бий болгох чиглэлээр нэвтрүүлэх ажил, үйлчилгээний шинэ арга хэлбэр, хэрэгсэл.
- Б. Банкны актив, пассивын бүтэц, хэмжээ, зээл, хадгаламж, хүүгийн бодлого, зээлдэгчдийн бүтэц, тэдэнд хандах хандлага, тавих хяналтын арга хэлбэр.
- В. Банкны онцлогтой уялдсан бусад арга хэмжээ.
2. **Банкны бүтэц, зохион байгуулалт, түүнийг боловсронгуй болгох, удирдлагын ур чадварыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээ.** Энэ хэсэгт банкны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд дараах асуудлын талаар баримтлах бодлого, байр суурийг он тус бүрээр төлөвлөж тусгана:
- А. Тухайн банкны стратегийн зорилттой уялдсан бүтэц, зохион байгуулалт (банк нь актив пассивын хороо, зээлийн хороо, бүртгэл мэдээллийн, дотоод хяналтын болон чанаргүй зээлтэй ажиллах албыг заавал байгуулах шаардлагатай бөгөөд тухайн банкны цар хэмжээ, онцлог байдал, зайлшгүй шаардлагаас хамаарч удирдлагын бусад нэгжтэй байж болно), удирдлага, банкны үйл ажиллагаанд тавих хяналтын арга хэлбэр, шинэ хувь нийлүүлэгчидтэй харилцах харилцаа.
- Б. Зээл олголт, түүнд тавих хяналт, эргэж төлүүлэх үйл ажиллагаа.
- В. Банкны одоогийн эрхлэх үйл ажиллагаа болон ирээдүйд шинээр нэвтрүүлэх үйлчилгээний төрөл, хэрэгслийг зохицуулахад чиглэгдсэн бодлогын чанартай эрх зүйн баримт бичиг.
- Г. Хот болон орон нутагт өөрийн нэгжийг байгуулах эсэх, түүний байршил, бүтэц зохион байгуулалт.
- Д. Хүний нөөцийн байдал, ур чадвар.
- Е. Банкны үйл ажиллагааны онцлогтой уялдсан бусад арга хэмжээ.
3. **Санхүүгийн төсөл.** Энэ хэсэгт банкны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойших 3 жилийн хугацааг хамруулан дараах санхүүгийн баримт бичгийн төслийг он тус бүрээр улирлын хуваарьтай тооцож төлөвлөхөөс гадна банкны жилийн төсвийг хийж тусгана:
- А. Банкны эхлэлтийн тайлан.
- Б. Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш улирал бүрийн тайлан тэнцэл, орлого зарлагын тайлан, мөнгөн хөрөнгийн урсгалын тайлангийн төсөөлөл.

- В. Ашиг, ашигт ажиллагааны түвшний үзүүлэлтүүдийн улирал бүрээр тооцсон төсөөлөл.
4. **Санхүү, төлбөрийн чадварын талаарх 3 жилийн хугацааны төсөл.** Энэ хэсэгт Банкны тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн Монголбанкнаас тогтоосон дараах шалгуур үзүүлэлтүүдийг банкны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойших 3 жилийн хугацаанд хэрхэн хангаж ажиллах талаарх төлөвлөгөөг он тус бүрээр улирлын хуваарьтай тооцож тусгана:
- А. Заавал байлгах нөөцийн хангалт.
- Б. Зээл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа.
- В. Зээлийн багцын чанарын үзүүлэлт.
- Г. Эдийн засгийн нэг салбарт олгох зээл, нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцаа.
- Д. Нэг зээлдэгч, холбогдох этгээдүүдэд олгох зээлийн дээд хэмжээ.
- Е. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ.
- Ё. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар.
- Ж. Актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны зөрүү.
- З. Гадаад валютын позици (нээлттэй буюу хаалттай).
- И. Эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд.

Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох Монголбанкны шийдвэр гарсан өдрөөс эхлэн банк нь энэ зааврын дагуу боловсруулсан бизнес төлөвлөгөөг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах үүрэгтэй.

Монголбанк нь банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх бүр энэхүү бизнес төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

## **БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Монголбанк Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг үндэслэн банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл авах хүсэлтийг хүлээн авах, хүсэлтийг хянаж судлах, банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг хязгаарлах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам нь Төв банк / Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн байна.

1.3. Банк үүсгэн байгуулах тухай Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол банкны үйл ажиллагааны энгийн зөвшөөрлийг банк үүсгэн байгуулах тусгай зөвшөөрлийн хамт олгоно.

1.4. Банк үүсгэн байгуулах тухай Монголбанкны шийдвэрт банк үүсгэн байгуулах зөвшөөрлийг үйл ажиллагааны энгийн зөвшөөрлийн хамт олгоогүй тохиолдолд энгийн зөвшөөрлийг олгохтой холбогдсон харилцааг тухайн шийдвэрт тодорхой заасан байна.

1.5. Банкны үйл ажиллагааны энгийн зөвшөөрлийг нэмэлтээр олгох, нэмэлт зөвшөөрлийг олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.6. Банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкны шийдвэрээр Банкны тухай хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа тус бүрээр олгоно.

1.7. Монголбанк нь энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан банкинд Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй тухай албан бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

1.8. Монголбанк үйл ажиллагааны зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд хуульд заасан үндэслэлээр энэ журмын 6 дугаар бүлэгт зааснаар үндэслэн хязгаарлаж, түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

1.9. Монголбанк нь банкны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалт, хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц болон хэмжээ, хүний нөөц, ажлын байр, техник, тоног төхөөрөмж, нөөц төв, програм хангамжийн бэлтгэгдсэн байдалд тусгайлан шаардлага тавьж, эрхлэх үйл ажиллагаанд хязгаарлалт, хугацаа тогтоон үйл ажиллагааны зөвшөөрөл олгож болно.

1.10. Банкны үйл ажиллагааны энгийн зөвшөөрөлд дараах зөвшөөрөл хамаарна:

1.10.1. Банкны тухай хуулийн 6.1.2-т заасан зээл;

- 1.10.2. Банкны тухай хуулийн 6.1.3-т заасан төлбөр тооцооны үйлчилгээ (зөвхөн бэлнээр болон банк хоорондын захаар хийх бэлэн бус төлбөр тооцоо);
- 1.10.3. Банкны тухай хуулийн 6.1.5-д заасан гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах (зөвхөн харилцагчийн захиалгаар валютын арилжааны хэлцэл хийх, ностро, лоро харилцах, зөвхөн ханшийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор хийгдсэн гадаад валютын своп, спот хэлцэл хийх);
- 1.10.4. Банкны тухай хуулийн 6.1.7-д заасан үнэт зүйл хадгалах;
- 1.10.5. Банкны тухай хуулийн 6.1.8-д заасан гадаад төлбөр тооцоо хийх (зөвхөн гадаадын банкнаас зээл авах, харилцагчийн захиалгаар валютын арилжааны хэлцэл хийх, ностро, лоро харилцах, зөвхөн ханшийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор хийгдсэн гадаад валютын своп, спот хэлцэл хийх);
- 1.10.6. Банкны тухай хуулийн 6.1.10-т заасан санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг тус тус эрхлэх зөвшөөрлийг хэлнэ.
- 1.11. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөлд дараах зөвшөөрөл хамаарна:
- 1.11.1. Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан мөнгөн хадгаламж;
- 1.11.2. Банкны тухай хуулийн 6.1.4-т заасан өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
- 1.11.3. Энэ журмын 1.10.3-т зааснаас бусад гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
- 1.11.4. Банкны тухай хуулийн 6.1.6-д заасан үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
- 1.11.5. Энэ журмын 1.10.5-д зааснаас бусад гадаад төлбөр тооцоо хийх;
- 1.11.6. Банкны тухай хуулийн 6.1.9-д заасан үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
- 1.11.7. Банкны тухай хуулийн 6.1.11-д заасан зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах;
- 1.11.8. Монголбанкны Ерөнхийлөгчийн банк байгуулах тусгай зөвшөөрөлд хамт олгоогүй, Банкны тухай хуулийн 6.1-д заасан бусад үйл ажиллагааны зөвшөөрлийг хэлнэ.

### **ХОЁР. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл олгоход тавих шаардлага**

- 2.1. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрлийг дараах шаардлагыг хангасан банкинд олгох буюу олгоход татгалзахгүй тухай санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Үүнд:
- 2.1.1. Банкны тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчөөгүй, Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 6 (зургаан) сарын турш тогтмол хангаж ажилласан;

2.1.2. Монголбанкнаас тухайн банкинд хамгийн сүүлд хийсэн газар дээрх иж бүрэн шалгалтаар “Сайн” буюу түүнээс дээш үнэлгээ авсан, хэрэв сүүлийн нэг жилийн хугацаанд тухайн банкинд иж бүрэн шалгалт ороогүй бол зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 12 сарын хугацаанд тогтмол хангасан;

2.1.3. Шалгалтын дагуу Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлсэн;

2.1.4. Тухайн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай банкны хүний нөөц, ажлын байр, техник, тоног төхөөрөмж, програм хангамж, хөрөнгийн эх үүсвэр бүрэн хангагдсан;

2.1.5. Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх тухай Монголбанкнаас баталсан журмын дагуу хамгийн сүүлд авсан зохистой засаглалын үнэлгээ нь “Дунд” ба түүнээс дээш байх,

2.1.6. Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загварын маягтын дагуу холбогдох мэдээллийг олон нийтэд заасан хугацаанд мэдээлдэг байх.

### **ГУРАВ. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг**

3.1. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл хүсэгч банк нь эрхлэх үйл ажиллагааны нэр төрөл, шаардлага, хөрөнгийн эх үүсвэр, тухайн үйл ажиллагааг явуулахад шаардагдах (нягтлан бодох бүртгэл, зээлийн мэдээллийн сан гэх мэт) техник, тоног төхөөрөмж, програм хангамж, шаардлага хангасан нөөц төв, ажлын байр, удирдлага, хүний нөөц, банкны үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлтэд орох өөрчлөлтийн талаар тодорхой тусгасан хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

3.1.1. Тухайн үйл ажиллагааг эрхлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.1.2. Банкны дүрэмд орох нэмэлт, өөрчлөлт;

3.1.3. Тухайн үйл ажиллагааг эрхлэхэд нэмж шаардагдах өөрийн хөрөнгө, зардал, тэдгээрийн эх үүсвэрийн тооцоолол;

3.1.4. Бизнес төлөвлөгөө болон санхүүгийн тайланд орох холбогдох өөрчлөлтүүд, танилцуулга;

3.1.5. Тухайн үйл ажиллагааг эрхлэхэд мөрдөх эрх зүйн баримт бичиг (журам, заавар, ажил үйлчилгээний ерөнхий нөхцөл гэх мэт);

3.1.6. Гадаад төлбөр тооцооны нэмэлт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэж буй банк нь энэ журмын 3.1.1- 3.1.5-д заасан баримт бичгээс гадна гадаад валютын арилжааны нэр төрөл, ажил гүйлгээг гүйцэтгэх журамд гадаад төлбөр тооцооны ажилтан тус бүрийн эдлэх эрх, үүрэг, хүлээх хариуцлага, нээлттэй позици болон арилжаатай холбоотой зохицуулалт, харилцагч гадаадын банкуудын эрсдэлийг тооцох аргачлал зэргийг тодорхой тусгасан байна.



3.2. Монголбанк нь энэ журмын 3.1-д заасан баримт бичгээс гадна энэ журмын шаардлагын дагуу нэмэлт материал шаардах эрхтэй.

**ДӨРӨВ. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрлийн хүсэлт,  
баримт бичгийг хянах, зөвшөөрөл олгох**

4.1. Монголбанк нь Банкны тухай хууль тогтоомжийг үндэслэн банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох зааврын дагуу хянаж, шаардлагатай асуудлыг Монголбанкны холбогдох газар, хэлтсүүд газар дээр нь шалгана.

4.2. Монголбанк банкны үйл ажиллагааны зөвшөөрөл олгох эсэх шийдвэрээ энэ журмын 3 дугаар бүлэгт заасан өргөдөл, баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор гаргаж, энэ тухай хүсэлт гаргагч банкинд ажлын 3 (гурав) хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

4.3. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт баримт бичиг шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагч банкинд энэ талаар албан бичгээр, эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.

4.4. Баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрийг банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрлийн хүсэлт хүлээн авсан өдөрт тооцно.

4.5. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд Монголбанкны банкны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар, хууль, эрх зүйн асуудал эрхэлсэн газар, төлбөр тооцоо, бүртгэлийн асуудал эрхэлсэн газар, мэдээлэл технологийн асуудал эрхэлсэн газар, валютын зах зээлийн асуудал эрхэлсэн газар санал, дүгнэлтээ Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж, шаардлагатай тохиолдолд Монголбанкны Хяналт шалгалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

4.6. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамж, Монголбанкны ажил үйлчилгээний шимтгэлийг ажлын 3 хоногийн дотор төлөхийг хүсэлт гаргагч банкнаас шаардаж, улсын тэмдэгтийн хураамж, Монголбанкны ажил үйлчилгээний шимтгэл төлсөн баримтыг хүсэлт бүхий материалд хавсаргана.

4.7. Монголбанк нь банкны үйл ажиллагаа эрхлэх тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэр, Улсын тэмдэгтийн хураамж, ажил үйлчилгээний шимтгэл төлсөн тухай нотлох баримтыг үндэслэн банкны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийнэ.

**ТАВ. Банкны үйл ажиллагааны зөвшөөрөл  
олгохоос татгалзах үндэслэл**

5.1. Монголбанк дараах үндэслэлээр банкны үйл ажиллагааны зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

5.1.1. Энэ журмын 2 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангаагүй;

5.1.2. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан баримт бичгийг бүрэн гүйцэд ирүүлээгүй;

5.1.3. Хүсэлт гаргагч банк тухайн үйл ажиллагааг эрхэлснээр үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, эсхүл санхүү, банкны салбарын тогтолцооны тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй гэж Монголбанк үзсэн;

5.1.4. Монголбанкнаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээлэл болон тухайн мэдээллийн нотлох баримтыг ирүүлээгүй, нотлох баримтын үндэслэл, тайлбар нь тодорхойгүй, тэдгээрийг тодорхойлох боломжгүй;

5.1.5. Бүрдэл дутуу материалыг буцааснаас хойш 30 (гуч) хоногийн дотор холбогдох баримт бичгийг ирүүлээгүй;

5.2. Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тухай банк байгуулах хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

### **ЗУРГАА. Банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг**

#### **хязгаарлах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

6.1. Банк үүсгэн байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор урьд олгосон, банкны үйл ажиллагаа эрхлэх бүх зөвшөөрөл хүчингүй болно.

6.2. Монголбанк банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг Банкны тухай хуульд заасан албадлагын арга хэмжээний дагуу дараах үндэслэлээр хязгаарлаж, түдгэлзүүлж, хүчингүй болгож болно. Үүнд:

6.2.1. Банкны тухай хуулийн 16.1.1, 16.1.2 дахь заалт, 17 дугаар зүйлд заасан шаардлагыг 3 сар дараалан хангаж ажиллаагүй;

6.2.2. Тухайн үйл ажиллагаанаас өөрийн хөрөнгийн үзүүлэлтэд нөлөөлөхүйц хэмжээгээр алдагдал хүлээсэн;

6.2.3. Банкны зарим үйл ажиллагааг хязгаарласан, түдгэлзүүлсэн шалтгааныг арилгаагүйгээр тухайн үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлсэн, эсвэл 6 сарын хугацаанд хязгаарласан, түдгэлзүүлсэн тухай шийдвэрийг цуцлах хангалттай нөхцөл бүрэлдээгүй;

6.2.4. Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкны бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан шийдвэрийг зөрчсөн буюу биелүүлээгүй;

6.2.5. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл бүрдсэн.

6.3. Гадаад төлбөр тооцоо хийх зөвшөөрлийг Монголбанкнаас хүчингүй болгосон тохиолдолд банк нь гадаадын банк дахь ностро, лоро дансдын хуулга болон холбогдох гэрээ, хэлцлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шийдвэр гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Монголбанкинд ирүүлнэ.

6.4. Банк энэ журмын 6.2-т заасан үндэслэлээр хязгаарласан, түдгэлзүүлсэн үйл ажиллагааны зөвшөөрлийг сэргээлгэх, хүчингүй болгосон үйл ажиллагааны зөвшөөрлийг шинээр авах хүсэлтийг Монголбанкинд ирүүлсэн тохиолдолд зөрчил дутагдлыг арилгасан эсэх, Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн эсэхийг газар дээр хийсэн хэсэгчилсэн буюу иж бүрэн шалгалтаар тогтоосон дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

6.5. Хүчингүй болсон үйл ажиллагааны зөвшөөрлийг дахин олгох тухай хүсэлтийг Монголбанк тухайн үйл ажиллагааг хүчингүй болгох тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын хугацаанд хүлээн авахгүй бөгөөд хүсэлт гаргагч нь тогтоосон хугацааны дараа энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлэн хүсэлт гаргана.

6.6. Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйл ажиллагааны зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос түдгэлзүүлсэн, хязгаарласан, хүчингүй болгосон тохиолдолд тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 (тав) хоногийн дотор тухайн банк энэ талаар Монголбанкинд бичгээр мэдэгдэнэ.

### **ДОЛОО. Хяналт, хариуцлага**

7.1. Энэ журмын 6.1, 6.2-т заасан үндэслэлээр банкны үйл ажиллагааг хязгаарлаж, түдгэлзүүлж, хүчингүй болгож, арга хэмжээ авахтай холбогдон гарсан зардлыг тухайн банк хариуцна.

## **БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Монголбанк Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийг үндэслэн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл (цаашид “зөвшөөрөл” гэх) олгох, олгосон зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам нь Төв банк/Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн байна.

1.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд дараах байдлаар өөрчлөлт орох тухай бүр Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасны дагуу энэ талаар Монголбанкинд бичгээр урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна. Үүнд:

1.3.1. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах;

1.3.2. Шинээр хувьцаа эзэмшигч нэмэгдэх;

1.3.3. Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох;

1.3.4. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох;

1.3.5. Банк хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг банкинд буцаан худалдан авах.

1.4. Банкны хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орсноор хувьцаа эзэмшигч холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн нийт хувьцааны 5 (таван) хувьд хүрэхгүй тохиолдолд тухайн өөрчлөлтийг Монголбанкинд албан бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

1.5. Энэ журмын 1.4-т заасан, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд орсон өөрчлөлтийг мэдэгдэхдээ хувьцаа эзэмшигчийн овог, нэр, регистрийн дугаар, хаяг, хувьцааны тоо ширхэг, хувьцааны хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний талаарх мэдээллийг энэ журмын 8.1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийн өөрчлөлтийн тайлангийн хамт Монголбанкинд албан бичгээр ирүүлнэ.

1.6. Банкны тухай хуулийн 69.1.14-д заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийг алдагдалд хаахад энэ журам хамаарахгүй.

**ХОЁР. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ,  
бүтцэд өөрчлөлт оруулах**

2.1. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:

- 2.1.1. Хувьцаа нэмж гаргах;
- 2.1.2. Ногдол ашгийг хувьцаагаар хуваарилах;
- 2.1.3 Өрийг хувьцаагаар солих;
- 2.1.4. Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй хоёрдогч өглөг байршуулах;
- 2.1.5. Нэгж хувьцааны үнийг өсгөх буюу бууруулах;
- 2.1.6. Хувьцааг нэгтгэх болон хуваах;
- 2.1.7. Хувьцаа эзэмшигч өөрийн хувьцааг бусдад худалдах;
- 2.1.8. Хувьцааг гэрээслэл, бэлэглэлийн гэрээний үндсэн дээр болон Иргэний хуульд заасан бусад хэлцлийн үндсэн дээр, хуульд зааснаар бусдад шилжүүлэх;
- 2.1.9. Хувьцааг шүүхийн шийдвэрээр бусдад шилжүүлэх;
- 2.1.10. Банк хувьцаа эзэмшигчээс хувьцааг буцаан худалдан авах (халаасны хувьцаа);

**ГУРАВ. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн  
хэмжээ бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл  
олгоход тавигдах шаардлага**

3.1. Монголбанк энэхүү журмын 1.3-т заасан зөвшөөрлийг олгохдоо банк, банкны хувьцаа эзэмшигчдэд дараах шаардлагыг тавина. Үүнд:

- 3.1.1. Компанийн тухай хуулийн дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөлийг хангасан байх;
- 3.1.2. Банкны дүрэмд оруулсан өөрчлөлт нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хуультай нийцтэй байх;
- 3.1.3. Хувьцаа эзэмшигч нь Банкны тухай хуулийн 19, 36<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх;
- 3.1.4. Хувьцаа эзэмшигч нь банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй байх;
- 3.1.5 Хувьцаа эзэмшигч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй байх;
- 3.1.6 Хувьцаа эзэмшигч нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

- 3.1.7. Хувьцаа эзэмшигч нь Банкны тухай хуулийн 36.12-т заасан шаардлагыг хангасан байх;
- 3.1.8. Өрийг хувьцаагаар солиход Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх;
- 3.1.9. Хувьцааг нэгтгэх болон хуваахад Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх;
- 3.1.10. Банк хувьцааг буцаан худалдан авахад Компанийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан байх.
- 3.2. Банкны хувьцаа эзэмшигч нь энэхүү журмын 3.1, 3.3-т заасан шаардлагыг хувьцаа эзэмшиж байх нийт хугацаанд хангах үүрэгтэй.
- 3.3. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд нь дараах шаардлагыг хангасан эсэх тухай Монголбанк дүгнэлт гаргана. Үүнд:
- 3.3.1. Тухайн этгээдтэй холбоотойгоор ямар нэгэн сахилгын арга хэмжээ авч байсан, эсхүл гэмт хэргийн шинж чанартай мөрдөн байцаах ажиллагаа явагдаж байгаа эсэх, эсхүл ийм үйл ажиллагаанд хүргэж болзошгүй байдалд байгаа эсэх;
- 3.3.2. Тухайн этгээд нь өмнө нь томилогдож байсан итгэлцэл, фидуци болон эдгээртэй адилтгах бусад төсөөтэй харилцааг тодорхой шалтгааны улмаас шаардсаны дагуу дуусгавар болгож байсан эсэх;
- 3.3.3. Тухайн этгээдийг шаардлага хангаагүй шалтгаанаар захирал, удирдах албан тушаалаас нь чөлөөлж байсан эсэх;
- 3.3.4. Тухайн этгээд өмнө нь зохицуулагч байгууллагатай хамтарч ажилласан эсэх, хууль эрх зүй, зохицуулалтын болон мэргэжлийн стандарт, шаардлагыг дагаж мөрдөхөд бэлэн эсэх;
- 3.3.5. Тухайн этгээд Монголбанкны шаардлага, түүнтэй адилтгах стандарт эсхүл зохицуулагч байгууллага, мэргэжлийн байгууллага эсхүл төрийн байгууллага, агентлагуудын шаардлагуудыг зөрчиж байсан эсэх;
- 3.3.6. Тухайн этгээд ажил үүрэг, эрх мэдэл, ажил үүргээ хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх;
- 3.3.7. Тухайн этгээдийг Монголбанк эсхүл мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар хувийн эсхүл мэргэжлийн ёс зүйгүй байдлыг тогтоож үйл ажиллагааг нь зогсоож байсан эсэх.”

**ДӨРӨВ. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ,  
бүтцэд өөрчлөлт оруулахад бүрдүүлэх баримт бичиг**

4.1. Банк нь хувьцаа нэмж гаргах, ногдол ашгийг хувьцаагаар хуваарилах, өрийг хувьцаагаар солих, хувьцаанд хөрвөх нөхцөлтэй хоёрдогч өглөг байршуулах, шинээр хувьцаа эзэмшигч нэмэгдэх, аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах замаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулж байгаа бол зөвшөөрөл хүссэн албан бичгээ дараах баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

- 4.1.1. Эрх бүхий этгээдийн шийдвэр;
- 4.1.2. Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсон бол өөрчлөгдсөн дүрмийн улсын бүртгэгчийн тамга болон нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- 4.1.3. Аудитын болон татварын байгууллагаар баталгаажуулсан банкны санхүүгийн тайлан нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 4.1.4. Энэхүү журмын Хавсралт 1-ийн дагуу гаргасан Хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт;
- 4.1.5. Банкны хувьцаа эзэмшигч нь шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй эсэх талаарх эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
- 4.1.6. Банкны хувьцаа эзэмшигчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхэд Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн мэдээ, баримт бичиг;
- 4.1.7. Банкны хувьцаа эзэмшигч болох хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч хүртэлх хэлхээ холбоог тогтооход Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн мэдээ, баримт бичиг;
- 4.1.8. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгийн хэмжээ, гарал үүслийг нотлох баримт. Үүнд:

- 4.1.8.1. Хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд нь хуулийн этгээд бол үйл ажиллагааны сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, иргэн бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны цалин, орлогын тодорхойлолт, татварын газрын тодорхойлолт, харилцагч банкны дансны хуулга;

- 4.1.8.2. Хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд нь хуулийн этгээд бол харьяалах татварын байгууллагаас баталгаажуулсан сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан”, иргэн бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны “Хувь хүний орлогын албан татварын тайлан”, татварын газрын тодорхойлолт;

- 4.1.9. Холбогдох гэрээ хэлцэл, нотлох баримт (худалдах, худалдан авах гэрээ, өр, хоёрдогч өглөгийг хувьцаанд хөрвүүлэх гэрээ, гэрээслэл, бэлэглэлийн гэрээ, шүүхийн шийдвэр гэх мэт);

- 4.1.10. Хувьцаа эзэмшигч нь гадаадын харьяалалтай хуулийн этгээд, иргэн бол хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч этгээд, иргэнтэй холбоотой дараах баримт бичгийг нэмж ирүүлнэ. Үүнд:

- 4.1.10.1. Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг;

- 4.1.10.2. Харьяалах улс, оронд гааль, татварын өртэй эсэхийг харуулсан баримт бичиг;

- 4.1.10.3. Харьяалах улс, оронд ял шийтгэлгүй болохыг нотлох баримт бичиг;

4.1.10.4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг.

4.1.11. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд нь энэхүү журмын 3.3-т заасан шаардлагыг хангаж буй эсэх тайлбараа Хавсралт 3-ын дагуу гаргаж ирүүлнэ.

4.2. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бөгөөд уг хуулийн этгээдийн 20 хувиас дээш багцыг эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох бол зөвшөөрөл хүссэн албан бичгээ энэ журмын 4.1-д заасан баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлэх бөгөөд энэ шаардлагыг үүнээс ч илүү үргэлжилсэн хэлхээ холбооны хамааралд тавина.

4.3. Компанийн тухай хуулийн хүрээнд банк хувьцааг буцаан худалдан авах бол зөвшөөрөл хүссэн албан бичгээ дараах баримт бичгийн хамт Монголбанкинд ирүүлнэ. Үүнд:

4.3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр (буцаан худалдан авах хувьцааны тоо, нэг бүрийн үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам, буцаан худалдан авах болсон шалтгаан, халаасны хувьцааг буцааж худалдах хугацаа, журам зэргийг тодорхой дурдсан байна);

4.3.2. Хувьцааг буцаан худалдан авч халаасны хувьцаанд бүртгэсний дараа Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг бүрэн хангаж байгааг харуулсан тооцоо судалгаа, дүгнэлт;

4.3.3. Компанийн тухай хуулийн 49.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигчтэй тохиролцсоны үндсэн дээр хувьцааг буцаан худалдаж авах бол хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээ;

4.3.4. Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн дагуу хувьцаа эзэмшигчийн шаардлагаар банк хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бичгээр гаргасан шаардлага, түүний шалтгаан;

4.4. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах харилцаанд гадаадын харьяалалтай хуулийн этгээд, иргэн оролцсон бол энэ журмын 4.1-4.3-т заасан холбогдох баримт бичгийг тухайн орны хэлээр үйлдэж, нотариатаар баталгаажуулсан монгол болон англи хэл дээрх албан орчуулгын хамт Монголбанкинд ирүүлнэ.

4.5. Монголбанк нь энэ журмын 1.5, 4.1-4.4-д заасан баримт бичгээс гадна нэмэлт мэдээ, баримт материал шаардах эрхтэй бөгөөд банкны хувьцаа эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээдтэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авна.



**ТАВ. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ,  
бүтцэд өөрчлөлт оруулахад бүрдүүлэх баримт  
бичгийг хянах, зөвшөөрөл олгох**

5.1. Монголбанк нь банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлтийг холбогдох зааврын дагуу хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгана.

5.2. Энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт баримт бичиг шаардлагатай тохиолдолд Монголбанк нэмэлт баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрийг хүсэлт хүлээн авсан өдөрт тооцно.

5.3. Монголбанк баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээж авсны дараа банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгийг Монголбанкны дансанд ажлын 5 өдрийн дотор байршуулахыг хүсэлт гаргагчаас шаардаж, хөрөнгийг Монголбанкны дансанд байршуулсан тухай баримтыг холбогдох материалд хавсаргана.

5.4. Монголбанк энэ журмын 1.3-т заасан зөвшөөрлийг олгох эсэх шийдвэрээ энэ журмын 3 дугаар бүлэгт заасан хүсэлт, холбогдох баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор гаргаж, энэ тухай хүсэлт гаргагч банкинд ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

5.5. Монголбанк шаардлагатай гэж үзвэл энэ журмын 5.4-д заасан шийдвэр өгөх хугацааг 30 (гуч) хоногоор сунгаж болно.

5.6. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд Монголбанкны банкны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар, хууль, эрх зүйн асуудал эрхэлсэн газар, төлбөр тооцоо, бүртгэлийн асуудал эрхэлсэн газар, мэдээлэл технологийн асуудал эрхэлсэн газар санал, дүгнэлтээ Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж, шаардлагатай тохиолдолд Монголбанкны Хяналт шалгалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

**ЗУРГАА. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ,  
бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл  
олгохоос татгалзах үндэслэл**

6.1. Монголбанк нь дараах үндэслэлээр зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

6.1.1. Банк, банкны хувьцаа эзэмшигч нь энэ журмын 3 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангаагүй;

6.1.2. Банкны тухай болон Компанийн тухай хууль тогтоомж зөрчсөн;

6.1.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг хангалтгүй, хувьцаа эзэмшигчийн хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого болох нь нотлогдоогүй;

6.1.4. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн гэж Монголбанк үзсэн, үүнийг хүсэлт гаргагч эсрэгээр нотолж чадаагүй;

6.1.5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд тухайн өөрчлөлтийг оруулснаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдал болон

банк, санхүүгийн салбарын тогтолцооны тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй гэж Монголбанк үзсэн;

6.1.6. Монголбанкнаас шаардсан мэдээлэл болон тухайн мэдээллийн нотлох баримтыг ирүүлээгүй, нотлох баримтын үндэслэл, тайлбар нь тодорхойгүй, тэдгээрийг тодорхойлох боломжгүй;

6.1.7. Энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан баримт бичгийг бүрэн гүйцэд ирүүлээгүй;

6.1.8. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгийг энэ журмын 5.3-т заасан шаардлагын дагуу байршуулаагүй;

6.1.9. Бүрдэл дутуу материалыг буцааснаас хойш 30 (гуч) хоногийн дотор холбогдох материалыг ирүүлээгүй.

### **ДОЛОО. Хувьцаа эзэмшигчийн хувийн хэрэг**

7.1. Банк Монголбанкнаас олгосон зөвшөөрлийг үндэслэн шинэ хувьцаа эзэмшигчтэй гэрээ байгуулж, хувьцаа эзэмшигч болсныг гэрчлэх баримтыг хувьцаа эзэмшигчид өгч, банкны хувьцаа эзэмшигчийн бүтцэд бүртгэнэ.

7.2. Банк нь хувьцаа эзэмшигч тус бүрээр хувийн хэрэг нээж, дараах баримт бичгийг хавсарган, бүртгэл хөтөлнө. Үүнд:

7.2.1. Хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийсэн тухай холбогдох шийдвэр;

7.2.2. Монголбанкны зөвшөөрөл;

7.2.3. Банк болон хувьцаа эзэмшигчийн хооронд байгуулсан гэрээ;

7.2.4. Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол Улсын бүртгэлийн гэрчилгээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирлын иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар, хувьцаа эзэмшигч нь иргэн бол иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

7.2.5. Хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрөнгө оруулсан тухай банкны гүйлгээний баримтын нотариатаар баталгаажуулсан хуулбар;

7.2.6. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд орсон өөрчлөлт болон ногдол ашиг хуваарилалтын талаар гаргасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, гүйлгээний баримтын нотариатаар баталгаажуулсан хуулбар;

7.2.7. Хувьцаа эзэмшигч болсныг гэрчлэх баримт;

7.2.8. Банкны дүрэм, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг баталсан хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр.

7.3. Хувьцаат компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан банкны зөвхөн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд хувийн хэрэг нээн хөтөлнө.

### **НАЙМ. Бусад зүйл**

8.1 Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийн өөрчлөлтийн тайланг өөрчлөлт гарах тухай бүр болон хагас жил тутам энэ журмын Хавсралт 2-ын дагуу гаргаж, банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх удирдлагын

гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанкинд ирүүлнэ.

8.2. Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийн өөрчлөлтийн тэмдэглэлийг хийлгэсэн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг энэ журмын 8.1-д заасан тайланд хавсарган ирүүлнэ.

8.3. Хувьцаат компани хэлбэрээр байгуулагдсан банк хувьцааны арилжааны (Хөрөнгийн биржийн) өдөр тутмын мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанкинд ирүүлнэ.

8.4. Банкны хувьцаа эзэмшигч нь гэр бүлийн гишүүнээс бусад этгээдэд бэлэглэлийн гэрээний үндсэн дээр банкны хувьцааг шилжүүлэх замаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт орсон бол бэлэглэлийн гэрээг байгуулснаас хойш 3 (гурван) жилийн хугацаанд банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт тооцохдоо Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс бэлэглэсэн хувьцааны дүнг хасч тооцно.

### **ЕС. Хяналт, хариуцлага**

9.1. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах явц, түүний нягтлан бодох бүртгэлийн ажиллагаанд банкны Төлөөлөн удирдах зөвлөл, Дотоод аудитын алба хяналт тавьж ажиллана.

9.2. Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулсан этгээдэд Банкны тухай хуулийн 36.4 болон холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авна.

..... **БАНКНЫ ХУВЬЦАА**  
**ЭЗЭМШИГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

С. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:			
Оноосон нэр:			
Улсын бүртгэлийн дугаар:			
Регистрийн дугаар:			
Байгуулагдсан огноо:			
Хуулийн этгээдийн улсын харьяалал:			
Үйл ажиллагааны чиглэл:			
Хаяг:			
Цахим хаяг:			
Холбоо барих утас:			
Хувь нийлүүлсэн хөрөнгө			
Огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)	Хувьцааны тоо ширхэг	Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)
...			
Нийт			
Холбогдох этгээдүүд			
	Оноосон нэр (овог, нэр)	Регистрийн дугаар	Эрхэлдэг ажил, албан тушаал
1			
2			
...			

<b>Эрх бүхий албан тушаалтан</b>		
1	Албан тушаал:	
	Овог, нэр:	
	Регистрийн дугаар:	
	Яс, үндэс:	
	Иргэншил:	
	Оршин суугаа хаяг:	
	Цахим шуудангийн хаяг:	
	Холбоо барих утас:	
...		

**Гүйцэтгэх удирдлагын түүх (он дарааллаар бичнэ үү)**

	Албан тушаал	Овог нэр	Хугацаа
1			
2			
3			
...			

**Хараат болон охин компанитай бол доорх хүснэгтийг бөглөнө үү**

	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар
1				
2				
3				
...				

**Өөр хуулийн этгээд, банкинд хувь эзэмшдэг бол доорхыг бөглөнө үү**

	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь
1		
2		
...		

Хэрэв хувьцаа эзэмшигч хуулийн этгээд нь аливаа нэг хуулийн этгээдийн охин эсвэл хараат компани бол толгой компанийн тухай мэдээллийг доорх хүснэгтэд бөглөнө үү.

Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	
Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар	
Үйл ажиллагааны чиглэл	
Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нийт хувьцааны 5%-аас илүү хувийг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг хувь хүн, тэдгээрийн холбогдох этгээдийн тухай мэдээллийг доорх хүснэгтэд бөглөнө үү.	
Овог, нэр	Регистрийн дугаар
	Эзэмшлийн хувь

1			
2			
...			
Хувьцаа эзэмшигчдийн бүтцийг диаграмм хэлбэрээр доорх хүснэгтэд оруулна уу			
(Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн охин болон хараат компани, хувьцаа эзэмшдэг компани, үүсгэн байгуулагчийн толгой компани болон хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн эзэмшлийн хувийг харуулсан нарийвчилсан диаграммыг энд зурна уу)			
Харилцагч банк			
1			
2			
...			

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)

..... оны ..... сарын .....-ний өдөр

<b>В. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУВЬ ХҮН БОЛ:</b>			
Ургийн овог:		3x4 харьцаатай сүүлийн зургаан сарын дотор авахуулсан өнгөт цээж зураг	
Овог:			
Нэр:			
Төрсөн огноо:			
Регистрийн дугаар:			
Яс, үндэс:			
Иргэншил:			
Оршин суугаа хаяг:			
Цахим шуудангийн хаяг:			
Суурин болон гар утасны дугаар:			
Ажил эрхлэлт:			
Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал			
Ажлын хаяг, утасны дугаар			
Урьд өмнө эрхэлж байсан ажил, албан тушаал <i>(он дарааллаар бичнэ үү)</i>			
Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.			
	Байгууллагын нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар
1			
2			
...			
Хуулийн этгээд, банкны хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол доорхыг бөглөнө үү.			
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар
1			
2			
...			
Гэр бүл, хамтран амьдрагчийн мэдээллийг доорх хүснэгтэд оруулна уу.			
	Овог, нэр, Регистрийн дугаар	Таны юу болох	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал
1			

2			
...			
Харилцагч банк			
1			
...			

Хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэх/паспортын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны ..... сарын .....-ний өдөр



## ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

..... оны ..... сарын .....-ний өдрийн байдлаар

### 1. Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өөрчлөлт

	Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл (он/сар/өдөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд гарсан өөрчлөлт (+,-)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл (он/сар/өдөр)
1				
2				
...				

### 3. Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмж оруулсан хөрөнгийн гүйлгээний тэмдэглэл

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	Хувь нийлүүлсэн хөрөнгөд нэмж оруулсан хөрөнгө (төгрөгөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

### 5. Өрийг хувьцаанд шилжүүлсэн гүйлгээний тэмдэглэл

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	Хувьцаанд шилжүүлсэн өрийн мөнгөн дүн (төгрөгөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

**7. Ногдол ашиг хуваарилсан гүйлгээний тэмдэглэл**

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	Хуваарилсан ногдол ашгийн мөнгөн дүн (төгрөгөөр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

**9. Хувьцааг буцаан худалдан авсан гүйлгээний тэмдэглэл**

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Буцаан худалдан авсан хувьцааны мөнгөн дүн	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эхний үлдэгдэл	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

**11. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлсэн (худалдсан, шүүхийн болон эрх хүлээн авагчийн шийдвэрээр хасалт хийсэн болон нэмсэн, гэрээслэлээр өвлөх, бэлэглэлийн гэрээ болон бусад хууль ёсны замаар хувьцаа шилжүүлсэн) тухай тэмдэглэл**

	Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дугаар, огноо	Өмчлөлийг шилжүүлсэн хувьцааны мөнгөн дүн	Өмчлөлийг шилжүүлэн өгсөн хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Өмчлөлийг шилжүүлэн авсан этгээдийн овог, нэр	Гүйлгээ хийсэн нягтлан бодогч (гарын үсэг, тэмдэг)
1						
2						
...						

“Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын Хавсралт 3

**..... БАНКНЫ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ  
БОЛОХ ЭТГЭЭД, БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,  
ГИШҮҮН, БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД  
ТОМИЛОГДОХ ЭТГЭЭДИЙН АСУУЛГА**

1	Та өөр улсын эрх бүхий байгууллагад зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байсан уу? Таны хүсэлтийг хүлээж аваагүй, эсвэл татгалзсан тохиолдол бий юу?	
2	Та аль нэг улсад иргэний, эрүүгийн шүүхийн шийдвэрээр ял, шийтгэл эдэлж байсан уу (18 нас хүрэхээс өмнө үйлдэж байсан гэмт хэрэг, тээврийн хэрэгсэл эзэмшихтэй холбоотой зөрчлийг хялбарчилсан журмаар шийдвэрлэсэн бол энд хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
3	Санхүүгийн байгууллагатай холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
4	Та гишүүн байсан мэргэжлийн байгууллагын шийдвэрээр сахилгын хариуцлага хүлээж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
5	Та өмнө нь луйвар, залилан, эсвэл ижил төрлийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй орлогын талаар мэдүүлэг өгч байсан уу (хараат бус шинжээчээр ажиллаж байсан бол хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
6	Та, эсвэл таны хувьцаа эзэмшдэг, захирал, гүйцэтгэх удирдлага, мөн/эсвэл ажилтнаар нь ажилладаг, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлдэг байгууллага, нөхөрлөл нь төрийн, мэргэжлийн, эсвэл бусад төрлийн зохицуулагч байгууллагын зүгээс мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.	
7	Таныг албан тушаалаас тань огцруулж байсан, эсвэл албан тушаалд томилогдохтой холбогдуулан татгалзаж байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.	
8	Таныг өөр улсад шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцож байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.	
9	Та өөр улсад шүүхийн шийдвэрээр төлбөр барагдуулах шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болж байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.	
10	Та хуулийн этгээд үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлдэгтэй холбоотой, эсвэл хуулийн этгээдийн удирдлага, ажилтны эсрэг залилан, эрх мэдлээ урвуулан ашиглах, бусад албан тушаалын гэмт хэрэгт холбогдон аль нэг улсад иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэгдэн шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
11	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, эсвэл ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл нь өр төлбөрөө бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн барагдуулж чадаагүй тохиолдол бий юу? Таныг албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа нэг жилийн дотор ийм тохиолдол гарсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
12	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөө цуцлуулж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	

13	Та итгэлцэл, фидуци болон эдгээртэй адилтгах бусад төсөөтэй харилцааг тодорхой шалтгааны улмаас шаардсаны дагуу дуусгавар болгож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
14	Та энэ байгууллагад хэн нэгэн гуравдагч этгээдийн удирдлага, зааварчилгааны дор ажиллах/ажиллаж байна уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
15	Та холбогдох хууль эрх зүй, зохицуулалтын болон мэргэжлийн стандарт шаардлагыг дагаж мөрдөхөд бэлэн үү?	

Би энэ тодорхойлолтыг бөглөн өгснөөр мэдүүлсэн бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг баталж байна. Мөн дээр дурдсан хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын захирал, гүйцэтгэх удирдлагаар ажиллах хугацаанд, эсвэл хувьцаа эзэмшигч байх, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэх хугацаанд энэ асуулгад мэдүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд эрх бүхий байгууллагад 21 хоногийн дотор мэдэгдэх болно.

Овог, нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_

Огноо \_\_\_\_\_

Монголбанкны Ерөнхийлөгчийн  
2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн  
А-82 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

**БАНК БАЙГУУЛАХ, БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ, БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХҮСЭЛТ,  
ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГИЙГ ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ ЗААВАР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэ зааврын зорилго нь банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт, баримтыг хүлээн авах, холбогдох журмын дагуу хянах, шийдвэрлэхэд ашиглана.
- 1.2. Монголбанкны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар нь банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт, баримт бичгийг Банкны тухай хууль, “Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам”, “Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”, “Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын шаардлагыг хангасан эсэхийг судалж, санал дүгнэлт боловсруулна.

**Хоёр. Хүсэлт, баримт бичгийг хянах**

- 2.1. Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт, баримт бичгийг шалгаж, холбогдох журмын дагуу бүрэн гүйцэд ирүүлсэн тохиолдолд хянана.
- 2.2. Банк байгуулах хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрдлийг энэ зааврын Хавсралт 1-ийн дагуу шалгана.
- 2.3. Баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт баримт бичиг шаардлагатай тохиолдолд энэ тухай хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 2.4. Нэмэлт баримт бичгийг Монголбанкинд бүрэн гүйцэд хүлээн авсан өдрийг хүсэлт хүлээн авсан өдөрт тооцно.
- 2.5. Банк байгуулах хүсэлт, баримт бичгийг доор заасан үзүүлэлтээр хянан, санал дүгнэлт боловсруулна. Үүнд:
  - 2.5.1. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээд нь зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй эсэх, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй эсэх;
  - 2.5.2. Банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй, ял шийтгэлгүй эсэх;

- 2.5.3. Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд, түүний холбогдох этгээд нь өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсэх;
- 2.5.4. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүрдүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ хангалттай эсэх;
- 2.5.5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлэх мөнгөн хөрөнгө нь банк байгуулагч, хувьцаа эзэмшигч болох этгээдийн татвар төлсөн, хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого мөн эсэх;
- 2.5.6. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлэх мөнгөн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг хангалттай эсэх;
- 2.5.7. Банкны ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагад томилогдох этгээд нь зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй эсэх, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй эсэх;
- 2.5.8. Банкны ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагад томилогдох этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй, ял шийтгэлгүй эсэх;
- 2.5.9. Банкны ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагад томилогдох этгээд нь “Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам”-д заасан, банкны эрх бүхий албан тушаалтанд тавигдах боловсрол, туршлага, ёс зүйн шаардлагыг хангаж байгаа эсэх;
- 2.5.10. Банкны бизнес төлөвлөгөөг тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нягтрал, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, хэмжээ, эх үүсвэр татах чадвар, хөрөнгө байршуулах бодит шаардлага гэх мэт гадаад, дотоод хүчин зүйлсийг харгалзан банкны эрхлэх үйл ажиллагаа, ажил үйлчилгээний хамрах хүрээг тодорхойлж, тооцоолсон эсэх;
- 2.5.11. Банкны бизнес төлөвлөгөө бодитой, хэрэгжих боломжтой эсэх;
- 2.5.12. Банк байгуулснаар үндэсний эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэхүйц ач холбогдолтой талаар тодорхой судалгаа хийж, дүгнэлт гаргасан эсэх;
- 2.5.13. Хууль, эрх зүйн асуудал эрхэлсэн газартай хамтран банкны бодлого, үйл ажиллагааг тусгасан эрх зүйн баримт бичиг нь хууль тогтоомжид нийцсэн эсэх дүгнэлт;
- 2.5.14. Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгө болон бусад эх үүсвэрийг эрсдэлээс хамгаалах чадвартай эсэх;
- 2.5.15. Банкны зохистой засаглал, зохион байгуулалт, банкинд учирсан болон учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, дүгнэх чадвартай эсэх, хяналтын удирдлагын шат бүр хэрэгжүүлэх давхар хяналтын системийг бүрдүүлж, хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг хууль тогтоомжид заасны дагуу тодорхой тусгаж чадсан эсэх;
- 2.5.16. Банкны үйл ажиллагааг явуулах техник, тоног төхөөрөмж, программ

- хангамж, ажлын байр нь найдвартай, тогтвортой ажиллагааг хангасан эсэх, шаардлага хангасан нөөц төвтэй эсэх, Монголбанкны банк хоорондын сүлжээ, зээлийн мэдээллийн сантай холбогдон ажиллах бэлтгэл хангагдсан эсэх;
- 2.5.17. Банк байгуулагдсанаар банк, санхүүгийн салбарт гарах нөлөөлөл;
- 2.5.18. Банкны тухай хууль, журамд заасан бусад шалгуур үзүүлэлтүүд.
- 2.6. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрлийн хүсэлт, баримт бичгийг доор заасан үзүүлэлтээр хянан, санал дүгнэлт боловсруулна. Үүнд:
- 2.6.1. Банк нь Банкны тухай хуулийн 16, 17 дугаар зүйл, Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 6 сарын турш хангасан эсэх;
- 2.6.2. Банк нь Монголбанкнаас хамгийн сүүлд хийгдсэн газар дээрх иж бүрэн шалгалтаар “Сайн” ба түүнээс дээш үнэлгээ авсан эсэх;
- 2.6.3. Монголбанкны шалгалтын дагуу өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлсэн эсэх;
- 2.6.4. Банкны зохистой засаглалын үнэлгээ нь “Дунд” ба түүнээс дээш эсэх;
- 2.6.5. Банк тухайн үйл ажиллагааг эрхэлснээр банк, санхүүгийн салбарт гарах нөлөөлөл,
- 2.6.6. Банкны тухай хууль, журамд заасан бусад шалгуур үзүүлэлтүүд.
- 2.7. Банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрлийн хүсэлт, баримт бичгийг доор заасан үзүүлэлтээр хянан, санал дүгнэлт боловсруулна. Үүнд:
- 2.7.1. Банкны хувьцаа эзэмшигч нь зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй эсэх, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй эсэх;
- 2.7.2. Банкны хувьцаа эзэмшигч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй, ял шийтгэлгүй эсэх;
- 2.7.3. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд нь өөр банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсэх;
- 2.7.4. Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох этгээд, түүний холбогдох этгээд нь өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсэх;
- 2.7.5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулах мөнгөн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчийн татвар төлсөн, хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого мөн эсэх;
- 2.7.6. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлэх мөнгөн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг хангалттай эсэх;
- 2.7.7. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд орох өөрчлөлт нь Банкны тухай хууль, “Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын

шаардлагыг хангаж байгаа эсэх;

2.7.8. Банкны тухай хууль, журамд заасан бусад шалгуур үзүүлэлтүүд.

2.8. Хүсэлт, холбогдох баримт бичгийг хянахдаа банк байгуулагч, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтнууд нь зээл батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа өртэй эсэх, ял шийтгэлтэй эсэх, эдийн засгийн болон аж ахуйн эсрэг гэмт хэрэг, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцож байсан эсэх талаарх тодорхойлолтуудыг эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авна.

### **Гурав. Хүсэлтийг шийдвэрлэх**

3.1. Баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт баримт бичиг шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагч банкинд энэ талаар албан бичгээр, эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.

3.2. Баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрийг хүсэлт хүлээн авсан өдөрт тооцно.

3.3. Монголбанк нь банк байгуулах тусгай зөвшөөрлийг олгох эсэх шийдвэрээ хүсэлт, баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор гаргаж, энэ тухай хүсэлт гаргагчид ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3.4. Монголбанк нь банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох эсэх шийдвэрээ хүсэлт, баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, энэ тухай хүсэлт гаргагч банкинд ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3.5. Монголбанк нь банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг олгох эсэх шийдвэрээ хүсэлт, баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээж авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, энэ тухай хүсэлт гаргагчид ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3.6. Монголбанк шаардлагатай гэж үзвэл энэ зааврын 3.5-д заасан шийдвэр өгөх хугацааг 30 хоногоор сунгаж болно.

3.7. Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох боломжгүй гэж үзсэн тохиолдолд Монголбанкны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар холбогдох дүгнэлт, саналыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж, хүсэлт гаргагчид албан бичгээр хариуг хүргүүлнэ.

3.8. Банк байгуулах, банкны нэмэлт үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт, баримт бичиг нь шаардлагыг бүрэн хангасан, холбогдох зөвшөөрөл олгох боломжтой гэж Монголбанкны хяналт шалгалтын газар үзсэн тохиолдолд хууль, эрх зүйн асуудал эрхэлсэн газар, төлбөр тооцоо, бүртгэлийн асуудал эрхэлсэн газар, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн газар, зах зээлийн асуудал эрхэлсэн газраас дүгнэлт, санал авна.

3.9. Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд



Монголанкны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар нь хууль, эрх зүйн асуудал эрхэлсэн газар, төлбөр тооцоо, бүртгэлийн асуудал эрхэлсэн газар, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн газрын дүгнэлт, саналыг нэгтгэж, банк байгуулах зөвшөөрөл олгох асуудлыг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

- 3.10. Банк байгуулах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэр гарсан тохиолдолд тухайн банкинд Гэрчилгээ олгож, хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар нл банкнийг бүртгэж, зохих журам, зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.
- 3.11. Банк байгуулах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэр гарсан тохиолдолд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн газар, төлбөр тооцоо бүртгэлийн асуудал эрхэлсэн газар нь банкны ажиллах байр, програм хангамж, техник, тоног төхөөрөмж, нөөц төв, үйл ажиллагаа эрхлэх аюулгүй орчин байдал нь шаардлага хангасан эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 3.12. Банкны үйл ажиллагаа эрхлэх нэмэлт зөвшөөрөл, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар нь хууль, эрх зүйн асуудал эрхэлсэн газар, төлбөр тооцоо, бүртгэлийн асуудал эрхэлсэн газар, мэдээллийн технологийн асуудал газар, валютын зах зээлийн асуудал эрхэлсэн газрын дүгнэлт, саналыг нэгтгэн, Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж, шаардлагатай тохиолдолд Монголбанкны Хяналт шалгалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.
- 3.13. Банкны үйл ажиллагаа эрхлэх, эсвэл банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэр гарсан тохиолдолд Хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар зохих журам, зааврын дагуу тухайн банкны Зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад тэмдэглэл хийж, улсын байцаагчийн тэмдэг дарна.

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн  
санд 2019 оны 6 сарын 5-ны өдрийн 4388 дугаарт бүртгэв.*

## **МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 23

Дугаар А-138

Улаанбаатар хот

### **Журам шинэчлэн батлах тухай**

Төв банк/Монголбанк/-ны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 2.23, 2.25-д тусгасан нэгж хувь, 5.1, 5.3 дахь заалт, 2.5-д тусгасан хөшүүргийн харьцааны доод хэмжээнээс бусад зохицуулалтыг 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А-57 дугаар тушаалыг мөн өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т үүрэг болгосугай.

**МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАЯРТСАЙХАН**

*Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А-138 дугаар тушаалын хавсралт*

## **БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь Төв банк/Монголбанк/-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн 16.1.1-16.1.2 заалтын дагуу Монголбанкнаас банкинд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнийг мөрдүүлэх, хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Банк дараах зохистой харьцааг хангаж ажиллана:

- 1.2.1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, түүнийг хамгаалах нөөц;
- 1.2.2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа;
- 1.2.3. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа;
- 1.2.4. Төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа.

1.3. Банк энэ журмын 1.2-т заасан зохистой харьцааны үзүүлэлтийг үнэн зөв тооцож, түүнд үнэлэлт, дүгнэлт хийх замаар үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авна.

1.4. Монголбанк банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, эрсдэлийн түвшинг харгалзан Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн 16.1.2-т заасны дагуу энэхүү журмын 1.2-т тусгаснаас бусад зохистой харьцааг тогтоон, мөрдүүлж болно.

### **ХОЁР. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХ НӨӨЦ**

2.1. Банкны эрсдэл даах чадварыг Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 хэсгийн 3.1.9 дэх заалтад тусгасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээр үнэлж, дараах зохистой харьцааг тогтооно:

- 2.1.1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа;
- 2.1.2. Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа;
- 2.1.3. Хөшүүргийн харьцаа.

2.2. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг энэ журмын 2.7-д заасан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 2.12-т заасны дагуу тохируулан, 2.14-т тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулан тооцно.

2.3. Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг энэ журмын 2.6-д заасан өөрийн хөрөнгийг 2.12-т заасны дагуу тохируулан, 2.14-т тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулан тооцно.

2.4. Хөшүүргийн харьцааг энэ журмын 2.7-д заасан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 2.12-т заасны дагуу тохируулан, арилжааны авлага, өглөгийн зөрүүгээр цэвэршүүлсэн нийт актив болон цэвэр хүлээж болох үүргийн 50 хувийн нийлбэрт харьцуулан тооцно.

2.5. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны доод хэмжээ 9 хувь, Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны доод хэмжээ 12 хувь, Хөшүүргийн харьцааны доод хэмжээ 5 хувь байна.

2.6. Банкны өөрийн хөрөнгө нь нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн нийлбэр байна.

2.7. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна:

- 2.7.1. Энгийн хувьцаа;
- 2.7.2. Энгийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал;
- 2.7.3. Хуримтлагдсан ашиг, алдагдал;
- 2.7.4. Нөөцийн сан.

2.8. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна:

- 2.8.1. Давуу эрхийн хувьцаа;
- 2.8.2. Давуу эрхийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал;
- 2.8.3. Хувьцаанд хөрвөх эх үүсвэр;
- 2.8.4. Хоёрдогч өглөг.

2.9. Дараах нөхцөлтэй давуу эрхийн хувьцааг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулан тооцно:

- 2.9.1. Хугацаагүй, Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас өмнө банк эргүүлэн худалдаж авах үүрэг, үүнтэй адилгах бусад төлбөрийн үүрэг хүлээгээгүй;
- 2.9.2. Банк ногдол ашиг тогтмол төлөх үүрэггүй;
- 2.9.3. Энэ журмын 2.28.2, 2.29.4-г тусгасан хязгаарлалт хэрэгжих боломжтой;
- 2.9.4. Ногдол ашгаас өөр хэлбэрээр өгөөж төлөх бүтэцгүй;
- 2.9.5. Давуу эрхийн хувьцаа худалдан авах эх үүсвэр нь хууль ёсны үйл ажиллагаанаас бүрдсэн, татвар төлсний дараах орлого байна;

2.9.6. Энэ журмын 2.9.1-2.9.5-д заасан нөхцлийг давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэр, холбогдох гэрээ, хэлцэлд тусгасан байна.

2.10. Дараах нөхцөлтэй хувьцаанд хөрвөх эх үүсвэрийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулан тооцно:

- 2.10.1. 5 ба түүний дээш жилийн хугацаатай;
- 2.10.2. Нийт хугацаанд үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийхгүй;
- 2.10.3. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 7.2 хувиас буурсан тохиолдолд үл маргах журмаар энгийн хувьцаанд хөрвөх;
- 2.10.4. Энэ журмын 2.28.4, 2.29.4-т тусгасан хязгаарлалт хэрэгжих;
- 2.10.5. Хүү, өгөөж нь өсөн нэмэгдэхгүй (no step-up);
- 2.10.6. Банк, банкны нэгдэлд оролцогч, банкны холбогдох этгээдийн хөрөнгийг барьцаалаагүй, эргэн төлөлтөд баталгаа, батлан даалт гаргуулаагүй;
- 2.10.7. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авч хугацаанаас нь өмнө хэсэгчлэн эсвэл бүрэн буцаан төлж болох. Төлсний дараа банк энэ журмын 2.22-оор тогтоосон нөөцөө хангасан байна;
- 2.10.8. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авч хөрөнгө оруулагчийг сольж болно;
- 2.10.9. Хөрөнгө оруулагч, эх үүсвэр нь банкны зөвшөөрлийн журамд заасан шаардлагыг хангасан;
- 2.10.10. Энэ журмын 2.10.1-2.10.8-д заасан нөхцөлийг холбогдох гэрээ, хэлцэлд тусгасан байна.

2.11. Дараах нөхцөлтэй хоёрдогч өглөгийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулан тооцна. Үүнд:

- 2.11.1. 5 ба түүний дээш жилийн хугацаатай, хугацааны эцэст банкны хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч харилцан тохиролцож энгийн хувьцаанд хөрвөж болох;
- 2.11.2. Нийт хугацаанд үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийхгүй;
- 2.11.3. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 5.4 хувиас буурсан тохиолдолд үл маргах журмаар энгийн хувьцаанд хөрвөх;
- 2.11.4. Энэ журмын 2.28.4, 2.29.4-д тусгасан хязгаарлалт хэрэгжих;
- 2.11.5. Хүү, өгөөж нь өсөн нэмэгдэхгүй (no step-up);
- 2.11.6. Банк, банкны нэгдэлд оролцогч, банкны холбогдох этгээдийн хөрөнгийг барьцаалаагүй, эргэн төлөлтөд баталгаа, батлан даалт гаргуулаагүй;
- 2.11.7. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авч хугацаанаас нь өмнө хэсэгчлэн эсвэл бүрэн буцаан төлж болно. Ингэхдээ банк энэ

- журмын 2.22 дахь заалтаар тогтоосон нөөцөө хангасан байна;
- 2.11.8. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авч хөрөнгө оруулагчийг сольж болно;
- 2.11.9. Хөрөнгө оруулагч, эх үүсвэр нь банкны зөвшөөрлийн журмаар тавигдаж буй шаардлагыг хангасан;
- 2.11.10. Энэ журмын 2.11.1-2.11.9-д заасан нөхцөлийг холбогдох гэрээ, хэлцэлд тусгасан байна
- 2.12. Банкны өөрийн хөрөнгөд дараах тохируулгыг дараалуулан хийнэ. Үүнд:
- 2.12.1. Банкны халаасны энгийн хувьцааг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, халаасны давуу эрхийн хувьцааг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна;
- 2.12.2. Гүүдвиллийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна;
- 2.12.3. Програм хангамж, хойшлогдсон татварын авлагын нийлбэр нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтэрсэн бол хэтэрсэн хэсгийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна;
- 2.12.4. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлээр тогтоогдсон хязгаарлалтыг давсан хэсгийг 75 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, үлдсэн 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө хүрэлцэхгүй бол нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс үлдсэн хэсгийг хасна;
- 2.12.5. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүнгийн 50 хувиас илүүгүй байна.
- 2.13. Монголбанк, эрх бүхий байгууллагын шаардлагаар буюу хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж өөрийн хөрөнгийн бодит дүнг гаргана.
- 2.14. Банкны эрсдэлээр жигнэсэн актив дараах бүрэлдэхүүнтэй байна:
- 2.14.1. Зээлийн эрсдэлээр жигнэсэн актив;
- 2.14.2. Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн актив;
- 2.14.3. Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн актив.
- 2.15. Зээлийн эрсдэлээр жигнэсэн активын дүнг тооцохдоо тэнцлийн актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан эрсдэлийн хувиар үржүүлж гаргах бөгөөд дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 2.15.1. Актив нь энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан нэгээс олон ангилалд хамаарч байгаа бол хамгийн өндөр эрсдэлийн жинтэй ангилалд хамааруулна;
- 2.15.2. Стандарт энд Пурс (Standard & Poors), Муудиз (Moody's), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон зээлжих суурь (baseline) зэрэглэлийг ашиглан гадаадын банкнаас авах авлагын эрсдэлийн хувь хэмжээг дараах хүснэгтийг үндэслэн тогтооно.

Стандарт энд Пурс	AAA / AA-	A+ / A-	BBB+ / BBB-	BB+ / B-	B- бага	Рейтинггүй банк
Фич						
Мууди	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	
3 сараас дээш хугацаатай авлага	20%	50%	50%	100%	150%	100%
3 сар хүртэл хугацаатай авлага	20%	20%	20%	50%	150%	100%

2.15.3. Энэ журмын 2.15.2-т заасан 2 болон түүнээс дээш зэрэглэл тогтоох байгууллагаас зээлжих зэрэглэл тогтоолгосон гадаадын банкнаас авах авлага болон түүний батлан даалтаар баталгаажсан зээлийн эрсдэлийн хувь хэмжээг тооцохдоо хамгийн доод зэрэглэлийг ашиглана;

2.16. Эрсдэлээр жигнэх тэнцлийн болон тэнцлийн гадуурх активын үлдэгдэлд дараах тохируулгыг хийнэ:

2.16.1. Актив нь Монгол Улсын Засгийн газрын баталгаа, олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч байгууллагын “А”-аас доошгүй үнэлгээ бүхий санхүүгийн байгууллагаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол баталгааны дүнгийн 80 хувиар цэвэршүүлнэ;

2.16.2. Актив нь Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн хөгжлийн банкнаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол баталгааны дүнгээр цэвэршүүлнэ;

2.16.3. Актив нь дотоодын банк, Монгол Улсын Засгийн газраас үүсгэн байгуулсан Зээлийн батлан даалтын сантай эрсдэл хуваах нөхцөлтэй (syndicated loans гэх мэт) бол харгалзах дүнгээр тухайн банкны активыг цэвэршүүлж, эрсдэл хуваагч банкны активыг нэмэгдүүлнэ. Нэгдмэл ашиг сонирхолтой, холбоотой банкуудад энэ зохицуулалт хамаарахгүй;

2.16.4. Тухайн активд зориулж тусгайлан байгуулсан сангаар цэвэршүүлнэ;

2.16.5. Актив нь үл маргах журмаар цэвэршүүлэх нөхцөлтэй тухайн банкинд байршуулсан санхүүгийн эх үүсвэр болон сорьцоор баталгаажсан алт, мөнгөн гулдмайгаар баталгаажсан бол харгалзах (спот) дүнгээр цэвэршүүлнэ.

2.17. Зээлийн эрсдэлээр жигнэсэн активын нийлбэрээс зээлийн бүлгийн эрсдэлийн сан, тархаалтын эрсдэлийн сан, ерөнхий эрсдэлийн сангийн нийлбэрийг хасна.

2.18. Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн активыг энэ журмын 4.3-т тусгасан нийт нээлттэй позицгийн дүнгээр тодорхойлно.

2.19. Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн активыг тухайн банкны сүүлийн гурван жилийн нийт орлогын дунджийн 1 хувийг түүнд тогтоосон өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааны доод хэмжээний урвуугаар үржүүлэн тодорхойлно. Банк өдөр дутмын үйл ажиллагаанд үүсч байгаа алдагдал, хохирлыг бүртгэнэ.

2.20. Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, эрсдэл даах чадварыг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр Монголбанкинд хүргүүлнэ.

2.21. Банкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервалыг бүх банкинд тогтооно.

2.22. Нөөц интервал нь суурь болон тусгай хэсгийн нийлбэрээс бүрдэх бөгөөд энэ журмын 2.5-д заасан банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын доод хэмжээн дээр нэмэгдэнэ.

2.23. Суурь хэсэг бүх банкинд хамаарах 2 нэгж хувь байх бол тусгай хэсэг нь зөвхөн системийн нөлөө бүхий банкинд хамаарна.

2.24. Банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтыг хууль, журамд заасныг баримтлан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

2.25. Тусгай хэсэг нь тогтмол болон хувьсах бүрэлдэхүүнтэй байна. Тогтмол хэсэг нь 1 нэгж хувь байх бол хувьсах хэсгийг дараах хүснэгтийн дагуу тооцно.

№	Үзүүлэлтүүд	Тайлбар	Шаардлага	
2.25.1	Системийн нийт активд эзлэх хувь	Өмнөх жилийн эцсийн үзүүлэлтээр	15%-аас бага бол 0%	15%-аас их бол +0.5%
2.25.2	Нийт банк хоорондын дамжуулсан гүйлгээний тоонд эзлэх хувь	Өмнөх жилд хийгдсэн нийт тоогоор	10%-аас бага бол 0%	10%-аас их бол +0.25%
2.25.3	Нийт иргэдийн зээлд эзлэх хувь, нийт байгууллагын зээлд эзлэх хувь хоёрын хамгийн их	Өмнөх жилийн эцсийн үзүүлэлтээр	10%-аас бага бол 0%	10%-аас их бол +0.25%

2.26. Монголбанкнаас хувьсах хэсгийг жилд нэгээс дээшгүй удаа шинэчлэн тогтоож, холбогдох банкуудад мэдээлнэ.

2.27. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа нь зохистой харьцааны доод хэмжээ болон тухайн банкинд тогтоосон нөөц интервалын нийлбэрээс бага бол нөөц алдагдсанд тооцно.

2.28. Тухайн банкинд тогтоосон нөөц 50 хүртэл хувиар алдагдсан тохиолдолд орлого, ашиг, нөөцөө хамгаалах, эрсдэл даах чадварыг улам муутгах зарцуулалт хийхээс сэргийлэх зорилгоор банк дараах арга хэмжээг авна:

2.28.1. Хувьцаа буцаан худалдаж авахгүй;

2.28.2. Энгийн болон давуу эрхийн хувьцаанд ноогдол ашиг хуваарлахгүй;

2.28.3. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагад олгох урамшуулал, бусад төрлийн гүйцэтгэлд суурилсан нэмэгдлийн 50-иас илүү хувийг төлөхгүй;



2.28.4. Энэ журмын 2.10 заалтыг хангасан хөрвөх эх үүсвэр болон 2.11 заалтыг хангасан хоёрдогч өглөгт хуваарын дагуу эргэн төлөх төлбөрийн 50-иас илүү хувийг төлөхгүй;

2.29. Тухайн банкинд тогтоосон нөөц 50 ба түүнээс илүү хувиар алдагдсан тохиолдолд орлого, ашиг, нөөцөө хамгаалж, эрсдэл даах болон төлбөрийн чадвараа хадгалах зорилгоор банк дараах арга хэмжээг авна:

2.29.1. Энэ журмын 2.28.1, 2.28.2 дахь заалтад тусгасан арга хэмжээ;

2.29.2. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагын цалин, түүнтэй адилтгах бусад хөнгөлөлт, нэмэгдлийг өсгөхгүй;

2.29.3. Төлөөлөх болон гүйцэтгэх удирдлагад олгох урамшуулал, бусад төрлийн гүйцэтгэлд суурилсан аливаа нэмэгдлийг олгохгүй;

2.29.4. Энэ журмын 2.9-2.11 дэх заалтыг хангасан давуу эрхийн хувьцаа, хувьцаанд хөрвөх эх үүсвэр, хоёрдогч өглөгтэй холбоотой аливаа төлөлт хийхгүй.

2.30. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа алдагдсан бол банк дараах арга хэмжээг авна:

2.30.1. Энэ журмын 2.29-д заасан арга хэмжээ;

2.30.2. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагад цалин, түүнтэй адилтгах хөлс, бусад нэмэгдэл, дэмжлэг, хандив олгохгүй;

2.30.3. Банкны удирдлага хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг энгийн хувьцаанд хөрвөх арга хэмжээний бэлтгэлийг Компаний тухай хууль, банкны дүрэм, бусад эрх зүйн актад нийцүүлэн яаралтай гүйцэтгэж, үр дүнг Монгобанкинд мэдээлнэ.

2.31. Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг хувьцаанд хөрвүүлэхэд дараах дарааллыг баримтлана:

2.31.1. Хувь нийлүүлэгч, холбогдох этгээдийн хувьцаанд эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг бүхэлд нь;

2.31.2. Энэ журмын 2.31.1-т тусгасан арга хэмжээ авсны дараа нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа хангагдаагүй бол бусад хөрөнгө оруулагчийн эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг хэсэгчлэн, эсвэл бүхэлд нь.

## **ГУРАВ. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА**

3.1. Харилцагчийн анхны шаардлагаар төлбөр гүйцэтгэх банкны чадварыг хангах, банкны актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилгоор Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тогтооно.

3.2. Энэ журмын 3.1-д тусгасан зохистой харьцааны доод хэмжээ 25 хувь байна.

3.3. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг энэ журмын 3.4-д заасны дагуу тохируулсан түргэн борлогдох хөрөнгийг 3.6-д заасны дагуу тохируулсан бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд харьцуулан тооцно. Биелэлтийг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу долоо хоног болон сар бүр ирүүлнэ.

3.4. Түргэн борлогдох хөрөнгөд бэлэн мөнгө, Монголбанкинд байршуулсан хөрөнгө, банк хоорондын захаас авах цэвэр авлага, Стандарт энд Пурс (Standard & Poors), Муудиз (Moody's), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон “BBB-”-аас доошгүй үнэлгээ бүхий гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, сорьцоор баталгаажсан алтан, мөнгөн гулдмай, Монгол Улсын Төв банкны үнэт цаас, Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, Монгол Улсын Засгийн газрын баталгаатай үнэт цаасны дүнг нэмж тодорхойлох бөгөөд дараах тохируулгуудыг гүйцэтгэнэ:

3.4.1. Клирингийн дамжуулалтын саатлын дансдын үлдэгдлийг хасах;

3.4.2. Аливаа санхүүгийн хэлцлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалсан, байршуулсан түргэн борлогдох хөрөнгийг хасах;

3.4.3. Гэрээний үндсэн дээр хугацаа, хүүгийн хэмжээг тохироогүй, захиран зарцуулах эрх нь шилжин ирээгүй түргэн борлогдох хөрөнгийг хасах;

3.4.4. Монголбанкнаас банк байгуулах зөвшөөрлийг нь хүчингүй болгосон, банкны бүрэн эрхт төлөөлөгч, тусгай төлөөлөгч, эрх хүлээн авагч томилсон банкнаас авах авлагыг банк хоорондын захын цэвэр авлагын тооцоонд оруулахгүй;

3.4.5. Замд яваа мөнгийг түргэн борлогдох хөрөнгөөс хасах.

3.5. Монголбанкны шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж түргэн борлогдох хөрөнгийн бодит дүнг гаргана.

3.6. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцах, хадгаламж, банк хоорондын захын цэвэр өглөг, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, бусад өр төлбөр, арилжааны цэвэр өглөг, тэдгээрт хуримтлуулан тооцсон хүүгийн өглөг, биелэх нь тодорхой болсон хүлээж болох үүргийн дүнг нэмж тооцох бөгөөд дараах тохируулгыг гүйцэтгэнэ:

- 3.6.1. Клирингийн дамжуулалтын саатлын дансдын үлдэгдлийг хасах;
- 3.6.2. Энэ журмын 3.4.2 дахь заалтын дагуу хасагдсан түргэн борлогдох хөрөнгийг барьцаалсан эх үүсвэрийг хасах;
- 3.6.3. Хоёрдогч өглөг, хувьцаанд хөрвөх эх үүсвэрийг хасах.

3.7. Банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвартаа иж бүрэн үнэлгээ дүгнэлт өгч, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зохистой харьцаа, эрсдэлийн удирдлагын зарчмыг дотооддоо мөрдөнө.

3.8. Банк орсон, гарсан мөнгөн урсгалын тайланг энэ журмын 5 дугаар хавсралтын дагуу 7 хоног бүр тайлагнана.

3.9. Банк санхүүгийн байгууллагуудтай хийх тооцооны тайланг энэ журмын 6 дугаар хавсралтын дагуу 7 хоног бүр тайлагнана.

3.10. Банк хугацаагаар ангилах боломжтой авлага, өглөгийн эргэн төлөгдөх үлдсэн хугацааны тайланг 7 дугаар хавсралтын дагуу долоо хоног бүр, 8 дугаар хавсралтын дагуу сар бүр тайлагнана.

3.11. Банк орох, гарах мөнгөн урсгалын төсөөллийг нэг сараар, төгрөг, валютаар гүйцэтгэж энэ журмын 9 дүгээр хавсралтын дагуу сар бүр тайлагнана.

3.12. Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай бусад мэдээллийг тухай бүр Монголбанкинд хүргүүлнэ.

## **ДӨРӨВ. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА**

4.1. Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсч болзошгүй алдагдлыг банкны эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицид хязгаарлалт тогтооно.

4.2. Тухайн нэг гадаад валютын нээлттэй позиц нь энэ журмын 2.12-т заасны дагуу тохируулсан 2.6-д тусгасан банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй байна.

4.3. Нийт нээлттэй позицийг гадаад валют тус бүрийн хувьд тооцсон урт позицуудын нийлбэр болон богино позицуудын абсолют нийлбэрийн аль их дүн дээр цэвэршүүлсэн алт, мөнгөний нээлттэй позицийн абсолют дүнг нэмж тодорхойлох бөгөөд энэ журмын 2.12-т заасны дагуу тохируулсан 2.6-д тусгасан банкны өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

4.4. Тухайн банкны үйл ажиллагаа нь ханшийн зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзвэл уг банкны зохистой харьцааны хязгаарыг бууруулж болно.

4.5. Нэг гадаад валютын нээлттэй позицийг дараах үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцож биелэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу долоо хоног болон сар бүр ирүүлнэ:

- 4.5.1. Цэвэр спот позиц буюу тэнцлийн гадаад валютын актив, пассив, эх үүсвэрийн зөрүү (үүнд хуримтлуулж тооцсон хүүг оруулан, цэвэршүүлсэн алт, мөнгөн гулдмайны үнэлгээг гаргахдаа тухайн үеийн спот ханшийг ашиглана, активын дүнгээс өөр валютаар сан байгуулсан валютын чанаргүй активыг хасна);
  - 4.5.2. Тайлант үеэс хойш 12 сарын дотор хэрэгжих Монголбанктай хийснээс бусад хэлцлээс гадаад валютын форвард, фьючерс болон свопын арилжаатай холбоотой авлага, өглөгийн зөрүү (үүнд свопын хувьд спот арилжаатай холбоотой хэсгийг нь хасч тооцох бөгөөд ирээдүйд орох, гарах мөнгөн урсгалыг спот ханшаар нь үнэлнэ);
  - 4.5.3. Тайлант үеэс хойш 6 сарын дотор хэрэгжих гадаад валютын баталгаа, батлан даалт, аккредитивын үүргийн сөрөг дүн. Ингэхдээ дараах тохируулгыг хийнэ.
    - 4.5.3.1. Тооцоонд орсон баталгаа, батлан даалт, аккредитивын үүргийн ижил валютаарх эх үүсвэр нь тухай банкинд байршсан бол тэдгээрийг тооцооноос хасна.
    - 4.5.3.2. Тооцоонд орсон баталгаа, батлан даалт, аккредитивын үүрэг нь ижил валютаар зээлийн шугамтай бол тэдгээрийг тооцооноос хасна;
  - 4.5.4. Гадаад валютаар гаргасан бусад үүргийн сөрөг дүн;
  - 4.5.5. Бусад үүрэг, гэрээ, хэлцлээр баталгаажсан гадаад валютын авлага, өглөгийн зөрүү;
  - 4.5.6. Энэ журмын 11 дүгээр хавсралтын дагуу тооцсон гадаад валютын опционы "дельта" суурьтай өртөг;
- 4.6. Монголбанк, банк биелэгдэх боломжгүй гэж үзсэн гадаад валютын ирээдүйн авлагыг нээлттэй позицийн тооцоонд оруулахгүй байж болно.
- 4.7. Монголбанктай хийсэн гадаад валютын бодит болон бодит бус деривативын авлага, өглөгийн дүнг хугацаанаас үл хамааран нээлттэй позицийн тооцоонд тусгаж болно.
- 4.8. Банкны ханшийн эрсдэлээс үүсэх алдагдлыг үнэлэхэд шаардлагатай бусад мэдээллийг тухай бүр Монголбанкинд хүргүүлнэ.

## **ТАВ. ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА**

5.1. Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмын дагуу тодорхойлсон нийт томоохон зээлдэгчдэд олгох активын нийлбэр нь банкны нягтлан бодох бүртгэлийн багц материалын дагуу тодорхойлсон банк өөрийн хөрөнгө, энэ журмын 2.10-г тусгасан шаардлагыг хангасан хувьцаанд хөрвөх эх үүсвэр, энэ журмын 2.11-д тусгасан шаардлагыг хоёрдогч өглөгийн нийлбэрийн 300 хувиас хэтрэхгүй.

5.2. Банкны үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгийн нийлбэр нийт активын 8 хувиас хэтрэхгүй.

5.3. Банкны хамгийн том 10 харилцагчийн хадгаламж, харилцахийн нийлбэр нь нийт активын 25 хувиас хэтрэхгүй.

5.4. Банкны үйл ажиллагааг эрсдэлээс хамгаалах зорилгоор нийт зээл, активын харьцаа, нэг салбарын зээл, нийт зээлийн харьцаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хязгаарлалт тогтоож болно.

5.5. Банкны төвлөрлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ энэ журмын 5.1-5.4 дэх хэсгээр хязгаарлагдахгүй.

5.6. Төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцааны биелэлтийг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу сар бүр тайлагнана.

### **ЗУРГАА. БУСАД**

6.1. Банк энэ журамд тусгасан зохистой харьцааг өдөр бүр хангаж ажиллана. Энэ журмын хоёр, дөрөв, тавдугаар, зургаадугаар бүлэгт тусгасан зохистой харьцааг алдагдсан тохиолдолд Монголбанкинд бичгээр, банк хариуцсан хянан шалгагчид (багийн ахлагчид) цахим шудангаар тухай бүр мэдэгдэнэ.

6.2. Банк зохистой харьцааны биелэлтийн болон Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор Монголбанкинд бичгээр болон цахим системээр ирүүлнэ.

6.3. Энэ журмын хэрэгжилтэд Монголбанк хяналт тавьж, хууль тогтоомжид заасан хяналт шалгалт, албадлагын арга хэмжээ авна.

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын  
I дүгээр хавсралт

## БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

Огноо Сая төгрөгөөр

Үзүүлэлт		Дүн
<b>А. Өөрийн хөрөнгө /AI+AII/</b>		
<i>I Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө (1+2+3+4+5-6)</i>		0.0
1	Энгийн хувьцаа	
2	Энгийн хувьцаанд нэмж төлөгдсөн капитал	
3	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	
4	Нөөц сан	
5	Тохируулга	
6	<i>Хасагдах (6.1+6.2+6.3)</i>	0.0
6.1	<i>Халаасны хувьцаа (энгийн хувьцаа)</i>	
6.2	<i>Гүүдвэл</i>	
6.3	<i>Хойшлогдсон татварын авлага, програм хангамж</i>	
<i>II Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө (1+2+3+4+5-6)</i>		0.0
1	Давуу эрхийн хувьцаа	
2	Давуу эрхийн хувьцаанд нэмж төлөгдсөн капитал	
3	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр	
4	Хоёрдогч өглөг	
5	Тохируулга	
6	<i>Хасагдах (6.1)</i>	
6.1	<i>Халаасны хувьцаа (давуу эрхийн хувьцаа)</i>	
<b>Үзүүлэлт</b>		Эрсдэлээр жигнэх хувь
<b>Б. Эрсдэлээр жигнэсэн актив (I+II+III+IV)</b>		-
<b>I Тэнцлийн үзүүлэлт</b>		-
1	Бэлэн мөнгө	0%
2	Замд яваа мөнгө	20%
3	Монгол Улсын Төвбанкнаас авах авлага, түүнд хуримтлуулсан хүү	0%
4	Дотоодын банкнаас авах авлага	-
4.1	3 сараас доош хугацаатай төгрөгийн авлага	20%
4.2	Бусад	100%
4.3	Хуримтлуулсан хүү	100%
5	Монгол Улсын Хөгжлийн банкнаас авах авлага	-
5.1	3 сараас доош хугацаатай төгрөгийн авлага	20%
5.2	Бусад	100%
5.3	Хуримтлуулсан хүү	100%
6	Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага	0%
7	Дотоодын бусад санхүүгийн байгууллагаас авах авлага	100%
8	Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авах авлага	-
8.1	3 сараас дээш хугацаатай	-
8.1.1	AA- дээш үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	20%

8.1.2	BBB-; A+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	50%
8.1.3	B-; BB+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	100%
8.1.4	B- бага үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	150%
8.2	3 сараас доош хугацаатай	-
8.2.1	BBB- дээш үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	20%
8.2.2	B-; BB+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	50%
8.2.3	B- бага үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	150%
8.3	Үнэлгээгүй гадаадын санхүүгийн байгууллага	100%
9	Төвбанкны үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	0%
10	Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас	-
10.1	Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	0%
10.2	Монгол Улсын Засгийн газрын баталгаатай үнэт цаас	0%
10.3	Монгол Улсын Засгийн газрын баталгаатай үнэт цаасны хуримтлуулж тооцсон хүү	100%
11	Дотоодын үнэт цаас	-
11.1	Хувьцаа, вексель, бусад	100%
11.2	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	-
11.2.1	Нэхэмжлэх эрх нь ялгаагүй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	100%
11.2.2	Нэхэмжлэх эрх нь ялгаатай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	-
11.2.3.1	Хамгийн давуу эрхтэй хэсэг	100%
11.2.3.2	Бусад хэсэг	200%
11.2.4	МИК-ээс гаргасан ИЗЗБ	50%
11.3	Бусад үнэт цаас	100%
11.4	Хуримтлуулж тооцсон хүү	100%
12	Гадаадын үнэт цаас (үнэт цаасны үнэлгээгээр)	-
12.1	3 сараас дээш хугацаатай	-
12.1.1	AA- дээш үнэлгээтэй	20%
12.1.2	BBB-; A+ үнэлгээтэй	50%
12.1.3	B-; BB+ үнэлгээтэй	100%
12.1.4	B- бага үнэлгээтэй	150%
12.2	3 сараас доош хугацаатай	-
12.2.1	BBB- дээш үнэлгээтэй	20%
12.2.2	B-; BB+ үнэлгээтэй	50%
12.2.3	B- бага үнэлгээтэй	150%
12.3	Үнэлгээгүй	100%
13	Хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	100%
14	Зээл	-
14.1	Иргэнд төгрөгөөр олгосон ипотекийн зээл	50%
14.2	Ханшийн эрсдэлтэй этгээдэд олгосон гадаад валютын зээл”	150%
14.3	Бусад зээл	100%
14.3.1	Барилга, боловсруулах үйлдвэрлэл, агуулах, тээврийн салбарын зээл	80%
14.3.2	Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл	0%
14.4	Чанаргүй зээл	150%
14.4.1	2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө ангилагдсан чанаргүй зээл	100%
14.5	Зээлд хуримтлуулж тооцсон хүү	100%
15	Санхүүгийн хөрөнгө, хуримтлагдсан хүү	100%
16	Санхүүгийн бус хөрөнгө	-
16.1	Алт, мөнгөн гулдмай	0%

16.2	Бусад санхүүгийн бус хөрөнгө	100%
17	Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө	100%
18	Дериватив санхүүгийн хөрөнгө	100%
18.1	Монголбангтай байгуулсан свопын бодит үнэ цэнийн авлага	0%
<b>II Тэнцлийн гадуурх үзүүлэлт</b>		
1	Деривативын зээлтэй адилтган тооцох өртөг ( <i>10 дугаар хавсралтын дагуу</i> )	100%
2	Аккредитив	20%
3	Батлан даалт, баталгаа	100%
4	Тендер болон гүйцэтгэлийн батлан даалт	50%
5	Зээлийн шугам	50%
6	Хамтын санхүүжилттэй зээлийн эрсдэлд харгалзах зээлийн цэвэр үлдэгдэл	100%
7	Бусад хүлээж болох үүрэг	100%
<b>III Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт</b>		
<b>IV Сүүлийн гурван жилийн эерэг нийт орлогын дундаж</b>		
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ	9%
2	Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ	12%
3	Нөөц интервал	
4	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ биелэлт	
5	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний биелэлт	
6	Шаардлагатай нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	
7	Шаардлагатай хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө	

Энэхүү тайланд активыг хугацаар нь ангилах бол үлдсэн хугацааг нь ашиглана.

“-Зээл, үнэт цаас, эдгээртэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд холбогдох гадаад валютаар төлөх нийт төлбөрийн дүн нь сүүлийн 2 жилийн татварын дараах нийт гадаад валютаарх орлогын дунджийн 85 хувиас их этгээдийг ханшийн эрсдэлтэй гэж үзнэ. Уг этгээд нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банктай ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгслийг зээлийн нийт хугацаанд байгуулсан бол ханшийн эрсдэлгүй гэж тооцно.

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:	/нэр/
Санхүү, бүртгэлийн газрын захирал	/нэр/
Санхүү, бүртгэлийн газрын ажилтан	/нэр/



“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 2 дугаар хавсралт

## ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

Огноо	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Сая төгрөг
<b>А</b>	<b>ТҮРГЭН БОРЛОГДОХ ХӨРӨНГӨ</b>	-
1	Бэлэн мөнгө	
2	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	
3	Банк хороондын захын цэвэр авлага	
4	ВВВ ба түүнээс дээш үнэлгээтэй гадаадын СБ-д байршуулсан хөрөнгө	
5	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын баталгаатай үнэт цаас	
6	Сорьцоор баталгаажсан алтан, мөнгөн гулдмай	
7	Тохируулга	
<b>Б</b>	<b>ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ</b>	-
1	Харилцах	
2	Хадгаламж	
3	Банк хороондын захын цэвэр өглөг	
4	Санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	
5	Бусад эх үүсвэр	
6	Бусад өр төлбөр	
7	Тохируулга	
<b>В</b>	<b>ТӨЛ.ТҮР. ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (А/Б*100)</b>	#DIV/0!
<b>Г</b>	<b>ЗОХИСТОЙ ХАРЬЦАА</b>	25.0%
<b>Д</b>	<b>ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/</b>	#DIV/0!
<b>Е</b>	<b>ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ</b>	-

Тайлбар: Энэ журмын 2.10 болон 2.11 дэх заалтыг хангасан хувьцаанд хөрвөх болон хоёрдогч өглөгийг өр төлбөрийн дүнд оруулан тооцохгүй

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:	/нэр/
Санхүү, бүртгэлийн газрын захирал	/нэр/
Санхүү, бүртгэлийн газрын ажилтан	/нэр/

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур  
 үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын  
 3 дугаар хавсралт

**БАНКНЫ ГАДААД ВАЛЮТЫН НЭЭЛТЭЙ  
 ПОЗИЦИЙН ТАЙЛАН**

Огноо

Үзүүлэлтүүд	Нэгж валют (Мянган нэгжээр)							Банкнаас оруулсан	ТЭНЦЛИЙН ДҮН	
	USD	EUR	JPY	GBP	CNY	KRW	CHF		Бусад / USD/	USD (Сая.\$)
<b>A</b>										
ГАДААД ВАЛЮТЫН АКТИВ										
Мөнгөн хөрөнгө										
Хөрөнгө оруулалт (цэвэр)										
Зээлийн ерийн үлдэгдэл (цэвэр)										
Бусад хөрөнгө										
Арилжаа (Дериватив санхүүгийн хөрөнгө)										
<b>B</b>										
ГАДААД ВАЛЮТЫН ПАССИВ										
Хариллах										
Хадгаламж										
Банк, СБ-с тасан эх үүсвэр										
Бусад эх үүсвэр										
Бусад өр төлбөр										
Арилжаа (дериватив санхүүгийн өглөг)										
<b>C</b>										
ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС										
Баталгаа										
Батлан даалт										



“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 4 дүгээр хавсралт

### БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 17 ДУГААР ЗҮЙЛИЙН БИЕЛЭЛТ

Огноо	Биелэлтийг төрөл	Биелэлт*	Хасагдах дүн*	Тайлбар**	Сая төгрөгөөр
№					
1	Банкны тухайн хуулийн 17.1-ийн биелэлт				
2	Банкны тухайн хуулийн 17.2-ын биелэлт				
3.1	Банкны тухайн хуулийн 17.3-ын биелэлт (5%)				
3.2	Банкны тухайн хуулийн 17.3-ын биелэлт (20%)				
4	Банкны тухайн хуулийн 17.4-ийн биелэлт				
5	Банкны тухайн хуулийн 17.5-ын биелэлт				

\*-Тийм, үгүй.

\*-Банкны тухайн хуулийн 17.11-ийн дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ тооцоход хасагдах дүн буюу хязгаарлалтаас давсан хэсэг.

\*\*-Хязгаарлалтаас илүү гарсан тохиолдолд зээлдэгчийн нэр, нөхцөл шалтгааныг тодорхой бичнэ.

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүү, бүртгэлийн газрын захирал

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

/нэр/

/нэр/

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын  
5 дугаар хавсралт

## ӨНГӨРСӨН 7 ХОНОГИЙН МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН

Огноо Сая төгрөгөөр

	Холбоотой санхүүгийн үзүүлэлт	Гарсан			Орсон			НИЙТ ЗӨРҮҮ
		Төгрөг	Валют	НИЙТ	Төгрөг	Валют	НИЙТ	
<b>A</b>	<b>НИЙТ</b>							
<b>1</b>	<b>Харилцах</b>							
	Засгийн газар							
	Улсын байгууллага							
	Хувийн байгууллага							
	Санхүүгийн байгууллага							
	Иргэд							
	Харьяат бус, Ор.Суугч бус							
<b>2</b>	<b>Хугацаагүй хадгаламж</b>							
	Засгийн газар							
	Улсын байгууллага							
	Хувийн байгууллага							
	Санхүүгийн байгууллага							
	Иргэд							
	Харьяат бус, Ор.Суугч бус							
<b>3</b>	<b>Хугацаатай хадгаламж</b>							
	Засгийн газар							
	Улсын байгууллага							
	Хувийн байгууллага							
	Санхүүгийн байгууллага							
	Иргэд							
	Харьяат бус, Ор.Суугч бус							
<b>4</b>	<b>Зээл</b>							
	Засгийн газар							
	Улсын байгууллага							
	Хувийн байгууллага							
	Санхүүгийн байгууллага							
	Иргэд							
	Харьяат бус, Ор.Суугч бус							
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалт</b>							
	ЗГҮЦ							
	ТБҮЦ							
	Бусад							
<b>6</b>	<b>Бусад</b>							
	Арилжаа, хэлцэл, дер-тив							
	Бусад хүлээж болох үүрэг							
	Бусад							

## **Тайлбар:**

Банкны үндсэн бизнестэй холбоотойгоор бодиттоор гарсан болон орсон мөнгөн урсгалыг тусгана. Өөрөөр хэлбэл, кассын орлого, зарлага, эсвэл банк хороондын тооцоогоор дамжиж ирсэн, гарсан эх үүсвэр, зээл, хөрөнгө оруулалт, бусад хэлцэлтэй холбоотой гүйлгээнд хамаарах мөнгөн урсгалыг тусгана.

Тухайн харилцагч өөрийн хугацаагүй хадгаламжийн данснаас гаргаад, хугацаатай хадгаламжийн дансанд оруулсан, эсвэл төгрөгийн хадгаламжаас гаргаад гадаад валютын хадгаламжинд оруулсан зэргийг мөнгөн урсгал гэж үзэхгүй.

Нэг харилцагч нөгөө харилцагчийн мөнгөн хөрөнгө шилжүүлсэн бол гарч, орсон мөнгөн урсгал гэж үзэхгүй.

Банк зээл олгож, харилцагчийн харилцах дансанд шилжүүлсэн бол гарч, орсон мөнгөн урсгал гэж үзэхгүй. Харин харилцагч зарцуулалт хийж өөр банкинд шилжүүлсэн, эсвэл бэлнээр авсан бол мөнгөн урсгал болно.

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:	/нэр/
Санхүү, бүртгэлийн газрын захирал	/нэр/
Санхүү, бүртгэлийн газрын ажилтан	/нэр/

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 6 дугаар хавсралт

**БАНКНЫ БАНК, САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГАТАЙ ХИЙХ ТООЦОО**

№	Огноо	Банк	Сая тогтогөөр											
			Нийт		Харилцах		Хадгаламж		Зээл		Овернайг			
			Авлага	Өглөг	Авлага	Өглөг	Авлага	Өглөг	Авлага	Өглөг	Авлага	Өглөг		
		<b>НИЙТ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
1		Догоодлын банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1		Хаан	0.0	0.0										
2		ХХБ	0.0	0.0										
3		Голомт	0.0	0.0										
4		Хас	0.0	0.0										
5		Төрлийн	0.0	0.0										
6		УБ	0.0	0.0										
7		Чингис	0.0	0.0										
8		Кредит	0.0	0.0										
9		Ариг	0.0	0.0										
10		ҮХО	0.0	0.0										
11		Калитрон	0.0	0.0										
12		Тээвэр	0.0	0.0										
13		Богд	0.0	0.0										

II	Дотоодын санхүүгийн байгууллага	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1	Монголбанк	0.0	0.0										
2	Хөгжлийн банк	0.0	0.0										
3	Хадгаламжийн даатгалын ко	0.0	0.0										
4	ББСБ	0.0	0.0										
5	ХЗХ	0.0	0.0										
6	Бусад	0.0	0.0										
III	Гадаадын банк	0.0	0.0										
IV	Гадаадын санхүүгийн байгууллага	0.0	0.0										

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүү, бүртгэлийн газрын захирал

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

/нэр/

/нэр/



“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 7 дугаар хавсралт

## ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНЫ ТАЙЛАН

Огноо

Сая төгрөг

Хөрөнгө		1-7 хоног	8-14 хоног	15-30 хоног	Нийт
	<b>НИЙТ</b>				
	Бэлэн мөнгө				
	Мөнгөтэй адилтгах хөрөнгө				
2	БСБ-д байршуулсан хөрөнгө				
	Хөрөнгө оруулалт				
	ЗГҮЦ				
3	МБҮЦ				
	Бусад үнэт цаас				
	Зээл				
	ЗГ, Улс.Бай олгосон зээл				
	БСБ-д олгосон зээл				
4	Хувийн.Бай олгосон зээл				
	Иргэнд олгосон зээл				
	Бусад зээл				
	Ху.Анги.Болох Санхүү.Хөр				
	Ху.Анги.Болохгүй Санхүү.Хөр				
	Санхүүгийн бус хөрөнгө				
6	Хугацаагаар ангилж болох бусад				
	Дериватив санхүүгийн хөрөнгө*				
	Үндсэн хөрөнгө				
	<b>Өр төлбөр</b>				
	<b>НИЙТ</b>				
	Харилцах				
	Хугацаагүй хадгаламж				
	Хугацаатай хадгаламж				
	ЗГ, Улс.Бай				
	Хувийн.Бай				
	Иргэд				
	Бусад				
	БСБ-аас татсан эх үүсвэр				
	Монголбанк				
	Дотоодын банк				
	Дотоодын СБ				

	Гадаадын БСБ				
	Бусад				
	Бусад эх үүсвэр				
	Үнэт цаас цаас				
	Төслийн санхүүжилт				
	Бусад				
	Хугацаагаар ангилж болох бусад				
	Ху.Анги.Болохгүй бусад				
	Дериватив санхүүгийн өглөг*				
	<b>Цэвэр зөрүү</b>				
	<b>Цэвэр зөрүү (өссөн дүнгээр)</b>				

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын захирал

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 8 дугаар хавсралт

## ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНЫ ТАЙЛАН

Огноо

Сая төг

	Хөрөнгө	Хугацаагүй	1-30 өдөр	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-2 жил	2-5 жил	5 жилээс дээш	Нийт
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө									
2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө									
	Монголбанкны үнэт цаас									
3	Засгийн газрын үнэт цаас									
	Бусад үнэт цаас									
	Засгийн газар, улсын байгуулагад олгосон зээл									
	Банк, санхүүгийн байгууллагад олгосон зээл									
4	Хувийн аж ахуй нэгжид олгосон зээл									
	Иргэдэд олгосон зээл									
	Бусад зээл									
5	Дериватив санхүүгийн хөрөнгө*									
6	Хугацаагаар ангилж болох бусад хөрөнгө									
	<b>НИЙТ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ</b>									

Өр төлбөр		Хугацаагүй	1-30 өдөр	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-2 жил	2-5 жил	5 жилээс дээш	Нийт
1	Харилцах									
	Засгийн газар, төсөв, нийгэм даатгал									
	Улсын байгууллага									
	Хувийн байгууллага									
	Иргэд									
	Бусад									
	Хугацаагүй хадгаламж									
	Засгийн газар, төсөв, нийгэм даатгал									
	Улсын байгууллага									
	Хувийн байгууллага									
	Иргэд									
	Бусад									
	Хугацаагүй хадгаламж									
	Засгийн газар, төсөв, нийгэм даатгал									
	Улсын байгууллага									
	Хувийн байгууллага									
	Иргэд									
	Бусад									
	Банк, санхүүгийн байгууллага									
	Монголбанк									
	Дотоодын банк									
	Дотоодын СБ									
	Гадаадын банк, СБ									
	Бусад өр төлбөр									



“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 9 дүгээр хавсралт

### ИРЭХ 30 ХОНОГИЙН МӨНГӨН УРСГАЛЫН ТААМАГЛАЛ

Огноо

Сая төгрөг

	Холбоотой санхүүгийн үзүүлэлт	Гарах			Орох			НИЙТ ЗӨРҮҮ
		Төгрөг	Валют	НИЙТ	Төгрөг	Валют	НИЙТ	
1	<b>Харилцах</b>							
	Засгийн газар							
	Улсын байгууллага							
	Хувийн байгууллага							
	Санхүүгийн байгууллага							
	Иргэд							
	Бусад							
	<b>Хугацаагүй хадгаламж</b>							
	Засгийн газар							
	Улсын байгууллага							
	Хувийн байгууллага							
	Санхүүгийн байгууллага							
	Иргэд							
	Бусад							
	<b>Хугацаатай хадгаламж</b>							
	Засгийн газар							
	Улсын байгууллага							
	Хувийн байгууллага							
	Санхүүгийн байгууллага							
	Иргэд							
	Бусад							
	<b>Зээл</b>							
	Засгийн газар							
	Улсын байгууллага							
	Хувийн байгууллага							
	Санхүүгийн байгууллага							
	Иргэд							
	Бусад							
	<b>Хөрөнгө оруулалт</b>							
	ЗГҮЦ							
	ТБҮЦ							
	Үнэт метал							
	Бусад							
	<b>Бусад</b>							
	Арилжаа, хэлцэл, дер. тив							
	Бусад хүлээж болох үүрэг							
	Бусад							

	Нийт зөрүү	
	Түргэн борлогдох хөрөнгө	
	Дутагдал	

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал: /нэр/  
Санхүү, бүртгэлийн газрын захирал /нэр/  
Санхүү, бүртгэлийн газрын ажилтан /нэр/

*“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 10 дугаар хавсралт*

## **САНХҮҮГИЙН ДЕРИВАТИВИЙН ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ ӨРТГИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ**

1. Санхүүгийн деривативийн зээлтэй адилтган тооцох өртгийг энэхүү аргачлалын дагуу тодорхойлно.

2. Зээлтэй адилтган тооцох өртгийг дараахь деривативийн хувьд тооцно:

2.1. Хүүгийн эрсдэлийн деривативууд:

2.1.1. Тухайн нэг улс, орны валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэгслүүдийн хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Single currency interest rate swaps),

2.1.2. Санхүүгийн хэрэгслүүдийн суурь хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Basis swaps),

2.1.3. Хүүгийн форвардын гэрээ, хэлцэл (Forward rate agreement),

2.1.4. Худалдан авсан хүүгийн опцион гэрээ, хэлцэл. Үүнд хүүгийн дээд болон доод хязгаарыг тогтоосон, мөн эдгээрийг хослуулан хэрэглэсэн гэрээ, хэлцэл хамаарна (Interest rate options purchased, including caps, collars and floors purchased),

2.2. Гадаад валютын арилжааны дериватив:

2.2.1. Хоёр өөр улс орны валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн бүтээгдэхүүний хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Cross-currency interest rate swaps),

2.2.2. Гадаад валютын арилжааны форвардын гэрээ, хэлцэл (Forward foreign exchange contracts),

2.2.3. Бусдаас худалдан авсан гадаад валютын арилжааны опцион гэрээ, хэлцэл (Currency options purchased),

2.3. Зээлийн эрсдэл үүсгэж болзошгүй санхүүгийн бусад дериватив.

3. Энэхүү аргачлалын 2 дугаар хэсэгт заасан деривативийн ангилалд хамаарах боловч дараахь шинж чанарыг агуулсан деривативийн хувьд зээлтэй адилтган тооцох өртгийг тооцох шаардлагагүй:

3.1. Үлдсэн хугацаа нь 14 өдрөөс доош;

3.2. Тусгай зориулалт бүхий дотоодын бирж дээр арилжаалдаг, үнэ ханшийн зөрүүнээс үүдэлтэй аливаа төлбөр тооцоог өдөрт нь тусгай клирингийн төвөөр дамжуулан гүйцэтгэдэг дериватив.

4. Санхүүгийн деривативийн зээлтэй адилтган тооцох өртгийг (credit equivalent amount) тухайн үеийн (current exposure) болон ирээдүйд хүлээж болзошгүй (potential future credit exposure) алдагдлын нийлбэр дүнгээр тодорхойлно.



5. Тухайн үеийн алдагдлын дүнг санхүүгийн деривативийн суурь бүтээгдэхүүний гэрээнд заасан үнэ болон тухайн үеийн зах зээлийн үнэ хоёрын зөрүүгээр тооцох бөгөөд шаардлагатай үед хүү, ханш, индекс болон харилцагч этгээдийн төлбөрийн чадварт гарсан өөрчлөлтийг харгалзан үзэж болно.

6. Ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын дүнг санхүүгийн деривативийн суурь бүтээгдэхүүний гэрээнд заасан үнийг Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос баталсан хөрвүүлэлтийн хувь хэмжээгээр (conversion factor) үржүүлэн тооцно:

Төлөгдөх хугацаа	Хүүгийн эрсдэлийн	Гадаад валютын болон алтны арилжааны	Хувьцааны арилжааны	Алтнаас бусад үнэт металлын	Бусад
1 жилээс доош хугацаатай	0.0%	1.0%	6.0%	7.0%	10.0%
1-5 жилийн хугацаатай	0.5%	5.0%	8.0%	7.0%	12.0%
5 жилээс дээш хугацаатай	1.5%	7.5%	10.0%	8.0%	15.0%

7. Деривативийн ашиг алдагдлыг цэвэршүүлэн тооцох бололцоотой бол зээлтэй адилтган тооцох өртгийг дараахь томъёог ашиглан бодож гаргана:

$$A_{Net} = 0.4 \times A_{Gross} + 0.6 \times NGR \times A_{Gross}$$

$A_{Net}$  - зээлтэй адилтган тооцох цэвэр өртөг

$A_{Gross}$  - зээлтэй адилтган тооцох нийт өртөг

NGR - ашиг, алдагдлын нийлбэр дүнг тухайн үеийн алдагдлын нийлбэр дүнд харьцуулсан харьцаа. Үүнд ашиг, алдагдлын нийлбэр дүн нь тэгтэй тэнцүү, аль эсвэл сөрөг утгатай байвал NGR-ийг тэгтэй тэнцүү гэж үзнэ.

ЖИШЭЭ:

"А" банк нь 3 сарын хугацаатай, 5000.0 мянган ам.долларын гадаад валютын форвардын гэрээ; 4 жилийн хугацаатай, 6000.0 мянган ам.долларын суурь хүүгийн свопын гэрээ; 6 жилийн хугацаатай, 12000.0 мянган ам.долларын хувьцааны арилжааны фьючерсийн гэрээ тус тус байгуулсан байсан бөгөөд 2004 оны 4 дүгээр сарын байдлаар деривативуудыг зах зээлийн үнэлгээгээр нь үнэлэхэд гадаад валютын арилжааны гэрээнээс 20.0 мянган ам.долларын, хувьцааны арилжааны фьючерсийн гэрээнээс 100.0 мянган ам.долларын алдагдал тус тус хүлээж, харин хүүгийн свопоос 10.0 мянган ам.долларын ашиг олсон байв.

"А" банкны зээлтэй адилтган тооцох нийт өртгийг тооцоход:

2004 оны 4 дүгээр сарын байдлаар

(мянган ам.доллар)

	САНХҮҮГИЙН ДЕРИВАТИВ	Суурь бүтээгдэх- үүний үнэ	Хөрвүүлэл- тийн хувь хэмжээ	Ирээдүйд хүлээж болзошгүй алдагдал	Тухайн үеийн алдагдал	Зээлтэй адилтган тооцох өртөг (нийт)
	А	1	2	3=1*2	4	5=3+(4>0)
1	3 сарын хугацаатай гадаад валютын форвардын гэрээ	5 000,0	1,0%	50,0	20,0	70,0
2	4 жилийн хугацаатай суурь хүүгийн своп	6 000,0	0,5%	30,0	0,0	30,0*
3	6 жилийн хувьцааны арилжааны фьючерсийн гэрээ	12 000,0	10,0%	1 200,0	100,0	1300,0
	БҮГД	23 000,0		1 280,0	120,0	1400,0

Тайлбар: \* - зээлтэй адилтган тооцох өртгийг тооцоходоо ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын дүнг тухайн үеийн ашгийн дүнгээр хорогдуулахгүй.

Хүснэгтээс үзэхэд 3 деривативийн гэрээнийн зээлтэй адилтган тооцох нийт өртөг нь 1400.0 мянган ам.доллар байна. Хүүгийн свопын ашгийг харгалзан зээлтэй адилтган тооцох өртгийг тооцвол:

$$A_{Net} = 0.4 \times 1400.0 + 0.6 \times \left( \frac{20.0 - 10.0 + 100.0}{20.0 + 100.0} \right) \times 1400.0 = 1330.0$$

*“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 11 дүгээр хавсралт*

## **ГАДААД ВАЛЮТЫН ОПЦИОНЫ "ДЕЛЬТА" СУУРЬТАЙ ӨРТӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛТ**

Гадаад валютын опционы "дельта" суурьтай өртөгийг Гармэн-Колхаген ("Garman-Kohlhagen")-ны томъёогоор тооцно:

$$C = e^{-FT} SN(x + \sigma\sqrt{T}) - e^{-DT} KN(x)$$
$$x = \frac{\ln(S/K) + (D - F - \sigma^2/2)T}{\sigma\sqrt{T}}$$
$$delta = \frac{\partial C}{\partial S} = e^{-FT} N(x + \sigma\sqrt{T}) > 0$$

Үүнд "С" нь колл опционы өртөг, "F" нь гадаад валютын хүү, "D" нь үндэсний валютын хүү, "Т" нь опционы хугацаа, "S" нь спот ханш, "K" нь опционы гэрээнд заасан ханш, N(x) нь спот болон гэрээнд заасны ханшны харьцааг хүүгийн зөрүү болон опционы хугацаагаар тохируулсан дүн нь тодорхой тоон утгатай тэнцүү буюу түүнээс бага байх магадлал. Энэхүү магадлалыг хэвийн тархалттай санамсаргүй хэмжигдэхүүний нягтын функцийн тусламжтайгаар олно.

*Захиргааны хэм хэмжээний актын  
улсын нэгдсэн санд 2019 оны 6 сарын 26-ны  
өдрийн 4417 дугаарт бүртгэв.*

## **МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 10-ны өдөр

Дугаар А-155/134

Улаанбаатар хот

### **Журам шинэчлэн батлах тухай**

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталж, мөрдүүлсүгэй.

2.Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг банкуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх удирдлагад тус тус даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-193/228 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан), Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар (Ц.Зоригтбат)-т тус тус даалгасугай.

**МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**САНГИЙН САЙД**

**Н.БАЯРТСАЙХАН**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

*Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А-155/134 дугаар хамтарсан тушаалын хавсралт*

## **АКТИВЫГ АНГИЛАХ, АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 27.1-д заасан зээл болон бусад активыг ангилах, Банкны тухай хуулийн 35.5-д заасан актив төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан байгуулах, зарцуулахад тавигдах доод шаардлагыг Монголбанкнаас тогтоох, банкинд мөрдүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журам нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.
- 1.3. Банк нь активыг хугацааны болон чанарын үзүүлэлтээр энэ журмын 2 дугаар бүлэг болон Хавсралт 1, Хавсралт 2-т заасан аргачлалаар ангилан, харгалзах эрсдэлийн санг энэ журмын 3 дугаар бүлэг болон Хавсралт 3-т заасны дагуу байгуулж Монголбанкнаас тогтоосон доод шаардлагыг хангах үүрэгтэй.
- 1.4. Банк нь нягтлан бодох бүртгэл болон удирдлагын үйл ажиллагааны зорилгоор өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ болон боловсронгуй байдалтай уялдуулан активыг ангилж, эрсдэлийн сан байгуулах, Активын эрсдэлийн удирдлагын талаар дотооддоо баримтлах бодлого, журам, заавар, аргачлал зэргийг боловсруулан мөрдөж ажиллана.
- 1.5. Банкнаас энэ журмын дагуу хийсэн активын эцсийн ангилал, байгуулсан эрсдэлийн сан нь Монголбанкны зүгээс энэ журмын дагуу холбогдох активт тогтоосон ангилал, харгалзах эрсдэлийн сангийн хэмжээ нь зөрүүтэй байх тохиолдолд банк нь Монголбанкны ангилал болон эрсдэлийн сангийн хэмжээг дагаж мөрдөнө.
- 1.6. Банк нь активын ангиллыг энэ журмын 2.1.1-т заасан үндсэн ангиллаас илүү олон төрлөөр дотооддоо ангилж болох бөгөөд уг ангиллыг энэ журамд заасан ангилалд буцаан хөрвүүлэх боломжтой байхаар боловсруулна.
- 1.7. Энэ журамд заасан активын ангилал, эрсдэлийн сангийн доод шаардлагын хэрэгжилтийн тайланг Банк нь өөрийн дотоод ангилал, аргачлалын тооцооллын хамт энэ журмын 3.6.1-т заасан хугацаанд багтаан Монголбанкнд тайлагнана.
- 1.8. Банк нь активын ангиллыг үнэн зөв тогтоож, харгалзах эрсдэлийн сангийн

түвшин, хэмжээг зохистойгоор тооцох үүрэгтэй бөгөөд энэ журмаар тогтоосон доод шаардлагыг тогтмол хангаж ажиллана.

- 1.9. Энэ журмын дагуу банкнаас хийсэн активын ангилал, байгуулсан эрсдэлийн сангийн хэмжээ нь энэ журмаар тогтоосон доод шаардлагыг хангасан эсэхийг Монголбанкнаас шалгаж, доод шаардлагыг хангаагүй активын ангиллыг өөрчилж, дутуу байгуулсан эрсдэлийн санг нэмж байгуулах арга хэмжээг тухай бүр авна.
- 1.10. Банкнаас энэ журмын 1.4-т заасан дотоод журам, аргачлалаар тогтоосон активын ангилал нь энэ журмаар тооцох ангиллаас доогуур байгаа тохиолдолд банкны дотоод аргачлалаар тогтоох ангиллыг мөрдөнө.
- 1.11. Энэ журмын 1.4-т заасан банкны дотоод аргачлалын дагуу тооцсон активын эрсдэлийн сангийн хэмжээ энэ журмын дагуу тооцсон эрсдэлийн сангаас их байгаа тохиолдолд банкны дотоод аргачлалаар тооцсон эрсдэлийн санг ашиглана.
- 1.12. Дор дурдсан актив буюу зээл, зээлтэй адилтган тооцох бусад активт энэ журмын дагуу ангилал тогтоож, эрсдэлийн сан байгуулна:
  - 1.12.1. “Зээл” буюу гэрээний дагуу олгосон мөнгөн хөрөнгийн төлбөрийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрх үүсгэж байгаа санхүүгийн хөрөнгө;
  - 1.12.2. “Бусад актив” буюу зээлтэй адилтган тооцохуйц зээлээс бусад тэнцэл дэх актив, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.8-д заасан Төв банкны үнэт цаас болон Засгийн газрын үнэт цааснаас бусад төрлийн үнэт цаас; тэнцлийн гадуурх баталгаа, батлан даалт, аккредитив, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, хэлцлийн дагуу хүлээж болзошгүй үүрэг зэрэг банкны үйл ажиллагаатай холбоотойгоор ирээдүйд банкинд шаардах эрх, авлага буюу активын эрсдэл үүсгэхээр байгаа үүрэг;
  - 1.12.3. Энэ журмын 2.2.2-д заасан нөхцөлийг хангасан “Хамааралтай актив /Multiple facilities/”;
  - 1.12.4. Энэ журмын 2.7-д заасны дагуу нэгдсэн байдлаар багцалж, энэ журмын дагуу нийтэд нь эрсдэлийн сан байгуулахаар бүлэглэсэн активууд буюу “Багцалсан актив” /pooled assets/;
  - 1.12.5. “Нэгж актив” буюу багцалсан активт багтаж байгаа тухайлсан актив;
  - 1.12.6. Энэ журмын 2.4.1-т заасан шалгуурыг хангасан “Бүтэц өөрчлөгдсөн актив”;
  - 1.12.7. Банкнаас овердрафт, зээлийн эрхтэй төлбөрийн карт, зээлийн шугам зэрэг санхүүжилтийн хэмжээ, хугацаа, давтамж, дээд хязгаар болон бусад нөхцөлийг үүрэг гүйцэтгэгчийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан бусад активтай харьцуулахад уян хатан, тодорхой хязгаарт багтаан олон давтамжтайгаар олгохыг зөвшөөрсөн тухайн нэг эсвэл багцалсан актив буюу “Хувьсах нөхцөлтэй актив” /revolving facility/;
  - 1.12.8. Банкны нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.5.Б-д тусгасан “Өмчлөх бусад хөрөнгө”.

- 1.13. Активт ангилал тогтоож, эрсдэлийн сан байгуулахад дараах ерөнхий зарчмыг баримтална:
- 1.13.1. “Активын эрсдэл”-ийг төлбөр хариуцагчаас банктай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу хүлээн авсан активын төлбөрийг, харгалзах хүүгийн хамт заасан хугацаанд тодорхой хэсгийг эсвэл бүхэлд нь эргэн төлөхгүй байх магадлал; эсвэл тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа баталгаа, батлан даалт болон бусад үүргийг банкнаас биелүүлэх магадлал нэмэгдэх үзүүлэлтээр тус тус тооцох;
  - 1.13.2. Активт энэ журмын Хавсралт 1-д заасан хугацааны хүчин зүйлээр тогтоосон ангиллыг Хавсралт 2-т заасан чанарын хүчин зүйлээр тогтоосон ангилалтай харьцуулж, аль доогуур шатлалаар “Активын эцсийн ангилал”-ыг тогтоох;
  - 1.13.3. “Зээлтэй адилтган тооцох өртөг”-ийг энэ журмын 3.2.1.2 эсвэл 3.2.1.7-д заасны дагуу тооцох;
  - 1.13.4. “Эрсдэлийн төлөв /Risk Profile”-ийг төлбөр хариуцагчийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой тоон мэдээллийг ашиглан төлбөр хариуцагчийн эрсдэлүүдийг тооцсон банкны ерөнхий дүгнэлт, үнэлгээг хэлбэрээр тооцох;
  - 1.13.5. “Төлбөр төлөгдөхгүй байх магадлал /PD”-ыг Нягтлан бодох бүртгэлийн зааврын Хавсралт 1 -ийн 4.3.Г-д тусгасны дагуу ойрын 12 сарын хугацаанд зээл болон бусад активын хувьд үндсэн болон хүүгийн төлбөр 90-ээс дээш хоногоор хэтрэх (дефолт) тохиолдлоор тооцох;
  - 1.13.6. “Алдагдал үүсэх магадлал /LGD”-ийг Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.3.Г-д тусгасны дагуу зээл болон бусад активын хэмжээнд тооцох;
  - 1.13.7. “Алдагдал тодорхойлох хүчин зүйл /LIP”-ийг Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.3.Г-д тусгасны дагуу зээл болон бусад активын хэмжээнд тооцох;
  - 1.13.8. “Активын эрсдэлийн параметр”-ыг энэ журмын 1.13.5, 1.13.6 болон 1.13.7-д заасан үзүүлэлтүүд болон банкнаас активын эрсдэлийг тооцоход ашиглаж байгаа үзүүлэлтүүдийн аль нэгийг эсвэл нэгдсэн байдлаар тооцох;
  - 1.13.9. Төлбөр хариуцагчид хамаарах тухайн нэг болон нийт актив, эсвэл багцалсан активыг энэ журамд тусгасан шалгуурын дагуу чанар нь буурсан талаар дүгнэлтэд үндэслэн холбогдох ангилал хийж, харгалзах эрсдэлийн сангийн хувиар тооцож байгуулсан дүнгээр “Тусгай эрсдэлийн сан”-г тооцох;
  - 1.13.10. Нийт санхүүгийн салбарын болон тухайн банкны үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй активын эрсдэлийн ерөнхий түвшинд үндэслэн, тэнцлийн болон тэнцлийн гадуурх нийт активын үлдэгдлээс холбогдох эрсдэлийн сангийн хувиар тооцсон мөнгөн дүнгээр “Ерөнхий эрсдэлийн сан”-г тооцох;

- 1.13.11. Активын урт хугацааны тоон үзүүлэлт болон бусад мэдээлэлд үндэслэн банкны ойрын 1 жилийн хугацаанд активаас гарахаар хүлээгдэж байгаа хохирол, алдагдлын дундаж үнэлгээ (арифметик, жигнэсэн болон статистикийн бусад дундаж хэмжигдэхүүн)-гээр “Активын хүлээгдэж байгаа алдагдал /expected loss/”-ыг тооцож, банкнаас тусгай эрсдэлийн сан байгуулахаар дотоод аргачлалдаа ашиглана;
- 1.13.12. Активыг энэ журамд заасан хүчин зүйлсийн үнэлгээ эсвэл банкны дотоод журам, аргачлалаар үнэлэхэд гэрээнд заасан хугацаанд төлбөр нь бүрэн болон хэсэгчлэн эргэн төлөгдөх боломж буурсан тохиолдолд “Ангилал буурсан актив”-аар тооцно;
- 1.13.13. “Төлбөр хэтрэлт /дефолт/”-ийг тухайн нэг төлбөрийн хариуцагчид хамаарах активын хувьд дор дурдсан нөхцөлийн аль нэгээр тогтооно:
  - 1.13.13.1. Төлбөр хариуцагчаас эргэн төлбөл зохих актив нь материаллаг хэмжээгээр 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн. Актив нь овердрафт бол төлбөр хариуцагчийн зүгээс банкнаас санал болгосон хязгаараас хэтрүүлж зарцуулсан эсвэл банкны зүгээс зарцуулж болох дээд хязгаарыг бууруулсан;
  - 1.13.13.2. Хугацаандаа төлөгдөж байгаа эсвэл хугацаа хэтэрсэн эсэхээс үл хамаарч, төлбөр хариуцагчаас активын барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулахгүйгээр, активыг (үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлт зэрэг) анхны болон шинэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу бүхэлд нь эргэн төлөх боломжгүй болсон талаар банкнаас дүгнэсэн.
- 1.13.14. “Үр ашигт хүүгийн түвшин”-г Банкны нягтлан бодох бүртгэлийн зааврын 1 дүгээр бүлэгт заасны дагуу тооцно;
- 1.13.15. “Доогуур ангилал”-ыг тухайн активт харгалзах ангиллуудын хамгийн доод ангиллаар тооцно;
- 1.13.16. Банкны төлбөр хариуцагчид олгосон активт хамаарах нэг болон түүнээс дээш барьцааны зүйлийг тухайн банкны өөр төлбөр хариуцагчид давхар барьцаалах буюу “Давхар барьцаа хөрөнгө”-тэй тохиолдолд уг нөхцөлийг активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах тооцоололд энэ журмын дагуу тухай бүр тусгана;
- 1.13.17. Нэг батлан даагч буюу банкны төлбөр хариуцагчид олгосон активыг батлан даагч нь тухайн банкны өөр төлбөр хариуцагчид олгосон активыг давхар даах тохиолдолд уг нөхцөлийг активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах тооцоололд энэ журмын дагуу тухай бүр тусгана;
- 1.13.18. “Материаллаг байдал”-ыг дор дурдсан нөхцөлөөр тогтооно:



- 1.13.18.1. ямарваа зүйлүүдийг орхигдуулснаас эсвэл буруу тооцож, тайлагнаснаас шалтгаалан харилцагчдын эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх байдлыг (Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдалд орхигдуулсан, буруу тайлагнасан зүйлийн онцлог шинж, тоо хэмжээнээс шалтгаална.);
  - 1.13.18.2. Активын үнэлгээнд тусгасан эсвэл орхигдуулснаас шалтгаалан активын чанар болон эцсийн ангилалд мэдэгдэхүйц байдлаар нөлөөлөх хэмжээ, түвшин эсвэл өөрчлөлтийн хувийн үзүүлэлтээр активын үнэлгээнд тусгах тохируулгыг.
- 1.13.19. Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал буюу “Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар”-т заасны дагуу зээл болон бусад активын үнэ цэнийн бууралт, эрсдэлийн параметр болон бусад үзүүлэлтийг тооцно.

## **ХОЁР. АКТИВЫГ АНГИЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 2.1. Нийтлэг үндэслэл
  - 2.1.1. Банк нь энэ журмын 2.7.1.-д заасан Багцалсан активаас бусад активын ангиллыг энэ журмын Хавсралт 1-д заасан хугацааны болон Хавсралт 2-т заасан чанарын хүчин зүйлд тулгуурлан дор дурдсан ангиллаар тус, тусад нь хийж, аль доогуур үнэлгээгээр эцсийн ангиллыг тогтооно:
    - 2.1.1.1. Хэвийн
    - 2.1.1.2. Анхаарал хандуулах;
    - 2.1.1.3. Чанаргүй ангилал, үүнээс:
      - 2.1.1.3.а. Хэвийн бус;
      - 2.1.1.3.б. Эргэлзээтэй;
      - 2.1.1.3.в. Муу.
  - 2.1.2. Тэнцлээс гадуурх активаас бусад активын Зээлийн мэдээллийн санд шилжүүлэх ангиллыг зөвхөн хугацааны хүчин зүйлийн үнэлгээнд харгалзах ангиллаар тооцож хүргүүлнэ.
  - 2.1.3. Тэнцлээс гадуурх активын эцсийн ангиллыг Зээлийн мэдээллийн санд хүргүүлнэ.
  - 2.1.4. Чанарын хүчин зүйлээр хэвийн ангиллаар үнэлэгдсэн боловч хугацаа хэтэрсэн зээлийг төлбөр хариуцагчаас банкнаас үзүүлэх санхүүгийн дэмжлэггүйгээр хугацаа хэтэрсэн өдрөөс хойш иргэний хувьд 15 хүртэлх хоног, аж ахуйн нэгжийн хувьд 30 хүртэлх хоногт багтаан эргэн төлөх боломжтой талаар банкны зүгээс дүгнэвэл уг зээлийг хэвийн ангилалд бүртгэж болно. Энэхүү зээлийн эргэн төлөлт нь дээр заасан хоногоос хэтрэх тохиолдолд тус зээлийг энэ журамд заасан аргачлалын дагуу ангилал бууруулан тогтооно.

- 2.1.5. Активын чанарын ангиллыг энэ журмын Хавсралт 2-т заасны дагуу тогтоохдоо журмын Хавсралт 5, Хавсралт 6-д заасан харгалзах хүчин зүйлсийн жагсаалтад өгсөн үнэлгээг ашиглана.
- 2.1.6. Активын хугацааны болон чанарын хүчин зүйлийн үнэлгээнд орсон өөрчлөлтийг банкнаас тухай бүр тогтоож, энэ журмаар тогтоосон шаардлагын дагуу ангиллыг сард нэг удаа буюу тухайн сарын сүүлийн ажлын өдөрт багтаан хийнэ.
- 2.1.7. Банк нь дотоод аргачлалын дагуу активын ангиллыг энэ журмын 2.1.6-д зааснаас илүү давтамжтайгаар хийж болно.
- 2.1.8. Активын хэлбэрийг өөрчилсөн тохиолдолд хэлбэр өөрчлөгдөхөөс өмнөх ангиллыг хэвээр хадгалж, түүнд үндэслэн энэ журмын дагуу дараагийн ангиллыг хийнэ. Активыг төлүүлэх, худалдах зорилгоор өмчлөх бусад хөрөнгийг активын барьцаанд авсныг активын хэлбэр өөрчлөгдсөнд тооцохгүй бөгөөд өмчлөх бусад хөрөнгийг энэ журамд заасны дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулна.
- 2.1.9. Банк нь байгууллага, аж ахуйн нэгжид олгосон активын чанарын ангиллыг тогтооход ашиглах санхүүгийн тайланг улирал болгон гаргуулан авч судалгаа тооцоо хийх бөгөөд санхүүгийн тайланг оны эцэст аудитаар баталгаажуулсан байх шаардлагыг тавина.

## 2.2. Хамааралтай активууд

- 2.2.1. Нэг төлбөр хариуцагч болон түүнтэй хамааралтай бусад төлбөр хариуцагчдад олгосон активт ангилал хийхдээ нийт хамааралтай активын үлдэгдлийн төлбөр барагдуулах магадлал, боломжийн хувьд ялгаатай байгаа хэсгээс бусад хэсэгт ижил ангилал тогтооно. Уг магадлал, боломж нь ялгаатай гэж үзсэн активын нийт хамааралтай активын үлдэгдэлд эзлэх дүн нь 25 хувиас дээшгүй байна.
- 2.2.2. Дараах нөхцөл бүрдсэн нэг болон хэд, хэдэн төлбөр хариуцагчид олгосон активыг нэгтгэн хамааралтай активт тооцно:
  - 2.2.2.1. Нэг батлан даагчтай болон нэг батлан даалт, баталгаатай, давхар барьцаа хөрөнгөтэй эсвэл өөр хоорондоо батлан даалт, баталгаа гаргасан, санхүүгийн үйл ажиллагааны хувьд харилцан хамааралтай төлбөр хариуцагчид;
  - 2.2.2.2. Хувь эзэмшлийн бүтэц, бүрэлдэхүүн болон материаллаг түвшинд төлбөр хариуцагчид хяналт тогтоох боломжтой гэж Монголбанк эсвэл банкнаас дүгнэсэн, удирдлагын хувьд хоорондоо холбоотой төлбөр хариуцагчид;
  - 2.2.2.3. Тухайн төлбөр хариуцагчийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд хяналт тогтоох, нөлөөлөл үзүүлэх боломжтой талаар банк эсвэл Монголбанкнаас холбогдох баримтад үндэслэн дүгнэсэн бусад төлбөр хариуцагчид;
  - 2.2.2.4. Төлбөр хариуцагчтай үйл ажиллагаа, борлуулалт, дамжуулалтын

- сувгаар дамжуулан нягт хамааралтай үйл ажиллагаа явуулдаг нь банкны зүгээс цуглуулсан баримт, мэдээ, мэдээллээр дүгнэсэн бэлтгэн нийлүүлэгчид;
- 2.2.2.5. Банк эсвэл Монголбанкнаас энэ журмын 2.2.2.1-2.2.2.4-т зааснаас бусад үндэслэлээр ижил төрлийн буюу нийтлэг нэг эрсдэл үүсгэхээр байна гэж дүгнэсэн активын төлбөр хариуцагчид.
- 2.2.3. Энэ журмын 2.2.2-д заасан хамааралтай активуудад дор дурдсанаас бусад тохиолдолд нэг ангилал тогтооно. Үүнд:
- 2.2.3.1. Төлбөр хариуцагчдад олгосон активууд нь давхар барьцаа хөрөнгөгүй эсвэл нэг батлан даагчгүй;
- 2.2.3.2. Давхар барьцаа хөрөнгө эсвэл батлан даагчтай боловч хамааралтай активын чанар муудахад харгалзах нийт үндсэн болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хангалттай барьцаа хөрөнгөтэй буюу гуравдагч этгээдээр үүргийг гүйцэтгүүлэх боломжтой, мөн ижил барьцаа хөрөнгөөр үүргийг гүйцэтгэлийг хангуулахад тэргүүн ээлжинд хангагдах боломжтой талаар банк эсвэл Монголбанкнаас дүгнэсэн.
- 2.2.4. Нэг төлбөр хариуцагчид хамаарах хамааралтай активуудын материаллаг хэсгийг чанаргүй ангилалд үнэлэхээр байгаа тохиолдолд уг төлбөр хариуцагчид олгосон бусад активын эцсийн ангиллыг бүхэлд нь чанаргүй ангиллаар тогтооно. Энэ шаардлага нь иргэд болон өрх гэрт олгосон активт хамаарахгүй бөгөөд эдгээрт чанаргүй ангилал тогтоох эсэхийг актив тус бүрийн үнэлгээгээр шийдвэрлэнэ.
- 2.2.5. Нэгээс дээш төлбөр хариуцагчдад олгосон активууд нь хамааралтай активууд бөгөөд тэдгээрийн аль нэг активыг чанаргүйд ангилах нь уг хамааралтай активууд дахь бусад активыг чанаргүйд ангилах үндэслэл болохгүй. Уг чанаргүй активыг хамааралтай активт харгалзах бусад төлбөр хариуцагчдын санхүүгийн чадамж, нөхцөл байдалтай харьцуулж, үнэлсний үндсэнд хамааралтай активын бусад хэсэгт чанаргүй ангилал тогтоох эсэхийг шийдвэрлэнэ.
- 2.2.6. Банкин дахь активуудын хамаарлыг төлбөр хариуцагчаар дамжуулан тогтоохдоо Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан “Холбогдох этгээд”-ийн тодорхойлолтын агуулга, зарчимтай уялдуулсан байна.
- 2.2.7. Банк нь бусад санхүүгийн байгууллагатай хамтран нэг төслийг санхүүжүүлэх зорилгоор хамтын санхүүжилтийн активыг нэг актив гэж тооцож, оролцогч банк тус бүрт бүртгэлтэй холбогдох активуудад нэг эцсийн ангилал тогтооно. Хамтын санхүүжилтийн активын хяналтыг аль нэг банк нь дангаараа хэрэгжүүлж болох бөгөөд энэ талаар холбогдох гэрээ, хэлцэлд тодорхой заасан байна. Уг гэрээнд хамтын санхүүжилтийн активтай холбоотой үүсэх эрсдэлийг оролцогч банк тус бүрээр тодорхой тусгасан байна.

### 2.3. Тэнцлийн гадуурх актив

2.3.1. Тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа бусад актив, (хүлээж болзошгүй) үүргийг энэ журмын хавсралт 2-т заасан чанарын хүчин зүйлээр үнэлж тогтооно.

2.3.2. Тэнцлийн гадуур бүртгэлтэй баталгаа, батлан даалт болон бусад хүлээж болзошгүй үүргийг банкаар хангуулахаар гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдэд Банк эсвэл Монголбанкнаас дараах нийтлэг нөхцөл байдал үүссэн талаар дүгнэсэн тохиолдолд холбогдох активын ангиллыг бууруулна.  
Үүнд:

2.3.2.1. Санхүүгийн болон төлбөрийн чадварын үзүүлэлт муудсан эсвэл сүүлийн үед эрчимтэй муудаж байгаа, үйл ажиллагаа эрхэлдэг салбарт аливаа хүндрэл, доголдол үүссэнээс банкнаас гэрээнд заасан болзошгүй үүргийг биелүүлсний дараа төлбөр хариуцагчаас шаардлагатай авлагыг хугацаанд нь, түргэн шуурхай төлүүлэх боломж багассан талаар дүгнэсэн;

2.3.2.2. Буцаан дуудахгүй (irrevocable) нөхцөлтэй зээлийн шугам болон түүнтэй адилтгах бусад активаар банкнаас санхүүжилт авах эрхтэй этгээдийн зээлжих чадвар, санхүү болон төлбөрийн чадвар муудсанаас ирээдүйд авах активын үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх боломж багассан талаар дүгнэсэн;

2.3.2.3. Банктай үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа хийх гэрээ, хэлцэл байгуулсан талын (counterparty) санхүүгийн болон төлбөрийн чадвар муудсан, муудах эрсдэл нэмэгдсэн, эсвэл зээлжих чадвар буурсан талаар зэрэглэл тогтоох олон улсын болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон зэргээс шалтгаалан банкнаас холбогдох арилжаанаас орох мөнгөн урсгалыг бүрэн хэмжээгээр авч чадахааргүй талаар дүгнэсэн.

2.3.3. Тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн ангиллыг энэ журмын 2.3.1-д заасны дагуу тогтоохдоо холбогдох гэрээнд тусгасан хэлцлийн хэрэгжих хугацаа, холбогдох гэрээнд заасан бол болзошгүй үүргийг биелүүлсний дараах төлбөр хариуцагчаас авах авлагын эргэн төлөлтийн хуваарийг харгалзан үзнэ.

2.3.4. Тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийг хэрэгжүүлсний дараа тэнцлийн доторх холбогдох активын төрөл, үлдэгдэл дүнгээр бүртгэж энэ журмын 2.1.8 болон активын ангилал, эрсдэлийн санг байгуулахтай холбоотой бусад шаардлагыг банкнаас мөрдөж ажиллана.

### 2.4. Бүтэц өөрчлөгдсөн актив

2.4.1. Төлбөр хариуцагчид учирсан санхүүгийн хүндрэлээс шалтгаалан банкны дүгнэлт эсвэл төлбөр хариуцагчийн хүсэлтийг харгалзан активын нөхцөлд хөнгөлөлт үзүүлсэн тэнцлийн болон тэнцлийн гадуурх активыг бүтэц өөрчлөгдсөн актив гэж үзнэ. Доорх болон түүнтэй адилтгах бусад нөхцөлүүдийг хөнгөлөлттэй нөхцөл гэж үзнэ:

- 2.4.1.1. Анхны гэрээнд заасан активын эргэн төлөгдөх хуваарьт хүүгээс чөлөөлөх хугацаа сунгах (grace period), зөвхөн хүү төлөх хугацааг сунгах, үндсэн төлбөрийг хугацааны сүүл хэсэгт их дүнтэйгээр төлүүлэхээр хуваарилах (balloon payment) эсвэл хугацааны эцэст бүхэлд нь төлүүлэх (bullet payment) зэрэг өөрчлөлт оруулсны үр дүнд сар, улирал, хагас жил, жил бүрийн болон түүнээс дээш давтамж бүрт төлөх үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмжээг өөрчлөн тогтоосон;
  - 2.4.1.2. Зах зээлийн ерөнхий нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд хүүгийн түвшинг анх гэрээнд тохирсон түвшнээс өөрчлөн (хойшлуулах, цуцлах гэх мэт) тогтоосон;
  - 2.4.1.3. Хуримтлагдсан хүүгийн авлагыг хүүг бүхэлд нь болон хэсэгчлэн хөнгөлөх, чөлөөлөх байдлаар бууруулсан;
  - 2.4.1.4. Хүүгийн авлагыг бүхэлд нь болон хэсэгчлэн үндсэн төлбөрт шингээн шинэ үндсэн төлбөрийг тогтоосон буюу хүүг капиталжуулсан;
  - 2.4.1.5. Эргэн төлөгдөх хугацаа эсвэл хуваарийг (хүү, үндсэн төлбөрийн давтамж) хойшлуулахдаа, хүүгийн түвшинг ижил эрсдэлийн төлөвтэй, шинээр олгож байгаа активын хүүгийн ерөнхий түвшингээс доогуур тогтоосон;
  - 2.4.1.6. Эргэн төлөгдөх хугацаа болон хуваарийг (хүү, үндсэн төлбөрийн давтамж) сунгахдаа ижил эрсдэлийн төлөвтэй активын эргэн төлөгдөх хугацаанаас материаллаг түвшинд ялгаатайгаар буюу урт хугацаагаар сунгасан;
  - 2.4.1.7. Барьцаа хөрөнгийг чөлөөлөх эсвэл Зээл-Үнэлгээний харьцаа (LTV) нь зөвшөөрөгдөх түвшнээс муудсан;
  - 2.4.1.8. Төлбөр хариуцагчийн өрийг хувьцаанд хөрвүүлэх (хувьцаат капитал);
  - 2.4.1.9. Үүргийн гүйцэтгэлийг хангуулах, төлбөр барагдуулах хугацааг сунгах;
  - 2.4.1.10. Активын гэрээнд тусгасан нөхцөл (covenants)-ийг хөнгөлөх.
- 2.4.2. Активыг бүтэц өөрчлөгдсөнд тооцоход банк болон төлбөр хариуцагчийн хооронд активын шинэ нөхцөлийг харилцан тохиролцож, гэрээ байгуулна.
  - 2.4.3. Бүтэц өөрчлөгдсөн актив тус бүрийн хувьд нөхцөл, хугацаа, хэмжээнд өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шалтгаан, төлбөр хариуцагчийн активыг эргэн төлөх чадвар нь шинэ нөхцөлтэй нийцсэн, эргэн төлөлт хийх боломжтой байгаа эсэхийг банкнаас өөрийн дотоод аргачлал, үнэлгээгээр баталгаажуулж, банкны удирдлагын түвшинд эсвэл түүнтэй адилтгах хорооноос активын бүтцийг өөрчлөх эсэх талаар шийдвэрлэнэ. Банк нь зөвхөн төлбөр хариуцагчаас бүтэц өөрчлөгдсөн активыг шинэ нөхцөлийн дагуу хугацаанд нь, бүхэлд нь төлж барагдуулах боломжтой гэж үнэлсэн тохиолдолд активын бүтцийг өөрчилнө.
  - 2.4.4. Активыг бүтэц өөрчлөгдсөн активт шилжүүлэхтэй холбоотойгоор одоогийн үүссэн болон ирээдүйд үүсэх алдагдал, үнэ цэнийн бууралтыг банкны санхүүгийн тайланд тухай бүрт тусгана.

- 2.4.5. Активын бүтцийг өөрчилсний үр дүнд тус активт тавигдах нөхцөл нь шинээр олгож байгаа ижил эрсдэлийн төлөвтэй активын нөхцөлтэй ижил бөгөөд активын бүтцийн өөрчлөлт нь төлбөр хариуцагчийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалаагүй бол уг активыг бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүй.
- 2.4.6. Банкнаас хэрэглээний зориулалттай олгосон активаас бусад активын төлбөр хариуцагч хуулийн этгээдийн зээлжих болон төлбөрийн чадвар найдвартай боловч үйл ажиллагаа эрхэлж байгаа салбар эсвэл өөрийн дотоод онцлогоос шалтгаалж түр хугацааны санхүүгийн хүндрэл учирсан ч төлбөр хариуцагчаас тухайн хугацаанд багтаан хэвийн үйл ажиллагаа эрхэлж, активын үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг анхны гэрээнд заасан нөхцөлөөр бүрэн хэмжээгээр эргэн төлөх чадвартайг өөрийн дотоод аргачлал, үнэлгээгээр тогтоож, баталгаажуулсан тохиолдолд активын эргэн төлөх хугацааг сунгахгүйгээр активын гэрээний эргэн төлөгдөх нөхцөлд 12 сараас дээшгүй хугацаагаар өөрчлөлт оруулсан активыг бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүй байж болно. Энэ хугацаанд төлбөр хариуцагчийн санхүүгийн байдал сайжрахгүй, эргэн төлөлтийн хоцролт үүссэн тохиолдолд гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсан хугацаанаас эхлэн бүтэц өөрчлөгдсөн активт тооцож холбогдох ангилал, эрсдэлийн санг энэ журамд заасан бүтэц өөрчлөгдсөн активтай холбоотой заалтын хүрээнд хийж гүйцэтгэнэ.
- 2.4.7. Хэвийн болон чанаргүй активыг бүтэц өөрчлөгдсөн ангилалд тогтоож болно. Чанаргүй активын бүтцийг өөрчлөх тохиолдолд тус активыг чанаргүй ангилалд хэвээр үлдээнэ. Хэвийн активын бүтцийг өөрчлөхөд, активт тавих шинэ нөхцөлөөс үл хамаарч тус активыг чанаргүй активын нөхцөлийг хангаж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв активын бүтцийг өөрчлөхөөс өмнө буюу хөнгөлөлттэй нөхцөл тавихаас өмнө уг актив нь чанаргүй ангилалд шилжихээр байгаа бол бүтэц өөрчлөгдсөн активыг чанаргүй ангилалд ангилна.
- 2.4.8. Нэг активын бүтцийг хэвийн болон ангилал буурсан хэсгүүдэд хэсэгчлэн хувааж, тусад нь ангилахыг хориглоно.
- 2.4.9. Активын бүтцийг төлбөр хариуцагчид учирсан санхүү, төлбөрийн чадварын хүндрэлийг нуун дарагдуулах, эргэн төлөгдөх төлбөрийн хэмжээг хойшлуулах, активын ангиллыг чанаргүй ангилалд шилжүүлэх болон банкнаас шаардлагатай эрсдэлийн сан байгуулахаас зайлсхийх зорилгоор өөрчлөхийг хориглоно.
- 2.4.10. Банкнаас зөвхөн энэ журмын 2.9.1-д заасан шаардлагыг нэгэн зэрэг хангасан бүтэц өөрчлөгдсөн активт хэвийн ангилал тогтоож болно.
- 2.4.11. Дор дурдсан хоёр нөхцөлийг зэрэг хангасан активыг бүтэц өөрчлөгдсөн ангиллаас хасч болно. Үүнд:
- 2.4.11.1. Шинэ гэрээний нөхцөлийн дагуу сүүлийн 6 сарын турш (тайлагнах доод шаардлага) төлбөл зохих активын төлбөрийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн төлж байсан. Бүтэц өөрчлөх үед активын хэвийн эсвэл чанаргүй эцсийн ангилалд байгаагаас үл хамаарч эргэн төлөлтийн хоног тооцох хугацааг активын бүтцийг өөрчилснөөс хойш төлөгдөх анхны эргэн төлөлтөөс эхлэн тооцно.

- 2.4.11.2. Төлбөр хариуцагч нь санхүүгийн хүндрэлээ шийдвэрлэсэн.
- 2.4.12. Энэ журмын 2.9.1-д заасан өөрчлөлтийг бүтэц өөрчлөгдсөн активт нэг удаа хэрэгжүүлж болно.
- 2.4.13. Чанарын ангиллаас үл хамаарч, энэ журмын 2.9.1-д заасан шаардлага, нөхцөлийг активын бүтцийг өөрчилсөн болон түүнээс хойших хугацаанд хангаагүй бүтэц өөрчлөгдсөн активын хугацааны ангиллыг анхны гэрээнд тусгасан эргэн төлөгдөх хуваарьт үндэслэн тооцно.
- 2.4.14. Банк нь төлбөр хариуцагч болон түүний холбогдох этгээдэд актив болон харгалзах хүүг нэмж актив олгох, эх үүсвэр байршуулах зэргээр төлүүлэхийг хориглоно.
- 2.5. Өмчлөх бусад хөрөнгө
- 2.5.1. Өмчлөх бусад хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн зааварт заасны дагуу худалдан борлуулах зориулалттай, банкны үйл ажиллагаанд ашиглагдахгүй үл хөдлөх хөрөнгө (цаашид үл хөдлөх хөрөнгө), хөдлөх хөрөнгө, үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгөнд төрөлжүүлэн, төрөл тус бүрт ангилал тогтооно.
- 2.5.2. Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөнд хамаарах өмчлөх бусад хөрөнгийн ангиллыг зөвхөн энэ журмын Хавсралт 1.б.-д заасан хугацааны хүчин зүйлээр ангилна.
- 2.5.3. Үл хөдлөх, хөдлөх хөрөнгөөс бусад өмчлөх бусад хөрөнгийг энэ журмын Хавсралт 1.а.-д заасан холбогдох активт харгалзах хугацааны, Хавсралт 2-т заасан чанарын үнэлгээгээр тооцож, эцсийн ангиллыг Хавсралт 3.а.-ын дагуу тогтооно.
- 2.5.4. Банк нь өмчлөх бусад хөрөнгийг дотоод хэрэгцээнд ашиглахаар төлөвлөж байгаа бол уг шийдвэрийг тухайн хөрөнгийг өмчлөлд авах үед гаргаж, Монголбанкнаас уг хөрөнгийг холбогдох дансанд бүртгэх зөвшөөрлийг авна. Банкны өмчлөх бусад хөрөнгөнд хамаарах үл хөдлөх хөрөнгө ашиглалтад ороод 5-аас ихгүй, хөдлөх хөрөнгийн хувьд үйлдвэрлэсэн хугацаанаас хойш 1-ээс ихгүй жил өнгөрсөн бол энэ журмын 2.5.2-д заасан үнэлгээгээр тооцсон хэвийн активаас бусад активын эцсийн ангиллыг нэг ангиллаар нэмэгдүүлж болно.
- 2.5.5. Банкнаас ашиглах зорилгыг харахан тодорхойлоогүй Өмчлөх бусад хөрөнгийг банкны эзэмшилд анх шилжүүлэхдээ үнэт цаасны хувьд Бусад санхүүгийн хөрөнгө, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн хувьд Бусад санхүүгийн бус хөрөнгө дансанд бүртгэнэ.
- 2.5.6. Өмчлөх бусад хөрөнгийг энэ журмын 2.5.5-т заасны дагуу банкны эзэмшилд бүртгэснээс хойш 1 сарын хугацаанд багтаан ашиглах зориулалтыг тодорхойлж, Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.5.Г-д заасны дагуу Бусад хөрөнгийн харгалзах данснаас банкнаас ангилахаар шийдвэрлэсэн дансанд шилжүүлэх эсвэл шилжүүлэх боломжгүй гэж үзсэн активыг Бусад хөрөнгийн дансанд хэвээр үлдээж бүртгэнэ.

- 2.5.7. Үнэт цаас хэлбэрээр эзэмшиж байгаа Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгийг энэ журмын 2.5.5-2.5.6-д заасан зарчмаар бүртгэж энэ журмын үнэт цаасанд хийх ангилал, эрсдэлийн сан байгуулахтай холбоотой шаардлагыг дагаж мөрдөнө.
- 2.5.8. Банкнаас санхүүгийн бус өмчлөх бусад хөрөнгийг дотоод хэрэгцээнд ашиглах зөвшөөрлийг Монголбанкнаас авсан бол өмчлөх бусад хөрөнгийг уг хөрөнгийг ашиглан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших 3 сарын хугацаанд багтаан Үндсэн хөрөнгө болон эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтойг үндэслэн Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх бөгөөд эдгээр хөрөнгөнд эрсдэлийн сан байгуулахгүй.
- 2.5.9. Энэ журмын 2.5.8-д заасан хөрөнгийн холбогдох ангиллын шинж чанар болон ашиглалтын зорилго алдагдах тохиолдолд өмчлөх бусад хөрөнгийн холбогдох дансанд буцаан шилжүүлж, харгалзах эрсдэлийн санг байгуулах бөгөөд уг шилжүүлсэн гүйлгээг буцаахгүй.
- 2.5.10. Өмчлөх бусад хөрөнгөөс Үндсэн хөрөнгөнд шилжүүлэх хэмжээг “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан үндсэн хөрөнгийн зохистой харьцааг хангахуйц байдлаар тогтооно.
- 2.5.11. Худалдан борлуулах зорилготой буюу худалдан борлуулах магадлал өндөртэй Санхүүгийн бус өмчлөх бусад хөрөнгийг Борлуулах зориулалттай хөрөнгөнд бүртгэнэ. Уг дансанд хүлээн зөвшөөрч, бүртгэснээс хойш худалдааны хэвийн нөхцөлөөр нэг жилийн дотор худалдан борлуулах шаардлагатай бөгөөд энэ хугацаанд тус хөрөнгийн тусгай эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.5, 4.6-д заасны дагуу үнэ цэнийн бууралтаар тооцож энэ журмын Хавсралт 4.в.-д заасан Активын тусгай эрсдэлийн сангийн хүрэлцээний дэлгэрэнгүй тайлангийн Өмчлөх бусад хөрөнгөнд харгалзах хүснэгтэд холбогдох дүнг тусгана.
- 2.5.12. Энэ журмын 2.5.11-д заасан хөрөнгийг Борлуулах зориулалттай хөрөнгөнд бүртгэснээс хойш нэг жилийн хугацаанд худалдан борлуулаагүй бол Санхүүгийн бус Өмчлөх бусад хөрөнгөнд буцаан шилжүүлнэ. Буцаан шилжүүлсэн хөрөнгийг энэ журмын Хавсралт 1.б-д заасан хугацааны хүчин зүйлээр тооцох бөгөөд “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын 1.2.1-д заасан зээлийн барьцаанд байгаа орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө бол анх эзэмшилд авснаас хойших борлогдоогүй хоногт, бусад хөрөнгө бол буцаасан өдрөөс хойших борлогдоогүй хоногт тус тус үндэслэн холбогдох ангиллыг тодорхойлж, харгалзах тусгай эрсдэлийн санг Хавсралт 3.в.-д заасны дагуу байгуулна.
- 2.5.13. Энэ журмын 2.5.9 болон 2.5.12-д заасны дагуу Өмчлөх бусад хөрөнгөнд шилжүүлсэн хөрөнгийг дахин борлуулахад бэлэн эсвэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн төрөлд шилжүүлэхгүй.
- 2.5.14. Үл хөдлөх, хөдлөх хөрөнгөнд дотоод болон гадны нөлөөнөөс шалтгаалан эвдрэл учирсан, эсвэл цаашид ашиглах эсвэл борлуулах боломжгүй гэж



мэргэжлийн үнэлгээний байгууллага эсвэл банкнаас дүгнэвэл дээрх хөрөнгийг хугацаа харгалзахгүй муу ангилалд шилжүүлнэ.

## 2.6. Үнэт цаас

- 2.6.1. Үнэт цаасыг зориулалт, банкны үнэт цаасны ангиллын бодлоготой уялдуулан Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу бүртгэнэ.
- 2.6.2. Арилжааны буюу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаасыг банкны тэнцэл дээр болон тэнцлийн гадуур бүртгэлтэй байх хугацаанд үүссэн дараах тохиолдлуудад энэ журамд заасны дагуу ангилал тогтоож, холбогдох тусгай эрсдэлийн санг байгуулна. Үүнд:
  - 2.6.2.1. Өрийн үнэт цаасны хуваарийн дагуу төлөгдөх хүү, үндсэн төлбөр хоцорсон эсвэл төлөгдөөгүй;
  - 2.6.2.2. Өмчлөлийн үнэт цаасанд ногдол ашиг зарласан боловч заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилаагүй бол тухайн ногдол ашгийн дүнгээр;
  - 2.6.2.3. Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадвар муудсан талаар банкнаас эсвэл эрх бүхий байгууллагаас мэдэгдсэн эсвэл татан буугдсан;
  - 2.6.2.4. Холбогдох үнэт цаас нь банкинд активын эрсдэл үүсгэнэ гэж Монголбанк эсвэл банкнаас дүгнэсэн бусад үндэслэл.
- 2.6.3. Энэ журмын 2.6.2.3-т заасан нөхцөл өмчлөлийн үнэт цаасанд үүссэн тохиолдолд хугацааны хүчин зүйлийг Хэвийн ангилалд байхаар тооцож, чанарын хүчин зүйлийн үнэлгээтэй хослуулан үнэт цаасны эцсийн ангилал болон тусгай эрсдэлийн санг тогтооно.
- 2.6.4. Борлуулахад бэлэн ангилалд байгаа үнэт цаасны ангиллыг тогтоож, харгалзах тусгай эрсдэлийн санг байгуулахдаа энэ журмын 2.6.2.1-2.6.2.3, 2.6.3-д заасан шалгуурыг мөрдөнө.
- 2.6.5. Хугацааны эцэс хүртэл эзэмших болон Зээл, авлагын ангилалд байгаа үнэт цаасны ангиллыг энэ журамд заасан хугацааны болон чанарын хүчин зүйлээр тооцож, холбогдох тусгай эрсдэлийн санг Хавсралт 3.а.-д заасны дагуу тооцно.
- 2.6.6. Банкнаас охин, хараат болон хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтад ангилалд хийхгүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.2.2.-т заасны дагуу эрсдэлийн санг тооцож байгуулна.
- 2.6.7. Банк нь өмчийн үнэт цаасаар хөрөнгө оруулсан компанид Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.2.2-т заасны дагуу хяналт, мэдэгдэхүйц нөлөө эсвэл хамтын хяналт тогтоосон эсэхийг нотлох боломжгүй бол холбогдох үнэт цаасыг энэ журмын 2.6.4-д заасны дагуу ангилж, тусгай эрсдэлийн санг байгуулна.
- 2.6.8. Банк нь Хугацааны эцэс хүртэл эзэмших ангилалд байгаа үнэт цаасыг худалдан борлуулсан эсвэл уг ангилалд үнэт цаасыг бүртгэх эрхгүй болсон бол энэ талаар Монголбанкинд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

## 2.7. Багцалсан актив

2.7.1. Банкнаас дараах доод шаардлагыг нэгэн зэрэг хангасан активуудыг нэгтгэн багцалж болно. Үүнд:

2.7.1.1. Тухайн багцалсан активын үлдэгдэлд эзлэх нэг нэгж активын хувийн жин нь 2.0 хувиас ихгүй байх;

2.7.1.2. Багцын нэгж актив тус бүр нь бүтээгдэхүүний төрөл, шинж чанар, байршил, эргэн төлөлтийн хуваарь болон эрсдэлийн түвшин болон бусад нөхцөлийн хувьд хоорондоо ижил төстэй байх;

2.7.1.3. Багцын нэгж актив нь банкны 40 том зээлийн тоонд ороогүй эсвэл хамааралтай актив биш байх;

2.7.1.4. Банкны өөрийн ажилчдын орон сууцны зээл болон өөрийн ажилчдын цалингийн зээлээс бусад банкны холбоотой этгээдэд олгосон актив биш байх;

2.7.1.5. Нэг багцалсан активын нийт үлдэгдэл нь тухайн банкны 40 том зээлдэгчдэд олгосон активын нийлбэр дүнгийн 20 хувиас ихгүй байх.

2.7.2. Энэ журмын 2.7.1-д заасан шаардлагыг хангасан банкны үйл ажиллагааны хүрээнд жижиглэн, жижиг дунд үйлдвэрлэл эсвэл иргэнд олгосон актив гэж тодорхойлсон, бага дүнтэй, олон тооны активуудыг нэгтгэн багцалж болно.

2.7.3. Хувьсах нөхцөлтэй активуудыг нэгтгэн багцалсан активт тооцож болно.

2.7.4. Багцалсан актив дахь нэгж актив нэг бүрийн эцсийн ангиллыг хугацааны хүчин зүйлээр тусад нь хийх бөгөөд тусгай эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.3.Г-д заасан бүлгийн аргыг ашиглан нийт багцын хэмжээнд нэгтгэн үнэлнэ.

2.7.5. Багцын нэгж актив эргэн төлөгдсөн, эсвэл тэнцлийн гадуур бүртгэж багцаас хасагдсан бол энэ журмын 2.7.1-д заасан шаардлагыг хангасан активыг багцад нэмж оруулж болно.

2.7.6. Багцын нэгж актив тухайн багцын нийтлэг, ижил төстэй байдлыг агуулаагүй эсвэл алдагдсан, эсвэл өөрчлөгдсөн тохиолдолд уг нэгж активыг багцаас хасч активын эцсийн ангиллыг хугацаа болон чанарын хүчин зүйлээр тодорхойлно.

2.8. Банкнаас активыг ангилахтай холбоотой тавих шаардлага.

2.8.1. Активын эрсдэлийг удирдах, хянах үүргийг банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага хүлээх бөгөөд энэ журмын 1.4-т заасан активыг ангилах, активын эрсдэлийн дотоод удирдлагын бодлого, журам, заавар нь дараах шаардлагыг хангасан байна:

2.8.1.1. Активын ангилал, эрсдэлийн сангийн бодлого болон хяналтын үйл ажиллагааг банкны удирдлага, зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагааны боловсронгуй байдал, цар хүрээ болон эрсдэлийн төлөвтэй уялдсан байхаар зохицуулсан байх;

2.8.1.2. Активын ангилал, тусгай болон ерөнхий эрсдэлийн санг дотоод бодлого, нягтлан бодох бүртгэлийн заавар болон Монголбанкнаас энэ журмаар тогтоосон шаардлагатай нийцүүлэн хэрэгжүүлэх дотоод

хяналтын нэгжийн ажил үүргийн хуваарь, эрх үүргийг нарийн тодорхойлсон байх;

2.8.1.3. Банкны зүгээс активын чанарыг үнэлэхдээ тоон үнэлгээ болон активыг үнэлж байгаа мэргэжилтний ур чадварын хүрээнд өгсөн үнэлэлт, дүгнэлтийг хэрхэн хослуулах, хязгаарлалт тогтоох нөхцөлүүдийг тодорхой тусгасан байх.

2.8.2. Активын эрсдэлийн удирдлагын нэгжийн үйл ажиллагааг банк, банкны нэгж нь активын эрсдэл, түүнд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийн өөрчлөлттэй тухай бүр, цаг алдалгүй уялдуулж, тохируулах шаардлагатай бөгөөд активыг ангилах, активын эрсдэлийн дотоод удирдлагын бодлого журам, зааварт дараах болон түүнтэй адилтгах бусад асуудлуудыг хэрэгжүүлэхээр тусгаж, баримтжуулсан байна:

2.8.2.1. Активын чанарт хяналт тавих, тандах;

2.8.2.2. Тэнцлийн болон тэнцлийн гадуурх активын чанарыг тухай бүр хэмжиж тооцох арга барил, үйл явц;

2.8.2.3. Төлбөр хариуцагч, батлан даагчийн эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотой үүсэх активын эрсдэлийн үнэлгээ;

2.8.2.4. Барьцаа хөрөнгийн үнэлгээ;

2.8.2.5. Чанар муудсан эсвэл эргэн төлөгдөх боломж багассан активын ангилал бууруулах, тэнцлээс гаргахад баримтлах арга барил;

2.8.2.6. Активын ангилал болон эрсдэлийн сангийн үнэлгээг баталгаажуулах;

2.8.2.7. Активын эрсдэлийн сангийн хэмжээ нь банкинд активын үйл ажиллагаанаас бодитоор илэрсэн болон хүлээгдэж байгаа алдагдлыг барагдуулахад хангалттай байхаар тооцох аргачлалыг нэвтрүүлэх;

2.8.2.8. Чанар муудсан, эрсдэлтэй активыг барагдуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой зохицуулалт, албадлагын арга хэмжээ;

2.8.2.9. Активын эрсдэлийг тооцох статистик загварчлал болон бусад арга барилын үр дүнг буцаан шалгадаг, үр нөлөөг тооцох, баталгаажуулах аргачлалтай байх.

2.8.2.10. Активын эргэн төлөлтөд нөлөөлж болох хүчин зүйлс:

а. Төлбөр хариуцагч эсвэл баталгаа гаргагч этгээдийн санхүү, төлбөрийн чадвар;

б. Гэрээний нөхцөлийг зөрчих магадлал;

в. Төлбөр хариуцагч (хуулийн этгээд) татан буугдах, дампуурах боломж эсвэл удирдлага, бүтэц өөрчлөгдөх нөхцөлүүд;

г. Төлбөр хариуцагчид олгосон активын бүтэц, нөхцөлийг өөрчлөхөд тавигдах шаардлага, зөвшөөрөгдөх нөхцөлүүд;

д. Активыг багцлан үнэлж байгаа бол тухайн багцад хамаарах активын төрлийн чанаргүй ангилалд шилжиж байсан хандлага, шилжилт хөдөлгөөнийг тооцох аргачлал;

е. Барьцаа хөрөнгийн талаар баримтлах бодлого, активын чанарын

- үнэлгээг өөрчлөхөд нөлөөлөх барьцаа хөрөнгийн үнэлгээ, төрөл, хөрвөх чадвартай холбоотой нөхцөлүүд;
- ж. Төлбөр хариуцагч, төлбөр хариуцагчийн батлан даагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байх бусад тохиолдол, нөхцөлүүд, тэдгээрт банкны зүгээс авах арга хэмжээ.
- 2.8.3. Төлбөрийн чадвар алдагдсан, дампуурсан төлбөр хариуцагчид олгосон активын эцсийн ангиллыг эргэлзээтэй ангиллаас дээшгүй байхаар тогтооно.
- 2.8.4. Хууль хяналтын байгууллагаар гэмт хэргийн шинж чанартай үйлдлээс үүссэн байж болзошгүй шалтгаанаар шалгагдаж байгаа активын хугацааны эцсийн ангиллыг муу ангилалд тогтооно.
- 2.9. Ангилал буурсан активын ангиллыг дээшлүүлэх
- 2.9.1. Дараах нөхцөлүүд хамтдаа илэрсэн анхаарал хандуулах эсвэл чанаргүй эцсийн ангилалтай актив болон бүтэц өөрчлөгдсөн активыг Хэвийн ангилал хүртэл нэмэгдүүлж болно:
- 2.9.1.1. Төлбөр хариуцагч нь 90-ээс дээш хоногоор хэтэрсэн материаллаг хэмжээний хугацаа хэтэрсэн төлбөргүй;
- 2.9.1.2. Сүүлийн 6 сар болон түүнээс дээш хугацаанд 3 удаагийн материаллаг хэмжээний эргэн төлөлтийг тогтмол хийсэн;
- 2.9.1.3. Төлбөр хариуцагчийн санхүү, төлбөрийн чадварын нөхцөл байдал сайжирснаар активыг анхны эсвэл шинэ гэрээний нөхцлийн дагуу бүхэлд нь төлж барагдуулах магадлал нэмэгдсэн;
- 2.9.1.4. Активт энэ журамд заасан төлбөр хэтрэлт (дефолт) болон нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан үнэ цэнийн бууралт үүсээгүй;
- 2.9.1.5. Монголбанкнаас хийсэн газар дээрх шалгалтын үнэлгээнд үндэслэн эцсийн ангиллыг дээшлүүлэхээр зөвшөөрсөн актив.
- 2.9.2. Энэ журмын 2.9.1-т заасны дагуу ангилал хийсэн активын эргэн төлөлтийг төлбөр хариуцагчаас активыг цаашид үргэлжлүүлэн авах, ангиллаа нэмэгдүүлэх сэдлээр хийсэн буюу активын чанар бодитоор сайжраагүй талаар банк эсвэл Монголбанкны зүгээс дүгнэвэл тус активын ангиллыг дээшлүүлэхгүй.
- 2.9.3. Энэ журмын 2.8.3 болон 2.8.4 заалтад хамаарах активт журмын 2.1.2, 2.9.1, 2.4.10-д заасан хөнгөлөлт болон ангилал дээшлүүлэх нөхцөл хамаарахгүй.
- 2.9.4. Одоогоор бүртгэлтэй байгаа чанаргүй активаас хэсэгчлэн тэнцлээс хассан (эргэн төлөгдөх боломжгүй гэж банкнаас үнэлсэн чанаргүй активын тодорхой хэсгийг тэнцлээс хассан зэрэг) бол уг активыг хэвийн ангилалд ангилахгүй.

## **ГУРАВ. АКТИВТ ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ**

- 3.1. Активын эрсдэлийн сан байгуулах үндсэн шаардлага
- 3.1.1. Банк нь дараах төрлөөр активын эрсдэлийн сан байгуулна:
- 3.1.1.1. Ерөнхий эрсдэлийн сан;
- 3.1.1.2. Тусгай эрсдэлийн сан.

- 3.1.2. Ерөнхий болон тусгай эрсдэлийн сангийн нийлбэрээр банкны нийт активын эрсдэлийн сангийн хэмжээг тодорхойлно.
- 3.1.3. Активт байгуулах эрсдэлийн санг хүлээсэн (incurred) болон хүлээгдэж байгаа алдагдлуудыг барагдуулахад хангалттай хэмжээтэй байхаар банкнаас тогтооно. Банкны санхүүгийн тайланд тусгах активын эрсдэлийн сангийн дүнг энэ журмын дагуу тооцсон болон энэ журмын 1.4-т заасан дотоод аргачлалаар тооцсон активын эрсдэлийн сангийн дүнгийн аль ихээр тогтооно.
- 3.1.4. Активын эрсдэлийн санг энэ журамд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.
- 3.1.5. Банк нь удирдлагын үйл ажиллагааны зорилгоор өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлог болон бүтээгдэхүүн үйлчилгээний боловсронгуй байдалд тулгуурлан энэ журамд заасан активын эрсдэлийн сан байгуулах хувь, хэмжээг тооцох аргачлал болон эрсдэлийн сантай холбоотой бусад шаардлагаас ялгаатай байдлаар активын эрсдэлийн санг дотооддоо байгуулах аргачлалыг энэ журмын 1.4-т заасан баримт бичигт тусгаж, мөрдүүлж болно.
- 3.1.6. Банк нь активын эрсдэлийн сангийн тооцооллыг энэ журамд заасан доод шаардлагын дагуу хийхээс гадна өөрийн дотоод аргачлалын дагуу үнэн зөв гүйцэтгэж Монголбанкинд энэ журмын 3.6.1-т заасан хугацаанд тайлагнах үүрэгтэй.
- 3.1.7. Энэ журмын 1.4-т заасан дотоод аргачлалыг ашиглах болон активын ерөнхий болон тусгай эрсдэлийн санг Монголбанкинд тайлагнахдаа дараах хүчин зүйлсийг хангасан эсэхийг баталгаажуулна:
  - 3.1.7.1. Активын чанарт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг сонгохдоо зөвхөн активын төрөл бус эдийн засгийн утга санаа, үзүүлэх нөлөөлөлд суурилах;
  - 3.1.7.2. Загварчлал, статистик аргачлал зэрэг ил тод, үнэн зөв үнэлгээ, тооцоололд суурилсан байх;
  - 3.1.7.3. Материаллаг алдаа, өөрчлөлт үзүүлэхээргүй байх;
  - 3.1.7.4. Активын чанарыг үнэлэх дотоод аргачлалд тухайн хугацаанд активын эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлөх голлох хүчин зүйлсийг тусгах.
- 3.1.8. Банкнаас активт байгуулах эрсдэлийн санг нэг актив, хамааралтай активууд эсвэл багцалсан активын хувьд байгуулна.
- 3.1.9. Энэ журмын 2.2.2-д заасан хамааралтай активуудын нийлбэр үлдэгдлээс нэг эрсдэлийн сан байгуулна. Энэ журмын 2.2.3-д заасан нөхцөлийг хангасан хамааралтай активуудын салгаж ангилахыг зөвшөөрсөн хэсгээр тусад нь эрсдэлийн сан байгуулна.
- 3.1.10. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д тэнцлийн гадуурх активаас бусад эрсдэлээр жигнэсэн активыг тооцохдоо зөвхөн энэ журамд заасан тусгай эрсдэлийн сангаар активаас хорогдуулсан дүнг ашиглана.

- 3.1.11. Тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүргийг зээлтэй адилтган тооцож, энэ журамд заасан аргачлалын дагуу эрсдэлийн санг байгуулах бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах нөөц дансанд нэрийн данс нээж бүртгэнэ.
- 3.1.12. Энэ журмын 3.1.11-д заасны дагуу эрсдэлийн сан байгуулсан тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийг нь энэ журмын 2.1.8-д заасны дагуу өөрчилж тэнцлийн дотор бүртгэх тохиолдолд Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах нөөц дансанд байгуулсан сангийн хэлбэр өөрчлөгдөж, тэнцэл дотор шилжсэн активт харгалзах тусгай эрсдэлийн сангийн данс руу шилжүүлж тусгана.
- 3.1.13. Өмчлөх бусад хөрөнгөнд багтах үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн эрсдэлийн санг Хавсралт 3.в-д заасны дагуу, бусад санхүүгийн хөрөнгийг Хавсралт 3.а-д заасны дагуу байгуулна. Тэнцлийн гадуурх активыг Хавсралт 3.б-д заасны дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулна.
- 3.1.14. Банкнаас эрсдэлийн санг бүртгэх, зориулалтын дагуу ашиглах, зарцуулах гүйлгээг Монголбанкнаас баталсан Нягтлан бодох бүртгэлийн багц материалын дагуу хийж, бүртгэнэ.

## **3.2. Эрсдэлийн сан тооцох активын үлдэгдэл**

- 3.2.1. Банкнаас ерөнхий болон тусгай эрсдэлийн санг дор дурдсан тохируулга хийсэн активын үлдэгдэлд байгуулна. Үүнд:
  - 3.2.1.1. Хадгаламж барьцаалсан актив бол барьцааны төгрөгт хөрвүүлсэн дүнгээр активаас хорогдуулсан дүнгээс;
  - 3.2.1.2. Эх үүсвэртэй тэнцлийн гадуурх аккредитив, баталгаа, батлан даалт болон түүнтэй адилтгах активаас тухайн эх үүсвэрийн дүнгээр хорогдуулсан дүнгээс;
  - 3.2.1.3. Төв банкны үнэт цаасаар баталгаажсан активыг баталгааны дүнгийн 100%-иар хорогдуулсан дүнгээс;
  - 3.2.1.4. Олон улсын зэрэглэл тогтоогч агентлагаас ААА зэрэглэл тогтоосон олон улсын олон талт хөгжлийн банк, санхүүгийн байгууллага (Азийн хөгжлийн банк, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк гэх мэт)-аас гаргасан баталгаатай активын баталгааны 100%-иар хорогдуулсан дүнгээс;
  - 3.2.1.5. Монгол болон гадаад улсын Засгийн газраас баталгаа, засгийн газрын бонд болон түүнтэй адилтгах үнэт цаасаар баталгаажсан актив бол, баталгааны хэмжээг энэ журмын Хавсралт 4.и-д заасан хувиар тооцсон дүнгээр активыг хорогдуулсан дүнгээс;
  - 3.2.1.6. Хувьсах нөхцөлтэй актив нь овердрафт бол зөвхөн төлбөр хариуцагчаас зөвшөөрсөн хязгаарт тохируулан авсан дүнгээс; бусад тохиолдолд төлбөр хариуцагчаас эргэн төлөх шаардлагатай нийт авлагын дүнгээс;
  - 3.2.1.7. Банкны тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа үүсмэл санхүүгийн хэрэгслийн “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны

шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан аргачлалаар тооцсон зээлтэй адилтган тооцох өртөг болон Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.4.В-д заасны дагуу бодит үнэ цэнээр (Mark-to-Market) тооцоход эерэг дүн буюу авлага үүсгэхээр байгаа үнэлгээний аль ихээр;

- 3.2.1.8. Төлбөр хариуцагчийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай бус, идэвхтэй зах зээл дээр түргэн хугацаанд арилжаалагддаг болон бодит үнэ цэнийг тогтоох боломжтой талаар Монголбанкнаас гаргасан тусгай удирдамж, зөвлөмжийн дагуу Монголбанкны газар дээрх шалгалтын үнэлгээгээр хүлээн зөвшөөрсөн зарим барьцаа хөрөнгөөр баталгаажсан бол барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийн 80 хүртэлх хувиар активын үнэлгээг хорогдуулсан дүнгээс.
- 3.2.2. Тусгай эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан зээл хэлбэрээр багцалсан активаас бусад үнэ цэнийн бууралтын аргачлалыг ашиглан банкнаас тооцохоор шийдвэрлэсэн активт энэ журмын 3.2.1-т заасан зохицуулалт үйлчлэхгүй.
- 3.2.3. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тэнцлийн гадуурх активаас бусад эрсдэлээр жигнэсэн активын тооцоонд тухайн активыг зөвхөн тусгай эрсдэлийн сангаар цэвэршүүлж тооцох бөгөөд ерөнхий эрсдэлийн санг нийт активын үлдэгдлээс цэвэршүүлэн тооцохгүй.
- 3.2.4. Тэнцлийн гадуурх активыг түүнд байгуулсан тусгай эрсдэлийн сангаар цэвэршүүлж тооцохгүй.

### **3.3. Ерөнхий эрсдэлийн сан**

- 3.3.1. Банкнаас эдийн засаг, санхүүгийн салбар болон өөрийн үйл ажиллагаанаас үүсч болох ерөнхий эрсдэлийн түвшинд үндэслэн тооцсон, ирээдүйд бодитоор илэрч болзошгүй алдагдлаас сэргийлэх зорилгоор тухайн активаас ерөнхий эрсдэлийн санг зардлаар байгуулж Монголбанкны Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.2.1.Г, 6.7.-д заасан эрсдэлийн сангийн нөөцөд бүртгэнэ.
- 3.3.2. Активт байгуулах ерөнхий эрсдэлийн санг активыг бүртгэснээс эхлэн эргэн төлөгдөх хүртэлх хугацааны турш байгуулж, зарцуулна.
- 3.3.3. Монголбанкнаас дор дурдсан активын нийт үлдэгдэлд тооцох ерөнхий эрсдэлийн сангийн хувь хэмжээг байгуулах доод шаардлагыг тавина:
  - 3.3.3.1. Зээлийн үлдэгдэл;
  - 3.3.3.2. Бусад актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүрэг.
- 3.3.4. Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, санхүүгийн салбарт гарсан томоохон өөрчлөлт, эрсдэлийн ерөнхий түвшинд суурилан энэ журмын 3.3.3-д заасан ерөнхий эрсдэлийн сангийн хувь хэмжээг энэ журмын 4.2-т заасан Монголбанкнаас тогтоосон доод шаардлагаас багагүй хувь, хэмжээгээр өөрчлөн тогтоож болно.

3.3.5. Банкнаас өмнөх хугацаанд тооцсон боловч илрэх нь тодорхойгүй алдагдал бодитоор үүсч, хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд эрсдэлийн сангийн нөөц дансанд бүртгэлтэй байгаа ерөнхий эрсдэлийн сангийн үлдэгдэл дүн болон нийт активаас үүссэн төлөвлөөгүй алдагдлын дүнд тохируулан тусгай эрсдэлийн санд шилжүүлэх эсвэл нэгдсэн байдлаар барагдуулна.

### **3.4. Тусгай эрсдэлийн сан**

3.4.1. Банкнаас активт байгуулах тусгай эрсдэлийн сангийн доод хэмжээг энэ журмын Хавсралт 3.а., Хавсралт 3.б. болон Хавсралт 3.в.-д тус тус заасны дагуу тооцож, байгуулна.

3.4.2. Тусгай эрсдэлийн санг банк нь дотоод аргачлалд суурилан тооцож болох бөгөөд банкны санхүүгийн тайланд тусгах нийт эрсдэлийн сангийн хэмжээ нь энэ журмын дагуу тооцсон хэмжээнээс багагүй байна.

3.4.3. Тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн тусгай эрсдэлийн санг холбогдох гэрээнд тусгасан хэлцэл хэрэгжих хугацаа болон холбогдох гэрээнд заасан бол болзошгүй үүргийг биелүүлсний дараа төлбөр хариуцагчаас авах авлагын эргэн төлөлтийн хуваарийг харгалзан үзсэнээр энэ журмын Хавсралт 3.б.-д заасны дагуу байгуулж Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах нөөц дансанд бүртгэнэ.

3.4.4. Энэ журмаар зөвшөөрсөн багцалсан активын тусгай эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.3.Г-д заасан бүлгийн аргачлалын дагуу тооцох буюу багцын үнэ цэнэ буурсан болон буураагүй хэсгээс тооцсон эрсдэлийн сангуудын нийлбэрээр тооцно.

3.4.5. Тэнцлийн гадуурх актив, үнэ цэнийн бууралтаар эрсдэлийн сан тооцсон үнэт цаас болон өмчлөх бусад хөрөнгөнд багтах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөөс бусад активын ангиллыг энэ журмын 2.9, 2.5.4 болон энэ журамд заасан бусад үндэслэлээр-бууруулах эсвэл дээшлүүлсэн тохиолдолд тус активын хугацааны болон чанарын үнэлгээг ижил ангилалтай байхаар тооцож Хавсралт 3.а.-д тусгасан харгалзах эрсдэлийн санг байгуулна.

### **3.5. Активыг тэнцлээс хасах**

3.5.1. Банкнаас дараах активыг одоогийн болон шинээр байгуулсан эрсдэлийн сангаас дор дурдсан нөхцөлд дараах үндэслэлээр улирал тутам хорогдуулж болно:

3.5.1.1. Активыг төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарснаас хойш 180 хоногийн дотор төлбөр хариуцагчаас төлбөрийг бүрэн хийгээгүй нөхцөлд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр;

3.5.1.2. Төлбөр хариуцагчаас тодорхой хэсгийг гаргуулахаар шүүхийн шийдвэр гарсан боловч үлдэх хэсгийг төлбөр хариуцагч хариуцахгүй болсныг тогтоосон шүүхийн шийдвэрээр тухайн үлдэх хэсгийг;

3.5.1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай шүүгчийн шийдвэр болон ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор холбогдох активын дүнг;



- 3.5.1.4. Банкны үнэлгээгээр цаашид эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй гэж тооцогдсон муу ангилалтай активыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр;
- 3.5.1.5. Банкны хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтанд олгосон активт энэ журмын 3.5.1.1, 3.5.1.4 дэх заалт хамаарахгүй.
- 3.5.2. Банкны хувь эзэмшигч тухайн банкин дахь зээлээ төлж чадахгүй бол эхний ээлжинд барьцаа хөрөнгийг худалдаж орсон орлогоор, хэрэв зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр уг орлогоос давж байвал Банкны тухай хууль тогтоомжид заасан банкинд авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээний хүрээнд тухайн банкинд хувь нийлүүлсэн хөрөнгийг худалдаж, орсон орлогоор зээлийг төлүүлнэ.
- 3.5.3. Банк энэ журмын 3.5.1, 3.5.6-д заасны дагуу активыг холбогдох сангаас хаасан болон активыг тэнцлээс хассан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийн хамт жил бүрийн 4 дүгээр сард багтаан Монголбанкинд ирүүлнэ.
- 3.5.4. Активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тохиолдолд тэнцлийн гадуурх дансанд бүртгэж, төлүүлж барагдуулах арга хэмжээг үргэлжлүүлнэ.
- 3.5.5. Эрсдэлийн сангаар хорогдуулж, тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн актив хэсэгчлэн эсвэл бүхэлдээ эргэн төлөгдсөн нөхцөлд тэр хэмжээгээр банкны үйл ажиллагааны бусад орлогод бүртгэнэ.
- 3.5.6. Банкнаас активыг худалдан борлуулах, шилжүүлэх тухай гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээнд үндэслэн, банкны тэнцэлд бүртгэлтэй активыг доорх шалгуурыг хангасан тохиолдолд үнэт цаасжуулах болон түүнтэй адилтгах бусад аргачлалыг ашиглах замаар тэнцлээс хасан тооцож, харгалзах активын ангилал, эрсдэлийн санг байгуулахгүй байж болно. Үүнд:
- 3.5.6.1. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 39 (IAS 39)-д заасан үл хүлээн зөвшөөрөх (Derecognition) шалгуур;
- 3.5.6.2. Санхүүгийн тайлагналын олон улсын (СТОУС)-ын холбогдох стандартад заасан үл хүлээн зөвшөөрөх (Derecognition) шалгуур;
- 3.5.6.3. Нягтлан бодох бүртгэлийн зааврын 8.7.7-д заасан шаардлага.
- 3.5.7. Энэ журмын 3.5.6.1-3.5.6.3-д заасан шалгуурыг хангаагүй активыг тэнцэлд үргэлжлүүлэн бүртгэж, холбогдох ангилал болон эрсдэлийн санг байгуулна.

### **3.6. Активыг тайлагнах**

- 3.6.1. Банк активын ангилал хийж, эрсдэлийн санг байгуулсан, эрсдэлийн сангаас хорогдуулсан болон активт хийгдсэн шилжилт хөдөлгөөн болон эрсдэлийн сангийн задаргааны талаарх сар бүрийн тайланг энэ журмын Хавсралт 4-ийн дор дурдсан дэд хэсгүүдийн дагуу дараа сарын 5-ны ажлын өдрийн дотор Монголбанкны Хяналт шалгалтын газарт бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлнэ:
- 3.6.1.1. Активын эрсдэлийн сан тооцох активын үлдэгдлийн тайланг Хавсралт 4.а.-р;
- 3.6.1.2. Активын үлдэгдэл, эрсдэлийн сангийн хүрэлцээ, хангамжийн

нэгдсэн тайланг Хавсралт 4.б.-р;

3.6.1.3. Активын тусгай эрсдэлийн сангийн хүрэлцээний дэлгэрэнгүй тайланг активын төрөл тус бүрийн хувьд Хавсралт 4.в.-р;

3.6.1.4. Өмчлөх бусад хөрөнгийн шилжилтийн тайланг Хавсралт 4.г.-р;

3.6.1.5. Бүтэц өөрчлөгдсөн активын шилжилтийн тайланг Хавсралт 4.д.-р;

3.6.1.6. Үнэт цаасны үлдэгдлийн задаргаа, эрсдэлийн сангийн байгуулалтын задаргааны тайланг Хавсралт 4.е.-р;

3.6.1.7. 20 том хамааралтай активын тайланг Хавсралт 4.ж.-р;

3.6.1.8. Багцалсан активын параметр үзүүлэлтийн тайланг Хавсралт 4.з.-р.

3.6.2. Банк нь активыг тэнцлээс хасч, эрсдэлийн сангаар хорогдуулан тэнцлийн гадуур бүртгэсэн тухай бүрт Монголбанкны зээлийн мэдээллийн санд тусгана.

### **3.7. Багцалсан активт тусгай эрсдэлийн сан тооцох аргачлалыг ашиглах**

3.7.1. Багцалсан активт байгуулах эрсдэлийн санг дор дурдсан аргачлалын аль нэгийг эсвэл холимог байдлаар ашиглан байгуулна:

3.7.1.1. Банк, банкны нэгжээс олгосон активын алдагдлын дотоод мэдээллийн арга (internal loss experience);

3.7.1.2. Зэрэглэл тогтоогч байгууллага болон бусад гадаад эх үүсвэрээс гаргасан зээл, активын зэрэглэлийн тоон мэдээлэлтэй уялдуулах (mapping to external data);

3.7.1.3. Активын алдагдлын статистик загварчлал (statistical loss model).

3.7.2. Банк нь энэ журмын 3.7.1-д заасан аргачлалаар багцалсан активт эрсдэлийн сан байгуулан дотооддоо ашиглаж болох бөгөөд уг аргачлал нь энэ журамд тавигдах доод шаардлага, зээлийн эрсдэлийн параметрийг тооцох, баталгаажуулахад мөрдөх олон улсын стандарт болон Монголбанкнаас тогтоосон заавар зөвлөмжид нийцүүлсэн байна.

3.7.3. Монголбанкнаас энэ журмын 3.7.1-д заасан банкны эрсдэлийн сан тооцох аргачлал нь дараах шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулна:

3.7.3.1. Активаас үүссэн алдагдлын тоон мэдээг төвлөрүүлэх, боловсруулах, цуглуулах чадамж бүхий удирдлагын мэдээллийн системтэй байх;

3.7.3.2. Тооцоолол хийхээр сонгосон түүвэр мэдээлэл нь эрсдэлийн үнэлгээ хийх багцалсан активтай бүтэц, нөхцөл, эрсдэлийн түвшин болон бусад шинж чанараар адилхан эсвэл харьцуулах боломжтой байх;

3.7.3.3. Үнэлгээнд ашиглаж байгаа тоо, мэдээлэлд харгалзах актив, зээл олгоход тавигдах шаардлага, стандарт нь банкнаас үнэлж байгаа багцалсан активтай ижил эсвэл харьцуулах боломжтой байх;

3.7.3.4. Сонгосон түүвэр мэдээлэл нь банкнаас эрсдэлийн сан тооцохоор багцалсан активын чанарыг оновчтой илэрхийлж, одоогийн болон ойрын ирээдүйн эдийн засаг болон зах зээлийн хүчин зүйлсийг илэрхийлэх боломжтой, нийцтэй байх;

3.7.3.5. Тооцоололд сонгосон түүвэр нь активын тоо ширхэг, түүврийн

хамрах хугацааны хувьд банкны зүгээс багцалсан активт харгалзах эрсдэлийн сан болон алдагдлын түвшинг статистик аргачлалаар зохистой итгэх түвшний хувьд оновчтой, үнэн зөв үнэлэх боломжтой байх;

3.7.3.6. Аргачлалыг энэ журмын 2.8-д заасан ерөнхий шаардлагатай нийцүүлсэн байх.

3.7.4. Активын алдагдлыг тооцоолоход ашиглаж байгаа аргачлал болон параметруудийн утгыг активын талаарх шинэ мэдээлэл буюу энэ журмын Хавсралт 2-6-д заасан активын чанарын үнэлгээний мэдээлэлд үндэслэн холбогдох тохируулгыг тухай бүрт тусгах боломжтой байхаар боловсруулна.

3.7.5. Энэ журмын 3.7.4-д дурдсан тохируулгыг хамгийн багадаа жилд нэгээс доошгүй удаа хийнэ.

3.7.6. Энэ журмын 3.7.1-д заасан аргачлалуудын алиныг сонгохоос үл хамаарч, банкны активын эрсдэлийн параметруудийг үнэлэх түүврийн түүхэн мэдээлэл нь хамгийн багадаа 5 жилийн хугацааг хамарсан байна. Таван жилээс дээш ажиглалтын утга олох боломжтой бол илүү хугацааны түүврийг ашиглана.

## **ДӨРӨВ. ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА**

4.1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь активын ангиллын үнэлгээ, активаас хүлээж болзошгүй алдагдал, тусгай болон ерөнхий эрсдэлийн сангийн хэмжээг үнэн зөвөөр тооцож, Монголбанкинд энэ журмын 3.6.1-г заасан хугацаанд тайлагнаж байх үүрэгтэй.

4.2. Монголбанк тухайн банкинд энэ журмын 3.1.1-д заасан ерөнхий болон тусгай эрсдэлийн сангийн хувь хэмжээг банкны эрсдэлийн төлөв, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын түвшинд суурилан өөрчлөн тогтоож болно.

4.3. Монголбанкнаас шаардлагатай гэж үзвэл багцалсан активт байгуулах тусгай эрсдэлийн сангийн хэмжээг тодорхойлох активын эрсдэлийн параметруудийн (PD, LGD, LIP болон бусад) доод болон дээд хязгаарыг тухайн нэг банк эсвэл нийт банкны салбарын хэмжээнд тогтоон, мөрдүүлж болно.

4.4. Энэ журамд заасан активт ангилал хийх, эрсдэлийн сан байгуулахтай холбоотой зохицуулалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тухайн активын төрөл, хэмжээ болон активын гэрээнд тусгасан нөхцөлийн хувьд өөрчлөн тогтоож болно.

4.5. Банкнаас олгосон тухайн актив, багцалсан актив эсвэл нэг төсөл санхүүжүүлэх зорилгоор олгосон активууд болон нэг төлбөр хариуцагчтай холбоотой нийт активуудын чанар ойрын хугацаанд муудаж, улмаар төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн зохистой харьцаанд сөргөөр нөлөөлөх дүгнэлт гарсан тохиолдолд банкны зүгээс яаралтай Монголбанкинд мэдэгдэнэ.

4.6. Банкны дотоод аудит хариуцсан нэгж нь банк активын эрсдэлийг хэрхэн оновчтой үнэлж, активын ангиллыг үнэн бодитой хийж байгаа болон холбогдох эрсдэлийн санг хэрхэн байгуулж, зарцуулж байгаад хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж байх үүрэгтэй. Банкны дотоод аудитын

нэгжийн үйл ажиллагааны хамрах хүрээнд энэ журам болон удирдлагын үйл ажиллагааны зорилгоор боловсруулсан банкны дотоод аргачлал тусгасан байна.

- 4.7. Монголбанк банк активын эрсдэлийг үнэлж, дүгнэн активыг ангилж, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь зохистой эсэх, ангиллыг үнэн зөв хийж байгаа эсэх, эрсдэлийн санг бүрэн гүйцэд байгуулж, зохистой зарцуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж, зайнаас хяналт тавина. Уг хяналт шалгалтын үйл ажиллагааны хамрах хүрээнд энэ журам болон удирдлагын үйл ажиллагааны зорилгоор боловсруулсан банкны дотоод аргачлал тусгасан байна.
- 4.8. Банк нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд ирүүлэх активын төлбөр хариуцагчийн талаарх мэдээлэлд тухайн активын ангиллыг сар бүр эсвэл ангилалд өөрчлөлт орсон тухай бүр үнэн зөв тусгана.
- 4.9. Монголбанкнаас хийх газар дээрх болон зайны хяналт шалгалтаар банкны үйл ажиллагааг шалгах явцад Монголбанкны хянан шалгагч тухайн банк аливаа хөрөнгийг буруу ангилсан, эсвэл хөрөнгийн эрсдэлийн санг дутуу байгуулсан, сангаас үндэслэлгүйгээр хорогдуулсан гэж үзэж, үндэслэлийг тодорхойлсон тохиолдолд тухайн активын ангиллыг өөрчилж, эрсдэлийн санг нэмж байгуулахыг хууль тогтоомжийн дагуу шаардана.
- 4.10. Монголбанк банкны үйл ажиллагааг шалгах явцад хөрөнгийг энэ журмын дагуу ангилаагүй, холбогдох эрсдэлийн санг тогтоосон хувь хэмжээгээр байгуулаагүй, буруу зарцуулсан нөхцөлд банк, түүний удирдлага, холбогдох ажилтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХАВСРАЛТ IХАВСРАЛТ 1.а.

**АКТИВЫН ХУГАЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР  
ДҮГНЭЖ АНГИЛАХ ХҮСНЭГТ**

Ангилал	ӨР ТӨЛБӨР ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНААС ХЭТЭРСЭН ХОНОГООР				
	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Зээл*	$\leq 15^\dagger; \leq 30^\dagger$	$\leq 90$	91-180	181-360	$\geq 361$
Хувьсах нөхцөлтэй актив**	$\leq 15$	15-90	91-180	181-270	$\geq 271$
Үнэт цаас***	-	$\leq 30$	31-60	61-90	$\geq 91$
Авлага болон бусад актив	$\leq 30$	31-60	61-90	91-120	$\geq 121$
†- Журмын 2.1.4-т заасны дагуу *Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөр **Хувьсах нөхцөлтэй актив, хүүгийн эргэн төлөлтөөр ***Үнэт цаас, хүүгийн эргэн төлөлтөөр					

ХАВСРАЛТ 1.б.

**ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨД БАГТАХ ҮЛ ХӨДЛӨХ,  
ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ АНГИЛЖ, ЭРСДЭЛИЙН САН  
БАЙГУУЛАХ ХҮСНЭГТ**

Ангилал	ӨМЧЛӨЛД АВСНААС ХОЙШ БОРЛОГДООГҮЙ ХОНОГООР				
	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Үл хөдлөх хөрөнгө	$\leq 60$	61-100	101-160	161-220	$\geq 221$
Хөдлөх хөрөнгө	$\leq 30$	31-60	61-90	91-120	$\geq 121$

ХАВСРАЛТ 2

**АКТИВЫГ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТЭЭР  
АНГИЛАХ ЕРӨНХИЙ ХҮСНЭГТ**

Ангилал <sup>1</sup>	Чанарын үнэлгээний бүрэлдэхүүн үзүүлэлт			Банкнаас активыг холбогдох чанарын ангилд тогтоох болсон үндэслэл <sup>5</sup>	Монголбанкны хэрэгцээнд <sup>6</sup>
	Төлбөр хариуцагчийн ерөнхий нөхцөл байдал <sup>2</sup>	Эдийн засгийн болон төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдал <sup>3</sup>	Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл <sup>4</sup>		
<i>Хэвийн</i>	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээний хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулахад санхүүгийн болон бусад аливаа хүндрэл, эрсдэл үүсэхгүй буюу эрсдэл багатай актив.	Төлбөр хариуцагчийн үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбарын нөхцөл байдал болон төлбөр хариуцагчийн санхүүгийн байдал сайн.	Төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичиг хангалттай байгаа.		
<i>Анхаарал хандуулах</i>	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээний дагуу хуваарьт заасан хугацаандаа төлж байгаа боловч ирээдүйд хуваарьт төлбөрийг төлж барагдуулахад хүндрэл үүсч болзошгүй шинж тэмдэг илэрч байгаа актив.	Доорхын аль нэг нөхцөл байдал үүссэн: а) Төлбөр хариуцагчийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын эдийн засгийн байдал хямрал, хүндрэлтэй байгаа б) Төлбөр хариуцагчийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал богино хугацаанд доройтсон боловч цаашид дунд болон урт хугацаанд сайжрах төлөвтэй.	Төлбөр хариуцагчийн зарим мэдээлэл, баримт бичиг дутмаг боловч тухайн мэдээлэл нь төлбөр хариуцагчийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэхэд материаллаг түвшинд сөрөг нөлөө үзүүлэхгүй.		

	<p>Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлж барагдуулахад эргэлзээтэй болсон актив. Эсвэл өмнө нь активын чанарыг муутгаж байсан түүхтэй төлбөр хариуцагчийн актив. Эдгээр нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд барьцаа хөрөнгө бий эсэх, түүний чанар, хамрах хүрээ зэрэг нь зээлийг энэ ангилалд ангилахгүй байх үндэслэл болохгүй.</p>	<p>Төлбөр хариуцагчийн эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц хүндрэл үүсч, санхүүгийн гол үзүүлэлтүүд муудсан ба цаашид муудах хандлагатай. Үүнд:</p> <p>а) Төлбөрийн чадвар болон бэлэн мөнгөний орлого буурсан эсвэл сөрөг утгатай болсон</p> <p>б) Өрийн хэмжээ ихэссэн буюу эздийн өмчийн хөрөнгөд эзлэх хувь өссөн</p> <p>в) Барьцаа хөрөнгө хангалтгүй эсвэл барьцаа хөрөнгийн борлогдох боломж нь төлбөр хариуцагчийн салбарын үйл ажиллагаатай нягт холбоотой, эсвэл хөрвөх чадвар багатайн улмаас активыг төлүүлэхээр худалдан борлуулахад бэрхшээлтэй байх магадлалтай.</p> <p>г) Ашигт ажиллагаа буурсан эсвэл сөрөг утгатай болсон</p>	<p>Төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичиг хангалтгүй, эсвэл эдгээрийн үнэн зөв эсэхийг баталгаажуулах боломжгүй.</p>	
<p>Эргэлзээтэй</p>	<p>Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах боломжгүй болсон актив.</p>	<p>Төлбөр хариуцагчийн эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал хэвийн бус ангилалд ангилагдсан үеэс илт доройтсон.</p>	<p>Төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл хангалтгүй буюу байхгүй, эсвэл мэдээлэл нь үнэн зөв эсэхийг баталгаажуулах боломжгүй.</p>	

Муу	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийн маш бага хувийг төлж барагдуулахаар байгаа актив.	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийг хийж чадахааргүй болтлоо санхүүгийн байдал нь доройтсон.	Төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл байхгүй, эсвэл байгаа мэдээлэл нь хуурамч.	
-----	---	--	---	--

**ТАЙЛБАР:** 1-Үнэлж байгаа активт олгосон чанарын ангилал

- 2-Хавсралт 5, Хавсралт 6-ын 1-3 дахь бүрэлдэхүүн хэсгүүд (хувийн хэргийн бүрдэл, санхүүгийн үзүүлэлт болон бусад) болон активын эргэн төлөгдөх хуваарийн мэдээлэлд үндэслэн нийгэд нь дүгнэх
- 3-Хавсралт 5, Хавсралт 6-ын 2 дахь (санхүүгийн үзүүлэлт) бүрэлдэхүүн хэсгийн үр дүнд үндэслэн дүгнэх
- 4-Хавсралт 5, Хавсралт 6-ын 1 дэх (хувийн хэргийн бүрдэл) хэсгийн үр дүнд үндэслэн дүгнэх
- 5-Үнэлж байгаа активыг холбогдох чанарын ангиллаар тодорхойлсон үндэслэл, тайлбарыг банкны зүгээс тодорхой, үндэслэлтэйгээр тусгах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргахад ашигласан бүх мэдээлэл, тоон мэдээ, тайлан, бусад судалгааг уг хүснэгтэд хавсаргасан байх.

6- Банкнаас гаргасан тайлбарыг хүлээн зөвшөөрөх эсэх талаарх тайлбар, дүгнэлтийг Монголбанкнаас тусгах. Монголбанкны санал давамгайлна.

**Активын чанарын ангилал тогтоох үндсэн заавар:** Дээрх хүснэгтэд тусгасан чанарын ангилал тогтоох 3 бүрэлдэхүүн хэсгээс давамгайлж байгаа үнэлгээний дагуу активыг харгалзах ангилалд бүртгэнэ. Харин онцгой тохиолдолд бусад бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээ эцсийн ангилал тогтооход хэрхэн материаллаг түвшинд нөлөөлж байгаа талаар тодорхой үндэслэл, тайлбарыг тусгана. Холбогдох баримт, материал, нотолгоог энэхүү үнэлгээний хуудаст хавсаргасан байна.



ХАВСРАЛТ 3.а.

**АКТИВЫН АНГИЛАЛ, ЭРСДЭЛИЙН САН  
БАЙГУУЛАХ ХУВЬ, ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ ХҮСНЭГТ**

Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хэвийн	Хэвийн 0.5%	Анхаарал хандуулах 1%	Хэвийн бус 15%	Эргэлзээтэй 35%	Муу 75%
Анхаарал хандуулах	Анхаарал хандуулах 1%	Анхаарал хандуулах 5%	Хэвийн бус 25%	Эргэлзээтэй 35%	Муу 75%
Хэвийн бус	Хэвийн бус 5%	Хэвийн бус 15%	Хэвийн бус 25%	Эргэлзээтэй 50%	Муу 100%
Эргэлзээтэй	Эргэлзээтэй 15%	Эргэлзээтэй 25%	Эргэлзээтэй 35%	Эргэлзээтэй 50%	Муу 100%
Муу	Муу 50%	Муу 50%	Муу 75%	Муу 100%	Муу 100%

Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хэвийн	Хэвийн 0.5%	Анхаарал хандуулах 1%	Хэвийн бус 15%	Эргэлзээтэй 35%	Муу 75%
Анхаарал хандуулах	Анхаарал хандуулах 1%	Анхаарал хандуулах 5%	Хэвийн бус 25%	Эргэлзээтэй 35%	Муу 75%
Хэвийн бус	Хэвийн бус 5%	Хэвийн бус 15%	Хэвийн бус 25%	Эргэлзээтэй 50%	Муу 100%
Эргэлзээтэй	Эргэлзээтэй 15%	Эргэлзээтэй 25%	Эргэлзээтэй 35%	Эргэлзээтэй 50%	Муу 100%
Муу	Муу 50%	Муу 50%	Муу 75%	Муу 100%	Муу 100%

Тайлбар: Активын ангиллыг хугацааны болон чанарын хүчин зүйлээр тооцсон үнэлгээний аль доогуур ангиллаар тогтоож, дээрх матрицад харгалзах эрсдэлийн сангаар байгуулна. Тухайлбал: Актив нь хугацааны үзүүлэлтээр “Анхаарал хандуулах”, чанарын үзүүлэлтээр “Эргэлзээтэй” ангилалаар үнэлсэн бол активыг “Эргэлзээтэй” ангилалд бүртгэж, эрсдэлийн санг 25 хувиар байгуулна.

**ХАВСРАЛТ 3.б.**

**ТЭНЦЛИЙН ГАДУУРХ АКТИВ, ХҮЛЭЭЖ БОЛЗОШГҮЙ ҮҮРГИЙН АНГИЛАЛ, ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХУВЬ**

Чанарын ангилал Гэрээгээр хэрэгжих боломжтой хугацаа	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
1 жилийн дотор	0%	5%	25%	50%	100%
1 жилээс дээш хугацааны дараа	0%	1%	15%	35%	75%

**ХАВСРАЛТ 3.в.**

САНХҮҮГИЙН БУС ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГИЙГ АНГИЛЖ, ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАХ ХҮСНЭГТ Ангилал	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Эрсдэлийн сангийн доод хувь	0%	25%	50%	75%	100%

ХАВСРАЛТ 4

ХАВСРАЛТ 4.а.

(тайлан хүлээж авах загвар)

№	Активын төрөл	Үлдэгдэл	Баталгаа, барьцаа хөрөнгийн хасагдуулга хийх хэмжээ						Нийт	Цвэр үлдэгдэл
			Хадгаламж (100%)	ТВҮЦ (100%)	ОУХБ (ОУВС, Дэлхийн банк, гм) (100%)	МУ ЗГ-ын баталгаа (...%)	Гадаад улсын ЗГ-ын баталгаа (...%)	Тэвшлийн гадуурх Үүртгт хамаарах эх үүсвэр		
(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)	(9)=(2)+...+(4)+(5)+(6)+(7)+(8)	(10)=(1)-(9)	
1	Зээл* (нийт)	-	-	-	-	-	-	-	-	
	Хэвийн									
	Анхарал хандуулах									
	<i>Чанаргүй</i>									
	Хэвийн бус									
	Эргэлзээтэй									
	Муу									
2	Баталгаа, баглан даалт (нийт)	-	-	-	-	-	-	-	-	
	Тендерийн									
	Гүйцэтгэлийн									
	Урьчилгаа төлбөрийг буцаах									
	Векселийн									
3	Аккредитив	-	-	-	-	-	-	-	-	
	Гадаад худалдааны аккредитив									
	Сэндбай									
4	Зээлийн шугам									
5	Авлага болон бусад актив									
6	НИЙТ	-	-	-	-	-	-	-	-	

Тайлбар: \* - Зээлээр багцалсан актив, хувьсах нөхцөлтэй актив болон хамааралтай активуудыг багтаана. \*\* - Энэ журмын хавсралт 4-и.-д заасан хувиар тохируулна.

(1) –Активын хасагдуулгын өмнөх дүн, (2) -Журмын 3.2.1.1-д заасан тохируулга, (3) -Журмын 3.2.1.3-д заасан тохируулга, (4) -Журмын 3.2.1.4-д заасан тохируулга, (5), (6) -Журмын 3.2.1.5-д заасан тохируулга, (7) -Журмын 3.2.1.2-д заасан тохируулга, (8) -Журмын 3.2.1.8-д заасан тохируулга.

ХАВСРАЛТ 4.б.

(тайлан хүлээж авах загвар)

**АКТИВЫН ХҮЛЭГДЭЛ, ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖИЙН НЭГДСЭН ТАЙЛАН**

Дд	АКТИВЫН ТӨРӨЛ	Зээл	Үнэт цаас	Өмчлөх бусад хөрөнгө	Авлага болон бусад актив	Нийт тэнцлийн эрсдэлтэй актив	Тэнцлийн гадуурх үрэг	Нийт эрсдэлтэй актив	/мянган төгрөгөөр/
<b>1</b>	<b>Үлдэгдэл* (1.1+1.2)</b>	-	-	-	-	-	-	-	-
1.1.	Үнэ цэнийн бууралт**-аар тооцох								
1.2.	Актив ангиллын журмаар тооцох								
<b>2</b>	<b>Тусгай эрсдэлийн сан (2.1+2.2)</b>	-	-	-	-	-	-	-	-
2.1.	Үнэ цэнийн бууралт**-аар тооцсон								
2.2.	Актив ангиллын журмаар тооцсон <b>(2.2.1+2.2.1+2.2.3)</b>								
2.2.1	Хэвийн:								
2.2.2	Анхаарал хандуулах								
2.2.3	Чанаргүй зээл (а+б+в) а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу								
<b>3</b>	<b>Ерөнхий эрсдэлийн сан (а+б+в)</b>	-	-	-	-	-	-	-	-
	Активийн хувь***	=(1)*(3а)			=(4)*(3б)		=(6)*(3в)		
	а/ Зээл	0%							
	б/ Тэнцлийн гадуурх үүрэг	0%							
	в/ Бусад актив	0%							
<b>4</b>	<b>НИЙТ ЭРСДЭЛИЙН САН [(2)+(3)]</b>	-	-	-	-	-	-	-	-
<b>5</b>	<b>БАНКНААС БАЙГУУЛСАН САН</b>								
<b>6</b>	Илүү (+) / Дулуу (-) [(4)-(5)]	-	-	-	-	-	-	-	-

Тайлбар: \* - Барьцаа хөрөнгийн хасагдуулгаар цэвэршүүлсэн дүн

\*\* - Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу тооцсон үнэ цэнийн бууралтын дүн

\*\*\* - Журмын 3.3.3-д заасны дагуу тогтоосон хувь хэмжээ.

ХАВСРАЛТ 4.В.

(тайлан хүлээж авах загвар)

**АКТИВЫН ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Зээл		/мянган төгрөгөөр/						
Дд	Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	<b>НИЙТ</b>	-	-	-	-	-	-	-

Хувьсах нөхцөлтэй актив		/мянган төгрөгөөр/						
Дд	Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	<b>НИЙТ</b>	-	-	-	-	-	-	-

Тайлбар: \* - Журмын 2.8.3, 2.8.4-д заасан тохируулга.

## АКТИВЫН ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Авлага болон бусад актив		/мянган төгрөгөөр/						
Дд	<del>Хугацааны Цанарын</del>	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	<b>НИЙТ</b>	-	-	-	-	-	-	-

Үнэт цаас		/мянган төгрөгөөр/						
Дд	<del>Хугацааны Цанарын</del>	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	<b>Үнэ цэнийн бууралтаар тооцсон**</b>							-
8	<b>НИЙТ</b>	-	-	-	-	-	-	-

Тайлбар: \* - Журмын 2.8.3, 2.8.4-д заасан тохируулга

\*\* - Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан үнэ цэнийн бууралтын дүн.

**ХАВСРАЛТ 4.в. - Үргэлжлэл**

(тайлан хүлээж авах загвар)

**АКТИВЫН ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Өмчлөх бусад хөрөнгө - Үл хөдлөх, Хөдлөх хөрөнгө		/мянган төгрөгөөр/						
Дд	Ангилал Эрсдэлийн сангийн доод хувь	Үлдэгдэл	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
			0%	25%	50%	75%	100%	
1	Үл хөдлөх хөрөнгийн үлдэгдэл	-						
2	Харгалзах эрсдэлийн сан		-	-	-	-	-	-
	Хөдлөх хөрөнгийн үлдэгдэл	-						
	Харгалзах эрсдэлийн сан		-	-	-	-	-	-
3	<b>НИЙТ</b>		-	-	-	-	-	-
4	Худалдан борлуулах зориулалттай Үл хөдлөх хөрөнгө*							
5	<b>Үнэ цэнийн бууралтаар тооцсон**</b>							

Өмчлөх бусад хөрөнгө - Санхүүгийн хөрөнгө		/мянган төгрөгөөр/						
Дд	Цанарын Хугацааны	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							
2	Анхаарал хандуулах							
3	Хэвийн бус							
4	Эргэлзээтэй							
5	Муу							
6	<b>Үнэ цэнийн бууралтаар тооцсон**</b>							
8	<b>НИЙТ</b>		-	-	-	-	-	-

Тайлбар: \* - Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан хөрөнгө, \*\* - Худалдан борлуулах зориулалттай Үл хөдлөх хөрөнгийн Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу тооцсон үнэ цэнийн бууралт.

ХАВСРАЛТ 4.в. - Үргэлжлэл

(тайлан хүлээж авах загвар)

АКТИВЫН ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тэнцлийн гадуурх үүрэг		/мянган төгрөг/						
Дд	Чанарын ангилал Гэрээний хэргүүдийн хугацаа	Зээлтэй адилтан тооцолдун	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Мүү	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	1 жилийн доторх	-	0%	5%	25%	50%	100%	
2	Үлдэгдэл	-	-	-	-	-	-	
3	Эрсдэлийн сан	-	0%	1%	15%	35%	75%	
4	1 жилээс дээшх	-	-	-	-	-	-	
5	Үлдэгдэл	-	-	-	-	-	-	
6	Эрсдэлийн сан	-	-	-	-	-	-	
7	<b>НИЙТ</b>							<b>0</b>

Багцалсан актив		/мянган төгрөгөөр/							
Дд	Багцалсан активын төрөл	Нийт багцын дэд төрлийн тоо	Нийт багцын тоо	Нийт гишүүн активын тоо	Сан тооцох үлдэгдэл			Тусгай эрсдэлийн сан	
					Нийт багцын дэд төрлийн тоо	Нийт багцын тоо	Нийт гишүүн активын тоо	Үнэ цэнэ буураагүй хэсэг	Үнэ цэнэ буураагүй хэсэг
1	Зээл								
2	Зээлээс бусад хувьсах нохцолтэй актив								
3	Авлага болон бусад актив								
4	<b>НИЙТ</b>								
5									



## ХАВСРАЛТ 4.г.

(тайлан хүлээж авах загвар)

## ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГИЙН ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАН

Дд	Өмчлөх бусад хөрөнгө	Өмнөх сарын үзлэгдэл (1)	Үүнээс дараах ангилалд шилжүүлсэн:				Шилжүүлсэн данснаас Буцаалсан*** (7)	Шинээр нэмэгдсэн (8)	Тайлант сарын үзлэгдэл =(1)-(2)+(3)+...+(6)-(7)+(8) (9)=
			Үндсэн хөрөнгө (2)	ХОУХХ* (3)	БЗХ* (4)	ББҮЦ** (5)			
1	Санхүүгийн бус хөрөнгө (1.а+1.б)								
	а/ Үл хөдлөх хөрөнгө:								
	а.1./ Орон сууцны зориулалттай†								
	а.2./ Бусад үл хөдлөх хөрөнгө								
	б/ Хөдлөх хөрөнгө								
2	Санхүүгийн хөрөнгө (2.а+2.б)								
	а/ Үнэг цаас								
	б/ Бусад								
3	НИЙТ ҮЛДЭГДЭЛ (1+2)								

## Тайлбар:

†- “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын 1.2.1-д заасан зээлийн барьцаанд байгаа орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө

\*-Хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглах үл хөдлөх хөрөнгө

\*\*-Борлуулах зориулалттай хөрөнгө

\*\*\*-Борлуулахад бэлэн үнэт цаас

\*\*\*\*- Журмын 2.5.12-д заасан тохируулга

ХАВСРАЛТ 4.д.

(тайлан хүлээж авах загвар)

Бүтэц өөрчлөгдсөн актив		/мянган төгрөг/					
№	Активын төрөл	Өмнөх сарын үлдэгдэл	Эргэн төлөгдсөн	Шинээр БӨ* ангилалд шилжсэн	Хэвийн ангилалд хэвээр байгаа эсвэл шилжсэн**	Бусад тохируулга***	Тайлант сарын үлдэгдэл
		(1)	(2)	(3)	(4)	(5)	(7) = (1)-(2)+(3)-(4)+(5)
1	Зээл (Нийт)						
	Хэвийн:						
	Анхаарал хандуулах						
	Чанаргүй зээл (а+б+в)						
	а/ Хэвийн бус						
	б/ Эргэлзээтэй						
	в/ Муу						
2	Үнэт цаас						
3	Авлага болон бусад актив						
4	Бусад						
5	НИЙТ						

\*БӨ – Бүтэц өөрчлөгдсөн

ХАВСРАЛТ 4.е.

(тайлан хүлээж авах загвар)

ҮНЭТ ЦААСНЫ ҮЛДЭГДЭЛ, ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАЛТЫН ЗАДАРГААНЫ ТАЙЛАН

Үнэт цаасны үлдэгдлийн задаргаа

Дд	Үнэт цаасны төрөл	АААБҮЦ*		Хугацааны эцэс хүртэлх	Борлуулахад бэлэн	Зээл, Авлага	Охин, Хараат компани, Хамтын өмчлөлд оруулсан хөрөнгө оруулалт	Нийт
		Арилжааны	Бодит үнэ цэнээрх					
1	Үлдэгдэл (1.1+1.2)							
1.1.	Үнэ цэнийн бууралт**-аар тооцсон							
1.2.	Актив ангиллын журмаар тооцсон							
2	Тусгай эрсдэлийн сан (2.1+2.2)							
2.1.	Үнэ цэнийн бууралт**-аар тооцсон							
2.2.	Актив ангиллын журмаар тооцсон (2.2.1+2.2.2+2.2.3)							
2.2.1	Хэвийн:							
2.2.2	Анхаарал хандуулах							
2.2.3	Чанаргүй зээл (а+б+в)							
	а/ Хэвийн бус							
	б/ Эргэлзээгүй							
	в/ Муу							
3	Банкнаас байгуулсан сан							
4	Илүү (+) / Дутуу (-) [(2)-(3)]							

Тайлбар: \* - Арилжааны буюу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас; \*\* - Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу тооцсон үнэ цэнийн бууралтын дүн.



ХАВСРАЛТ 4.3.

(тайлан хүлээж авах загвар)

БАГЦАЛСАН АКТИВЫН ПАРАМЕТР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

Дд	Багцын төрөл	Параметрийн тооцоо*			Хамгийн их - Хамгийн бага**				Тооцсон аргачлал***	Хамрах хугацаа		Нийт ажиглалтын тоо (observations)	Мэдээллийн давтамж**** (сар, улирал, хагас жил, жилээр гэх мэт)
		PD	LGD	LIP	PD	LGD	LIP	Эхлэх огноо		Дуусах огноо			
1	Орон сууцны...												
2	Жижиглэн...												
3	Төлбөр картын...												
4	Бичил санхүү...												
5	Хэрэглээний ...												
...													
	Гэх мэт...												

Тайлбар: \*-тэгээс цаашхи гурван орны нарийвчлалтай

\*\*-Параметрийг тооцох хугацааны туршид тооцож байсан хамгийн их болон хамгийн бага утга

\*\*\* - Журмын 3.7.1-д заасан аргачлалаас сонгох (ILM-internal loss experience; MED - Mapping to external data; SLM - Statistical Loss Model)

\*\*\*\* - Жилийн давтамжтай бол 1, хагас жилийн -2, улирлын -3, сарын – 4-ийг тус тус бичнэ.

ХАВСРАЛТ 4.и.

(тайлан хүлээж авах загвар)

ЗАСГИЙН ГАЗРААС ОЛГОСОН БАТАЛГАА, БАТЛАН ДААЛТЫН ХАСАГДУУЛГЫГ ТООЦОХ ХҮСНЭГТ

Ург хугацааны

ЗЭРЭГЛЭЛ/ РЕЙТИНГ*	Стандарт энд		AAA / AA-	A+ / A-	BBB+ / BBB-	BB+ / B-	ССС+- түүнээс бага	РЕЙТИНГҮЙ
	Пурс	Фич						
ХЭТИЙН ХАНДЛАГА*	Муудиз		Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	Саа1- түүнээс бага	
ЭРЭГ		100%	100%	100%	90%	80%	20%	80%
ТОГТВОРТОЙ		100%	100%	100%	90%	70%	20%	
СӨРӨГ		90%	90%	90%	80%	60%	20%	

Тайлбар:

\*- Засгийн газрын рейтингийг 2 болон түүнээс дээш байгууллагаас тогтоосон бол аль доогуур рейтинг болон хэтийн хандлагыг ашиглана.

Богино хугацааны

ЗЭРЭГЛЭЛ/ РЕЙТИНГ*	Стандарт энд		A-1+	A-1	A-2/A-3	B	C-түүнээс доош	РЕЙТИНГҮЙ
	Пурс	Фич						
Хасагдуулгын хувь	Муудиз		P-1	P-2	P-3	Prime-түүнээс бага		
		100%	100%	100%	80%	40%	20%	80%

Тайлбар:

\*- Засгийн газрын рейтингийг 2 болон түүнээс дээш байгууллагаас тогтоосон бол аль доогуур рейтингийг ашиглана.

ХАВСРАЛТ 5

**ИРГЭНД ОЛГОСОН АКТИВЫГ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТЭЭР АНГИЛАХАД ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ЖАГСААЛТ**

Дд	Үнэлгээний хүчин зүйлс	Үнэлгээ	Хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлтийн тайлбар*	Материалаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**
1.	Активын хувийн хэргийн бүрдэл*	Тийм/үгүй		
1.1.	Банкны мөрдөж байгаа дотоод дүрэм, журмын дагуу шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр бий эсэх, төлбөр хариуцагчийн талаарх банкны дүгнэлт			
1.2.	Актив олгохыг хүссэн өргөдөл			
1.3.	Активын гэрээ болон холбогдох бусад гэрээ, гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт			
1.4.	Төлбөр хариуцагчийн ажлын газрын тодорхойлолт (ажилласан жил, цалингийн хэмжээ)			
1.5.	Цалингаас өөр орлоготой бол бусад орлогын эх үүсвэр, ноглох баримт			
1.6.	Хадгаламж болон бусад хуримтлалыг 2-оос дээш жилийн хугацаагаар тогтвортой хуримтлуулж байгаа талаар ноглох баримт			
1.7.	Шаардлагай тохиолдолд өрхийн орлогын бүрдлийн эх үүсвэр, ноглох баримт			
1.8.	Барьцаа хөрөнгө			
	1.8.1. Тодорхойлолт <sup>4</sup>			
	1.8.2. Үнэлгээний баримт бичиг			
	1.8.3. Үл хөдлөх хөрөнгө бол улсын бүртгэлийн гэрчилгээ			
	1.8.4. Шалгасан баримт			

1.8.5.	Гадны харааг бус үнэлгээ								
1.9.	Барьцааны гэрээ, баглан даалттай бол баглан даалтын гэрээ								
2.	Төлбөр харьцагчийн санхүүгийн үзүүлэлтүүд	Үзүүлэлт/харьцуулалт***			Шалгуур үзүүлэлт бүрт тайлбар оруулах	Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**			
		Утга <sup>1</sup>	Δ% <sup>2</sup>	Бүлгийн дундаж <sup>3</sup>					
2.1.	Төлбөр харьцагчийн өр, орлогын харьцаа								
2.2.	Төлбөр харьцагчийн өр, орлогын харьцааны өөрчлөлт, сүүлийн 3 сарын хандлага								
2.3.	Өрхийн өр, орлогын харьцаа								
2.4.	Өрхийн өр, орлогын харьцааны өөрчлөлт, сүүлийн 3 сарын хандлага								
2.5.	Зээл/Үнэлгээний харьцаа (LTV) - Ипотек болон бусад хөрөнгө барьцаалсан зээл								
3.	Бусад	Тийм/үгүй				Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**			
3.1.	Барьцаа болон баглан даалт								
3.1.1.	Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хангалттай эсэх								
3.1.2.	Барьцаа хөрөнгийн үнэлгээний өөрчлөлт								
3.1.2.	Барьцаа хөрөнгийг худалдан борлуулж, активыг төлүүлэх эрх нь банкинд бүрэн шилжиж ирсэн эсэх								
3.1.3.	Барьцаа хөрөнгийг худалдан борлуулах салбарын нөхцөл байдал								
3.1.3.	Гуравдагч этгэдээс гаргасан баглан даалт								



3.1.4.	Актив нь баглан даалттай бол баглан даагчийн төлбөрийн чадварын байдал				
3.2.	Зээлийн мэдээллийн сангаас авсан мэдээлэл				
3.2.1.	Төлбөр хариуцагчийн активын эргэн төлөлтийн түүх				
3.2.2.	Хугацаа хэгэрсэн ямарваа нэгэн активын болон бусад хэлбэрийн өртэй эсэх				
3.2.3.	Тухайн сард төлбөр хариуцагчийн аливаа нэг активын ангилал буурсан эсэх				
3.3.	Бусад мэдээлэл				
3.3.1.	Төлбөр хариуцагчийн ажил эрхлэлтийн байдал /тогтвор суурьшилтай ажилласан, хувиараа ажил эрхэлсэн/				
3.3.2.	Бусад төр, хууль хяналтын эрх бүхий болон төрийн бус байгууллагаас авсан лавлагаанд төлбөр хариуцагчийн талаар сөрөг мэдээлэл агуулаагүй				
3.3.3.	Банкнаас төлбөр хариуцагчийн санхүүгийн байдлыг аливаа хүндрэлгүйгээр үнэлж, дүгнэж байгаа				
3.3.4.	Эдийн засгийн нөхцөл байдал, ажилгүйдлийн түвшин, төлбөр хариуцагчийн ажил эрхэлж байгаа салбарын нөхцөл байдал төлбөр хариуцагчийн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлж байгаа, ирээдүйд нөлөөлөх хандлага эерэг				
3.3.5.	Төлбөр хариуцагчтай холбоотой үүсэх активын эрсдэлийг бууруулах аливаа даатгалд хамрагдсан				
3.3.6.	Төлбөр хариуцагчийн талаар банкинд төвлөрүүлсэн дотоод мэдээлэлд зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэл байхгүй				

*Тайлбар:*

\*- Үнэлгээний хүснэгтээс зөвхөн хангалтгүй үнэлгээ авсан үзүүлэлтэд тайлбар бичих

\*\* - Чанарын ангилалд мэдэгдэхүйц өөрчлөлт орохоор байгаа талаар үндэслэл, тайлбарыг бичиж, шаардлагатай баримт материалыг хавсаргана.

\*\*\*-Холбогдох төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтийг 1-2 жил болон мэдээллийн хүрэлцээтэй байдлаас шалтгаалан түүнээс дээш жилийн хугацаатайгаар, сар, улирал, жилийн давтамжтайгаар нэгтгэн боловсруулж энэхүү хүснэгтэд хавсаргах бөгөөд үзүүлэлтийг тогтмол шинэчилнэ.

1-Санхүүгийн үзүүлэлтийн тайлант хугацааны утгыг тусгана.

2-Санхүүгийн үзүүлэлтийн өмнөх хугацааны хандлагыг тусгах бөгөөд сүүлийн үеийн байдлаар Өссөн /Ө эсвэл↑/, Буурсан /Б эсвэл↓/ эсвэл Тогтвортой /Т эсвэл~/ гэсэн тэмдэглэгээг хийнэ.

3-Санхүүгийн үзүүлэлтийг ижил төстэй төлбөр хариуцагч бүлгийн эсвэл үйл ажиллагаа явуулах салбарын дундаж үзүүлэлттэй харьцуулж тусгах бөгөөд сүүлийн үеийн байдлаар дундаж үзүүлэлттэй харьцуулахад үзүүлэлт сайжирсан бол Сайжирсан /С эсвэл↑/, муудсан бол Муудсан /М эсвэл↓/ эсвэл онцын өөрчлөлтгүй бол Төстэй /Т эсвэл~/ гэсэн тэмдэглэгээг хийнэ. Салбар болон бүлгийн мэдээллийг эрх бүхий байгууллагаас салбар, бүлгийн талаарх тоон мэдээллийн товхимол, цахим мэдээллийн сан болон банкнаас дотооддоо цуглуулсан тоон мэдээллийг ашиглаж болох ба мэдээлэл авсан эх сурвалжаа тусгасан байна. Салбар, бүлгийн дундаж үзүүлэлтийн мэдээг, санхүүгийн үзүүлэлтийн хандлагын мэдээтэй нэгтгэн энэхүү хүснэгтэд хавсаргасан байна.

4- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3/; 23.4-т заасан тодорхойлолт.

Активын чанарын ангилал тогтоох үндсэн заавар: Дээрх хүснэгтэд хангалтгүй үнэлгээтэй буюу материаллаг түвшинд сөргөөр нөлөөлөх үзүүлэлтүүдэд банкны зүгээс үндэслэл, тайлбарыг харгалзах баганад тусгах ба хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлт нь активын чанарын нийт үнэлгээнд мэдэгдэхүйц эсвэл ихээхэн нөлөөлөл үзүүлэх боломж, эрсдэл байгаа эсэхийг тодорхой тусгасан байна. Шаардлагатай тохиолдолд үндэслэлээ нотлох танилцуулга, баримт, материалуудыг энэхүү хүснэгтэд хавсаргасан байна.

ХАВСРАЛТ 6

**ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ОЛГОСОН АКТИВЫГ ЧАНАРЫН  
ҮЗҮҮЛЭЛТЭЭР АНГИЛАХАД ХАРГАЛЗАХ  
ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ЖАГСААЛТ**

Дд	Үнэлгээний хүчин зүйлс	Үнэлгээ	Хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлтийн тайлбар*	Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**
1.	Активын хувийн хэргийн бүрдэл	Тийм/үгүй		
1.1.	Тухайн банкны мөрдөж байгаа догоод дүрэм, журмын дагуу шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр бий эсэх, төлбөр хариуцагчийн талаарх банкны дүгнэлт			
1.2.	Актив олгохыг хүссэн өргөдөл			
1.3.	Активын төлбөр болон холбоотой бусад гэрээ, гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт			
1.4.	Төлбөр хариуцагчийн үүсгэн байгуулсан гэрээ, дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ			
1.5.	Санхүүгийн тайлан			
1.6.	Барьцаа хөрөнгө			
	1.6.1. Тодорхойлолт <sup>4</sup>			
	1.6.2. Үнэлгээний баримт бичиг			
	1.6.3. Үл хөдлөх хөрөнгө бол улсын бүртгэлийн гэрчилгээ			
	1.6.4. Шалгасан баримт			
	1.6.5. Гадны харааг бус үнэлгээ			
1.7.	Баглан даалт болон барьцааны гэрээ			
1.8.	Активээр санхүүжигдэх төсөл			

1.8.1.	Шаардлагатай бол эрх бүхий байгууллагаар баглуулсан эсэх								
1.8.2.	Үйл ажиллагааны талаарх баримт бичиг								
1.8.3.	Төслийн санхүүгийн тооцоолол								
1.8.4.	Төсөлтэй холбоотой төлбөр тооцооны баримт бичиг								
1.8.5.	Төсөл болон төлөвлөсөн ажлын гүйцэтгэл								
1.8.6.	Холбогдох гэрээ								
1.9.	Активын ашиглалт шалгасан материал								
1.10.	Зээлийн мэдээллийн сан болон бусад эрх бүхий байгууллагуудын лавлагаа мэдээлэл								
1.11.	Банк төлбөр хариуцагчийн санхүүгийн байдлыг үнэлж, дүгнэхэд мэдээлэл хангалттай, аливаа томоохон хүндрэл учраагүй								Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**
2.	Төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтүүд								
2.1.	Төлбөрийн чадвар								
2.1.1.	Эргэлтийн хөрөнгө/Богино хугацааг өр төлбөр, түүний өөрчлөлт, ирээдүйн хандлага								
2.1.2.	(Мөнгөн хөрөнгө+Богино хугацааг хөрөнгө оруулалт+Авлага)/Богино хугацааг өр төлбөр, түүний өөрчлөлт, ирээдүйн хандлага								
2.1.3.	Үндсэн үйл ажиллагааны орлого/богино хугацааг өр төлбөр, өөрчлөлт, ирээдүйн хандлага								
2.2.	Ашигт ажиллагаа								
		Утга <sup>1</sup>	Δ% <sup>2</sup>	Бүлгийн дундаж <sup>3</sup>	Шалгуур үзүүлэлт бүрт тайлбар оруулах				

2.2.1.	Нийт ашиг /Нийт орлого, сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)							
2.2.2.	Нийт зардал/Нийт орлого, сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)							
2.2.3.	Активын өгөөж ROA, сүүлийн 3 жилийн хандлага (жил, хагас жилийн давтамжтай)							
2.2.4.	Эзэмшигчдийн өмчийн өгөөж ROE, сүүлийн 3 жилийн хандлага (жил, хагас жилийн давтамжтай)							
2.3.	Хөрөнгийн удирдлага							
2.3.1.	Авлагын эргэлт /сүүлийн 12 сарын дундаж/							
2.3.2.	Авлагын эргэлт /тайлант үеийн эцэст/							
2.3.3.	Бараа материалын эргэлт /сүүлийн 12 сарын дундаж/							
2.3.4.	Бараа, магериалын эргэлт /тайлант үеийн эцэст/							
2.3.5.	Үндсэн хөрөнгийн эргэлт /тайлант үеийн эцэст/							
2.3.6.	Нийт активын эргэлт /тайлант үеийн эцэст/							
2.4.	Хөшүүрэг ба өрийн үйлчилгээ							
2.4.1.	Татвар болон хүү төлөхийн өмнөх ашиг /Хүүгийн зардал сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)							
2.4.2.	Өр төлбөр/Хүүгийн, татварын болон элэгдлийн зардлыг хасахаас өмнөх ашиг, сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)							
2.4.3.	Эзний өмч /Хөрөнгө (leverage), өөрчлөлт, сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)							

3.	Бусад	Тийм/үгүй	Материалаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**
3.1.	Барьцаа болон баглан даалт		Шалгуур үзүүлэлт бүрт тайлбар оруулах
3.1.1.	Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хангалттай эсэх		
3.1.2.	Барьцаа хөрөнгийг худалдан борлуулж, активыг төлүүлэх эрх нь банкид бүрэн шилжиж ирсэн эсэх		
3.1.3.	Барьцаа хөрөнгийн үнэлгээний өөрчлөлт, сүүлийн 3 сарын хандлага		
3.1.4.	Төлбөр хариуцагч нь гуравдагч этгээдээс гаргасан баглан даалттай эсэх		
3.1.5.	Актив нь баглан даалттай бол баглан даагч нь төлбөрийн чадвар сайтай эсэх		
3.2.	Зээлийн мэдээллийн сангаас авсан мэдээлэл		
3.2.1.	Төлбөр хариуцагчийн түүх		
3.2.2.	Хугацаа хэтрэсэн ямарваа нэгэн активын болон бусад хэлбэрийн өртэй эсэх		
3.2.3.	Тухайн сард төлбөр хариуцагчийн аливаа нэг активын ангилал буурсан эсэх		
3.3.	Бусад мэдээлэл		

3.3.1.	Зэрэглэл тогтоогч байгууллагаас авсан мэдээлэл, төлбөр хариуцагчид болон төлбөр хариуцагчийн гаргасан үнэт цаасад оноосон зэрэглэлийн түүхэн болон одоогийн мэдээлэлд зэрэглэл бууруулах талаар тусгаагүй, сануулга /warning, negative watch/ гаргаагүй			
3.3.2.	Аудитын компаниас авсан мэдээлэл, хязгаарлалттай дүгнэлт гаргаагүй, удирдлагын захидалд дурдсан анхаарах зүйлс нь төлбөр хариуцагчид материаллаг байдлаар сөргөөр нөлөөлөхөөргүй			
3.3.3.	Бусад төр, хууль хяналтын эрх бүхий болон төрийн бус байгууллагаас авсан лавлагаанд төлбөр хариуцагчийн талаар сөрөг мэдээлэл агуулаагүй			
3.3.4.	Эдийн засгийн нөхцөл байдал, төлбөр хариуцагчийн үйл ажиллагаа эрхэлж байгаа салбарын нөхцөл байдал төлбөр хариуцагчийн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлж байгаа, ирээдүйд нөлөөлөх хандлага эерэг			
3.3.5.	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад сувгаар төлбөр хариуцагчийн нэр хүнд болон санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхөөр мэдээлэл цацагдаагүй			
3.3.6.	Төлбөр хариуцагчтай холбоотой үүсэх активын эрсдэлийг бууруулах аливаа даатгалд хамрагдсан эсэх			
3.3.7.	Төлбөр хариуцагчийн талаар банкнд төвлөрүүлсэн дотоод мэдээлэлд одоо болон ирээдүйд гарах зээлийн эрсдэл байхгүй			

**Тайлбар:**

\*- Үнэлгээний хүснэгтээс зөвхөн хангалтгүй үнэлгээ авсан үзүүлэлтэд тайлбар бичих

\*\* - Чанарын ангилалд мэдэгдэхүйц өөрчлөлт орохоор байгаа талаар үндэслэл, тайлбарыг бичиж, шаардлагагай баримт материалыг хавсаргана.

\*\*\*-Холбогдох төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтийг 1-2 жил болон мэдээллийн хүрэлцээгэй байдлаас шалтгаалан түүнээс дээш жилийн хугацаатайгаар, сар, улирал, жилийн давгамжтайгаар нэгтгэн боловсруулж энэхүү хүснэгтэд хавсаргах бөгөөд үзүүлэлтийг тогтмол шинэчилнэ.

1-Санхүүгийн үзүүлэлтийн тайлант хугацааны утгыг тусгана.

2-Санхүүгийн үзүүлэлтийн өмнөх хугацааны хандлагыг тусгах бөгөөд сүүлийн үеийн байдлаар Өссөн /Ө эсвэл↑/, Буурсан /Б эсвэл↓/ эсвэл Тогтвортой /Т эсвэл ~/ гэсэн тэмдэглэгээг хийнэ.

3-Санхүүгийн үзүүлэлтийг ижил төстэй төлбөр хариуцагч бүлгийн эсвэл үйл ажиллагаа явуулах салбарын дундаж үзүүлэлттэй харьцуулж тусгах бөгөөд сүүлийн үеийн байдлаар дундаж үзүүлэлттэй харьцуулахад үзүүлэлт сайжирсан бол Сайжирсан /С эсвэл↑/, муудсан бол Муудсан /М эсвэл↓/ эсвэл онцын өөрчлөлтгүй бол Төстэй /Т эсвэл ~/ гэсэн тэмдэглэгээг хийнэ. Салбар болон бүлгийн мэдээллийг эрх бүхий байгууллагаас салбар, бүлгийн талаарх тоон мэдээллийн товхимол, цахим мэдээллийн сан болон банкнаас дотооддоо цуглуулсан тоон мэдээллийг ашиглаж болох ба мэдээлэл авсан эх сурвалжаа тусгасан байна. Салбар, бүлгийн дундаж үзүүлэлтийн мэдээг, санхүүгийн үзүүлэлтийн хандлагын мэдээтэй нэгтгэн энэхүү хүснэгтэд хавсаргасан байна.

4- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3/; 23.4-т заасан тодорхойлолт.

Активын чанарын ангилал тогтоох үндсэн заавар: Дээрх хүснэгтэд хангалтгүй үнэлгээтэй буюу материаллаг түвшинд сөргөөр нөлөөлөх үзүүлэлтүүдэд банкны зүгээс үндэслэл, тайлбарыг харгалзах баганад тусгах ба хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлт нь активын чанарын нийт үнэлгээнд мэдэгдэхүйц эсвэл ихээхэн нөлөөлөл үзүүлэх боломж, эрсдэл байгаа эсэхийг тодорхой тусгасан байна. Шаардлагатай тохиолдолд үндэслэлээ нотлох танилцуулга, баримт, материалуудыг энэхүү хүснэгтэд хавсаргасан байна.